



unesco

Соёлын үнэт зүйлийг хамгаалах нь

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ГАРЫН АВЛАГА



Соёлын үнэт зүйлийг хамгаалах нь

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ГАРЫН АВЛАГА

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (Фонтенуа, 75352 Парис хот 07 SP, Франц Улс)

© ЮНЕСКО, 2023

ISBN: 978-92-3-000189-6



Энэхүү хэвлэлийг Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) лицензийн дагуу Нээлттэй хандалтад байршуулсан болно (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo>). Энэхүү хэвлэлийн агуулгыг ашигласнаар хэрэглэгчид ЮНЕСКО-ийн нээлттэй хандалтын сан <https://en.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en> ашиглах нөхцөлийг дагаж мөрдөхөө хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Гарчиг: Protection of cultural property: military manual. Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (Фонтенуа, 75352 Парис хот 07 SP, Франц Улс), болон Хүмүүнлэгийн эрх зүйн олон улсын х үрээлэн (Вилла Ормонд, К.со Каваллотти 113, 18038 Санремо, Итали)-гээс 2016 онд эрхлэн гаргав

Энэхүү хэвлэлд ашигласан тэмдэглэгээ болон танилцуулсан материал нь бүхэлдээ аль нэг улс орон, нутаг дэвсгэр, хот, газар нутаг, түүний эрх баригчдын эрх зүйн байдлын талаар болон тэдгээрийн хил хязгаар, хилийн зурвасыг ялган зааглах талаар ЮНЕСКО-ийн ямар нэгэн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Энэхүү хэвлэлд илэрхийлсэн санаа, үзэл бодол нь зохиогчдын байр суурь бөгөөд ЮНЕСКО-ийн байр суур, бодлогыг тусгаагүй буюу тус байгууллага үүрэг хүлээхгүй.

Зохиогчид: Рожер О'Киф, Камилла Перон, Тофиг Мусаев, Жианлука Феррари

График дизайн, Хавтасны дизайн: MBE - MAIL BOXES ETC 205 Итали Улс, Санремо хот, Хүмүүнлэгийн эрх зүйн олон улсын хүрээлэн

Орчуулсан ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс.

Эх бэлтгэл: “Мөнхийн үсэг” ХХК

Монгол Улсад хэвлэв.

Зохиогчид

Рожер О'Киф

Их Британий Лондонгийн их сургуулийн коллеж

Камилла Перон

Бүгд Найрамдах Франц Улсын Батлан хамгаалах яам

Тофиг Мусаев

Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гадаад хэргийн яам

Жианлука Феррари

Бүгд Найрамдах Итали Улсын Соёлын үнэт зүйлийг
хамгаалах Карабиниери төв

АГУУЛГА

I. ОРШИЛ	11
A. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО	11
Б. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ НЬ ЦЭРГИЙН ХҮЧИНД АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОЛОХ НЬ	11
В. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ДҮРЭМ	12
(i) Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль (ЗМТХ)	12
(a) 1954 оны Гаагийн Конвенц, түүний I, II Протокол	13
(b) 1949 оны Женевийн Конвенцын нэмэлт 1977 оны протоколууд	13
(v) Зэвсэгт мөргөлдөөний тухай олон улсын заншлын эрх зүй	13
(ii) Олон улсын эрүүгийн эрх зүй (ОУЭЭЗ)	14
(a) Дайны гэмт хэрэг	14
(b) Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг	15
(iii) Олон улсын хүний эрхийн хууль (ОУХЭХ)	15
(iv) Дэлхийн Өвийн Конвенц	16
(v) 1970 оны ЮНЕСКО-ийн Конвенц	16
(vi) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолууд	17
(vii) НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын бюллетень 1999/13	18
(viii) Бүс нутгийн зохицуулалт	19
Г. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛСАН ЦЭРЭГ АРМИЙН ШИЛДЭГ ТУРШЛАГА	19
Д. ХОЛБОГДОХ ДҮРМИЙГ ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ	19
Е. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХАД ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ҮҮРЭГ	20
II. “СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ”-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ	22
III. БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ	25
A. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЗААВАРЧИЛГАА	25
Б. ЦЭРГИЙН СУРГАЛТ	26
В. ЦЭРГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНУУД	28
IV. ЦЭРГИЙН ДАЙСАГНАСАН АЖИЛЛАГААНЫ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ	30
A. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЯЛГАН ТОДОРХОЙЛОХ	30

Б. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ОНИЛГОО	32
(i) Соёлын үнэт зүйлийг довтолгооны объект болгох	33
(a) Ерөнхий заалт	33
(b) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн хувьд баримтлах тусгай заалт	37
(c) Соёлын үнэт зүйлийг тээвэрлэх тусгай заалт	38
(ii) Цэргийн цохилт өгөх үеэр соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учруулах	39
В. ӨӨРИЙН ХЯНАЛТАД БАЙГАА СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ УСТГАХ, ХОХИРОЛ УЧРУУЛАХ	42
(i) Ерөнхий заалт	42
(ii) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн тусгай заалт	43
Г. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ БУЮУ ТҮҮНИЙ ОРЧНЫГ АШИГЛАХ	43
(i) Ерөнхий заалт	43
(ii) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн тусгай заалт	45
Д. ЦЭРГИЙН АЖИЛЛАГААНААС ҮҮДЭН СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛД АЮУЛ УЧРАХ	46
Е. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХУУЛЬ БУСААР ЭЗЭМШИХ, САНААТАЙГААР ХОХИРОЛ УЧРУУЛАХ	48
(i) Цэргийн хүчнийхэн	48
(ii) Бусад талууд	49
Ё. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАРИУ БАРИХ БАЙДЛААР АШИГЛАХ	50
V. ЗЭВСЭГЛЭН ДОВТЛОХ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ	51
A. ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЭХЛЭХ, ДУУСГАХ	51
Б. ЭЗЛЭГЧ ГҮРНИЙ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ	52
В. ЦЭРГИЙН ДАЙСАГНАСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕЭР ХҮЛЭЭХ ҮҮРЭГТЭЙ ИЖИЛ БОЛОХ НЬ	53
(i) Соёлын үнэт зүйлийг тодорхойлох	54
(ii) Соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах	54
(iii) Соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын газрыг ашиглах	55
(iv) Соёлын үнэт зүйлийг завших, эвдэн сүйтгэх	56
(a) Цэргийн хүчнийхэн өөрсдөө завших, эвдэн сүйтгэх	56
(b) Бусад талууд завших, эвдэн сүйтгэх	
Г. ЦЭРГИЙН ХҮЧЭЭР ЭЗЛЭН ТҮРЭМГИЙЛЭЧДИЙН ХҮЛЭЭХ ОНЦГОЙ ҮҮРЭГ	59
(i) Эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэх	59
(ii) Зарим үйлдлийг хориглох, урьдчилан сэргийлэх	60
(a) Соёлын үнэт зүйлийг хууль бус экспортлох, нүүлгэн шилжүүлэх, өмчлөх эрхийг шилжүүлэх	61

(b) Археологийн малтлага	62
(c) Соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөх	63
VI. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ	65
A. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЯЛГАН ТАНИХ АЖЛЫГ ХӨНГӨВЧЛӨХ ЗОРИЛГООР ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ	65
(i) Соёлын үнэт зүйл	65
(ii) Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйл	66
(iii) Соёлын үнэт зүйлийг тээвэрлэх	66
(iv) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл	67
B. ЯЛГАХ ТЭМДЭГ БОЛОН БУСАД ТЭМДЭГЛЭГЭЭГ БУРУУ АШИГЛАХ	67
VII. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ АЖИЛТАН	68
A. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ ХАМГААЛАХ АЖИЛТНЫГ ХҮНДЛЭХ	68
B. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ АЖИЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ	68
VIII. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХАД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ	69
A. ТУСЛАМЖ, ЦЭРГИЙН ХҮЧ	69
B. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ	69
(i) ЮНЕСКО	69
(ii) Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хороо	70
(iii) Олон улсын Улаан загалмайн хороо (ОУУЗХ)	70
(iv) Төрийн бус байгууллага	71
B. УЛС ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУСЛАМЖ	71
Ё. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАРИУ БАРИХ БАЙДЛААР АШИГЛАХ	75
ХАВСРАЛТ I ХУРААНГУЙ	
ХАВСРАЛТ II БҮРТГЭЛ, ЖАГСААЛТ	
ХАВСРАЛТ III ТЭМДГҮҮД	
ХАВСРАЛТ IV ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕИЙН СОЁЛЫН ӨМЧИЙ ХАМГААЛАХ ТУХАЙ ЭРҮҮГИЙН ХЭРГҮҮД	

ҮГСИЙН ТОВЧЛОЛУУД

CCAAA	Coordinating Council of Audiovisual Archives Associations	Аудио-визуал архивын холбоодын зохицуулах зөвлөл
CDE	Collateral Damage Estimation	Дагалдах хохирол
IAC	International Armed Conflict	Олон улсын зэвсэгт мөргөлдөөн
ICA	International Council on Archives	Архивын олон улсын зөвлөл
ICBS	International Committee of the Blue Shield	Цэнхэр бамбайн олон улсын хороо
ICC	International Criminal Court	Олон улсын эрүүгийн шүүх
ICL	International Criminal Law	Олон улсын эрүүгийн эрх зүй
ICOM	International Council of Museums	Олон улсын музейн зөвлөл
ICOMOS	International Council on Monuments and Sites	Хөшөө дурсгал, дурсгалт газруудын олон улсын зөвлөл
ICRC	International Committee of the Red Cross	Олон улсын Улаан загалмайн хороо
ICTY	International Criminal Tribunal for the former Yugoslavia	Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх
IFLA	International Federation of Library Associations and Institutions	Олон улсын номын сангийн холбоо
IHL	International Humanitarian Law	Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй
IHRL	International Human Rights Law	Олон улсын хүний эрхийн хууль
INTERPOL	International Criminal Police Organization	Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага
LOAC	Law of Armed Conflict	Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль
MFA&A	Monuments, Fine Arts and Archives	Хөшөө дурсгал, дүрслэх урлаг, архивын

MINUSMA	United Nations Multidimensional Integrated Stabilization Mission in Mali	Мали дахь НҮБ-ын Олон хэмжээт нэгдсэн тогтворжуулах ажиллагаа
NATO	North Atlantic Treaty Organization	Умард атлантын гэрээний байгууллага
NIAC	Non-International Armed Conflict	Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн
NGO	Non-Governmental Organization	Төрийн бус байгууллага
NSL	No-Strike List	Цохилт өгөхгүй байх объектын жагсаалт
OMG	Office of Military Government	Цэргийн засгийн газрын алба
ROE	Rules of Engagement	Оролцооны дүрэм
RTL	Restricted-Target List	Хязгаарлагдмал зорилтот жагсаалт
SBAH	State Board of Antiquities and Heritage	Улсын эртний дурсгал, өвийн зөвлөл
SHAEF	Supreme Headquarters Allied Expeditionary Forces	Холбоотны экспедицийн дээд штаб
SPINs	Special Instructions	Тусгай заавар
UN	United Nations	Нэгдсэн Үндэстний байгууллага
UNESCO	United Nations Educational, Scientific and Cultural Organization	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
UNOSAT	United Nations Operational Satellite	НҮБ-ын үйл ажиллагааны хиймэл дагуул
UNIFIL	United Nations Interim Force in Lebanon	НҮБ-ын Ливан дахь түр хүчин
UNITAR	United Nations Institute for Training and Research	НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн
USCBS	United States Committee of the Blue Shield	АНУ-ын Цэнхэр бамбайн хороо

ӨМНӨХ ҮГ

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалахад зэвсэгт хүчний зүгээс анхаарал хандуулах хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа өнөө цагт энэхүү гарын авлага хэвлэгдэж байгаа нь цаг үеэ олсон хэрэг болж байна.

Сүүлийн арваад жилийн хугацаанд дайны тэргүүн шугамд соёлын өв өртөх, дайны уршгаас үүдэлтэй дагалдах хохирол амсах, дайсагнагч талууд соёлын объектыг онилох үйлдэл хийх нь эргээд хүчирхийлэл, үзэн ядалт, өс хонзонгийн сэдэл болох боллоо. Энэ гамшиг урт хугацааны туршид нийгмийг донсолгосон хэрэг болж, энх тайван байдлыг үгүйсгэхийн зэрэгцээ дайсагнасан байдлыг эцэс болгож эвлэрэлд хүрэхэд саад учруулсаар байна. Сүүлийн үед Мали, Ливи, Йемен, Ирак, Сири улсад болсон мөргөлдөөнүүд соёлын өвийг хамгаалах нь хүний амь насыг хамгаалахтай салшгүй холбоотой байдгийг баталж байна. Соёлын өвийг устгах нь олон улсад соёлын олон янз байдлыг үгүй хийхийг зорьсон соёлын цэвэрлэх стратегийн салшгүй нэг хэсэг болсон. Энэ нөхцөлд цэргийн хүчний зүгээс энх тайван, аюулгүй байдлыг тогтоох тогтвортой стратегийн салшгүй хэсэг болох соёлын өвийг хамгаалах асуудлыг анхаарлын төвд авч, үйл ажиллагааны горим, арга зам, ур чадвараа өөрчлөх шаардлагатай тулгарч байна.

Сүүлийн 70 жилийн хугацаанд ЮНЕСКО гишүүн орнууддаа эдгээр асуудлыг шийдвэрлэхэд туслахын тулд стандарт боловсруулсан. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенц нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалахтай холбоотой бүхий л асуудлыг дангаар нь авч үзсэн олон улсын гэрээний түвшинд батлагдсан анхны баримт бичиг болохын хувьд соёлын үнэт зүйлсийг хадгалах, хамгаалахад чиглэсэн дараа дараагийн гэрээ хэлэлцээрүүдэд ихээхэн нөлөө үзүүлсэн. 1990-ээд оны мөргөлдөөний дараа тус конвенцыг 1999 оны 3-р сард баталсан II Протоколоор улам бэхжүүлсэн бөгөөд протокол нь конвенцыг бодитоор хэрэгжүүлэх шинэ механизмаар дамжуулан зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалдаг. Мөн Соёлын үнэт зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой 1970 оны ЮНЕСКО-ийн Конвенц, Хулгайлагдсан буюу хууль бусаар экспортлогдсон соёлын объектын тухай 1995 оны UNIDROIT Конвенц, түүнчлэн 1972 оны ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн Конвенц зэрэг бусад баримт бичгүүдийг батлан гаргажээ. Хамгийн сүүлд 2015 онд ЮНЕСКО-ийн гишүүн орнууд Соёлыг хамгаалах ЮНЕСКО-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх бүрэн хэмжээний стратегийг баталсан. Мали улсын

Тимбукту дахь түрэмгийлэгчдийн устгасан бунхнуудыг сэргээн босгох, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн албан хаагчдыг сургах (MINUSMA) болон Ахмад Аль Факи Аль Махдиг олон улсын эрүүгийн шүүхээс дайны гэмт хэрэг үйлдсэн хэргээр шийтгэсэн зэрэг жишээ нь ЮНЕСКО энэхүү шинэ стратегийг шийдвэртэй хэрэгжүүлж буйг нотлон харуулж байна.

Конвенц болон бусад хууль эрх зүйн баримт бичгийг батлах нь зайлшгүй шаардлагатай боловч улам бүр газар авч буй асуудлын шалтгаант нөхцөл байдлыг шийдвэрлэхэд хангалттай арга зам болж чадахгүй билээ. Мөргөлдөөний тэргүүн фронтод соёл байсаар байгаа учраас энх тайван цагт ч мөн соёлын асуудалд бид нэн тэргүүнд анхаарах ёстой. Иймээс өв соёлыг хамгаалах уламжлалт аргыг өргөжүүлэхийн зэрэгцээ дахин шинээр бодож үзэх хэрэгтэй болоод байна. Бид бүх оролцогч талуудын бүрэн эрх, онцгой эрхийг хүндэтгэхийн зэрэгцээ соёл, аюулгүй байдал, хүмүүнлэгийн асуудлын хоорондын холбоо хамаарлыг тодорхой тогтоох хэрэгтэй. Зэвсэгт хүчин үүнд онцгой анхаарч, хүнд хэцүү нөхцөлд соёлын өвийг хамгаалах чадвартай байх ёстой. Энэхүү гарын авлага нь 1954 оны Гаагийн Конвенц болон түүний хоёрдугаар протоколын практик хэрэгжилтийг тоймлон харуулах зорилготой бөгөөд ингэснээр гишүүн орнууд ЮНЕСКО-той хамтран ажиллах боломж бүрдэхийн зэрэгцээ соёлын үнэт зүйлийг хамгаалах заавар, зааварчилгааг цэргийн удирдамжид тусгах юм.

Энэ бүхнийг зэвсэгт хүчинд ямарваа дарамт шахалт биш харин аюулгүй байдлын урт хугацааны зорилт, ялангуяа нийгмийн эв нэгдэл, эвлэрлийг бэхжүүлэх арга хэрэгсэл гэж үзвэл зохистой. Уг гарын авлага цаашдын цэргийн ажиллагаанд үр нөлөөтэй байна гэдэгт итгэлтэй байна.

Санремо дахь Хүмүүнлэгийн эрх зүйн олон улсын хүрээлэнд энэхүү гарын авлагыг эрхлэн гаргахад оруулсан хувь нэмэрт нь талархахын сацуу Азербайжаны Засгийн газар харамгүй тусламж үзүүлсэнд гүнээ талархаж байна. Мөн энэхүү гарын авлага зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад учирдаг элдэв сорилтод хариу арга хэмжээ авахад цэргийн хүчний чадавхыг нэмэгдүүлэхэд хувь нэмэртэй хэмээн үзэж үнэлж бүх засгийн газар ашиглаасай хэмээн чин сэтгэлээсээ хүсэж байна. Энэ бол дан ганц соёлын асуудлаар хязгаарлагдахгүй, аюулгүй байдлын зайлшгүй хэсэг билээ.

Ирина Бокова
ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал (2009-2017)

ӨМНӨХ ҮГ

ЮНЕСКО-ийн ивээл дор хэвлэгдсэн энэхүү цэргийн гарын авлагыг Хүмүүнлэгийн эрх зүйн олон улсын хүрээлэн ихээхэн талархан хүлээн авч байгаа бөгөөд уг гарын авлага зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг олон улсын хэмжээнд хамгаалах дүрэм журмыг илүү бодитой түгээн дэлгэрүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал хэрэгсэл болох нь дамжиггүй.

Сүүлийн жилүүдэд зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйл устах явдал гаарч, хүн төрөлхтний соёлын өвийг хамгаалахад чиглэсэн олон улсын эрх зүйн хэм хэмжээг бүдүүлгээр зөрчсөн үйлдэл удаа дараа гараад байна. Эдгээр гэмт хэрэг Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенц, түүний 1999 оны II Протокол, соёлын үнэт зүйлийг хамгаалах олон улсад дагаж мөрдөх нийтлэг дэг журмын хэрэгжилтийг хангах зайлшгүй шаардлага тулгараад байгааг харуулж байна.

Хүмүүнлэгийн эрх зүйн олон улсын хүрээлэн нь Итали улсын Санремо хотод төвтэй, Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн сургалт, судалгаагаар дагнасан олон улсад нэр хүндтэй, бие даасан байгууллага бөгөөд энэхүү чухал бөгөөд ээдрээтэй асуудалд анхаарлаа хандуулсаар ирсэн. 1984 онд тус хүрээлэнгээс 1954 оны Гаагийн конвенцын 30 жилийн ойг тохиолдуулан симпозиум, 1986 онд соёлын өмчийг хамгаалах талаар олон улсын эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн байлдааны хэрэгсэлтэй холбоотой техникийн дэвшилтэй уялдуулах нь” сэдэвт семинар зохион байгуулсан. Энэхүү уламжлалаа сахиж саяхан буюу 2009 онд тус хүрээлэнгээс 1954 оны Гаагийн конвенцын 1999 оны хоёрдугаар протоколын 10 жилийн ойн хүрээнд ЮНЕСКО-ийн дэмжлэгтэйгээр “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах олон улсын дэглэм” сэдэвт семинар зохион байгуулсан. Энэ семинарын зорилго нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлыг хамгаалах олон улсын дүрмийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэний болон цэргийн байгууллагын хооронд туршлага хуваалцах, мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэхэд оршиж байв.

Тус хүрээлэнгээс тодорхой сэдвээр сургалт зохион байгуулдаг нь энэ салбарт тавьж буй хүчин чармайлтын нэг илрэл юм. Тус хүрээлэн соёлын үнэт зүйлийг хамгаалах олон улсын үйл ажиллагааны төрөл бүрийн зарчим, дүрмийн талаар ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор олон улсын төрийн албан хаагчид, цэргийн мэргэжилтнүүдэд зориулан олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн сургалтыг жил бүр зохион байгуулдаг.

Санремогийн хүрээлэн уг тулгамдсан асуудлын талаар олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг түгээн дэлгэрүүлэх, сургахад чухал хувь нэмэр оруулах үүднээс энэхүү цэргийн гарын авлагыг хэвлүүлсэндээ баяртай байна. Цаашид ЮНЕСКО-той энэ чиглэлээр хамтран ажиллах болно.

Фаусто Покар
Хүмүүнлэгийн эрх зүйн олон улсын хүрээлэнгийн захирал

I ОРШИЛ

A. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО

1. Зэвсэгт мөргөлдөөний үед олон улсын эрх зүйн хэм хэмжээнд заасны дагуу соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор зэвсэгт хүчний зүгээс авах арга хэмжээг энэхүү гарын авлагад тусгасан болно. Уг гарын авлагад цэргийн ажиллагаатай холбоотой төр, иргэний хүлээх үүргийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт болон командлалын хийгээд хуурай зам, тэнгисийн болон агаарын цэргийн ажиллагааны өөр өөр үе шатуудад авч хэрэгжүүлэх шилдэг туршлагын талаарх саналуудыг нэгтгэн орууллаа.
2. Тус гарын авлагад зэвсэгт мөргөлдөөний тухай олон улсын эрх зүйгээр зохицуулагдаагүй цэргийн ажиллагаа, тухайлбал байгалийн гамшигтай холбоотой цэргийн тусламж, дотоодын эмх замбараагүй байдал, хурцадмал байдлын үед цэргийн хүчийг байршуулах зэрэг ажиллагааны талаар тусгаагүй болно. Гарын авлагад тусгагдсан зэвсэгт мөргөлдөөнд бэлтгэх болон зэвсэгт мөргөлдөөний үеийн цэргийн ажиллагаатай холбоотой зарим агуулгыг бусад нөхцөлд ашиглах боломжтой байж болох ч уг гарын авлага нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд соёлын үнэт зүйлийг хамгаалах асуудлыг хамгийн ихээр чухалчлан авч үзсэн болно.

B. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ НЬ ЦЭРГИЙН ХҮЧИНД АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОЛОХ НЬ

3. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах нь цэргийн хүчинд ач холбогдолтой гэх ойлголт нь онолын, стратегийн, эрх зүйн шинжтэй.
4. Онолын хувьд соёлын үнэт зүйл нь хувь хүн, хамт олон, ард түмэн, нийт хүн төрөлхтний соёлын өвөрмөц байдлын амин чухал хэсэг болдог. Соёлын үнэт зүйл нь хүний үл өөрчлөгдөх төлөв, хүн төрөлхтний бүтээлч суу ухаан, олон талт ялгаатай байдал, хүн төрөлхтний ой санамжийн биет

илэрхийлэл юм. Соёлын үнэт зүйлийг хадгалах нь хүний сайн сайхан, цэцэглэн хөгжихөд зайлшгүй шаардлагатай.

- 5.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах зайлшгүй шаардлага нь стратегийн шинжтэй. Зэвсэгт хүчин, ялангуяа гаднын улсын зэвсэгт хүчин соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах, түүнчлэн цэргийн хүчний хараа хамгаалалт хангалтгүй байснаас үүдэн бусад талууд тонон дээрэмдэх зэрэг урьдчилан сэргүүлэх, зайлсхийх боломжтой соёлын үнэт зүйлийг устгах, гэмтээх үйлдэл нь цэргийн хүчний үүргээ амжилттай гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлдөг. Эдгээр үйлдэл нь орон нутгийн иргэдийн дайсагналыг өдөөж, суртал ухуулгын зэвсгийн бай болоход хүргээд зогсохгүй ялалтын төлөөх дотоодын фронт болон холбоотнуудын дэмжлэг туслалцааг сулруулахын сацуу дээрэм тонуулаас урьдчилан сэргийлж, таслан зогсоож чадаагүй тохиолдолд төрийн бус зэвсэгт бүлэглэлүүд болон террорист байгууллагуудад орлогын эх үүсвэрийг нээж өгөх магадлал бий болдог. Түүнчлэн зөрчилдөөнийг улам хурцатгаж, энх тайвныг эргэн тогтоох, эвлэрэх явцыг төвөгтэй болгодог. Харин зэвсэгт мөргөлдөөний хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх замаар соёлын үнэт зүйлийг эвдрэн сүйдэх, шамшигдахаас сэргийлэн хамгаалж, анхаарал тавих нь стратегийн коммуникацийн үр дүнтэй хэсэг болж чадна. Энэ нь хүмүүсийн үзэл бодол, итгэл үнэмшлийг өөрчлөх хүчтэй.
- 6.** Хуулийн үүднээс авч үзвэл, зэвсэгт мөргөлдөөний үед олон улсын эрх зүйд заасан бүх арга хэмжээг авч соёлын үнэт зүйлийг хамгаалж чадаагүй нөхцөлд юуны өмнө тухайн зэвсэгт хүчин төр засгаа олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хуулийн хариуцлага хүлээх нөхцөлд хүргэж болзошгүй. Зэвсэгт мөргөлдөөний үед түүх, урлаг, археологийн ач холбогдол бүхий эд зүйл, барилга байгууламж, дурсгалт газруудыг устгасан, хохирол учруулсан, завшсан хэргээр өөр улс орон эсвэл хувь хүнд нөхөн төлбөр төлөх шаардлагатай байдалд орж болзошгүй юм.

Дэлхийн хоёр дайнд ялагдсан хэд хэдэн улс соёлын үнэт зүйлийг хууль бусаар устгаж, дээрэмдсэний хариуцлагыг энх тайвны гэрээнд заасны дагуу материаллаг байдлаар нөхөн төлөх хариуцлага хүлээжээ. Жишээлбэл, Версалийн гэрээний 247-р зүйлд зааснаар Германы талд "Лувенийн их сургуульд ... Германы довтолгооны үед галд шатаж утсан гар бичмэл, эртний хэвлэл ном, хэвлэмэл ном, газрын зураг, цуглуулгын тоо хэмжээ, үнэ цэнтэй дүйцэхүйц хэмжээний эд зүйлсээр тохижилт хийж өгөх шаардлага"-ыг тавьжээ. Иракийн зэвсэгт хүчний дайралтын үеэр Кувейтийн иргэний хувийн эзэмшлийн Исламын урлаг, ховор номын цуглуулаг устаж, дээрэмд өртсөн бөгөөд 1998 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нөхөн олговрын Комиссоос уг иргэнд 19,000,000 орчим ам. долларын нөхөн төлбөр олгох шийдвэрийг гаргаж, НҮБ-ын Аюулгүй Байдлын зөвлөлөөс шаардсаны дагуу Ирак Улс уг төлбөрийг төлж барагдуулж байв. Эритрей болон Этиоп хоёр улсын хооронд болсон дайны үеэр Этиопийн цэргүүд Эритрейн эртний дурсгалд санаатайгаар учруулсан хохирлын төлбөрт 50,000 ам.доллар төлөхийг 2009 онд Эритрейн Этиопын нэхэмжлэлийн комисс Этиоп улсаас шаарджээ.

Нэмж дурдахад, зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг санаатайгаар устгах, хохирол учруулах, завших нь дүрэмт хувцастай хүн бүрт шууд хамааралтай юм. Учир нь гэм буруутай нь тогтоогдвол дайны гэмт хэрэг, тэр бүү хэл хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр ял хүлээхэд хүргэж болзошгүй.

Нюрнбергийн Олон улсын цэргийн шүүхээс хэд хэдэн яллагдагчид эзлэгдсэн нутаг дэвсгэрт соёлын өвийг системтэйгээр устгаж, дээрэмдсэн хэрэгт гар бие оролцсон хэргээр шийтгэл оноожээ. Саяхан, хуучин Югославын Олон улсын эрүүгийн шүүхээс хэд хэдэн яллагдагч 1990-ээд онд Балканы хойгт болсон мөргөлдөөний үеэр соёлын дурсгалт газруудыг санаатайгаар устгасан, гэмтэл учруулсан хэргээр ял сонссон. Өдийг хүртэлх хугацаанд соёлын үнэт зүйлийг зориудаар устгасан хэргээр Олон улсын эрүүгийн шүүхээс оноосон нэг ялын гол шалтгаан нь байсан бөгөөд прокурор энэ төрлийн хэргийг цаашид шүүн хэлэлцэх боломжийг нэмэгдүүлэх сонирхолтой байгаагаар илэрхийлжээ. Соёлын үнэт зүйлийн эсрэг үйлдсэн дайны гэмт хэргийг мөрдөн байцаах ажил үндэсний хэмжээнд ч мөн хийгдэж байна.

Эд хөрөнгийг биечлэн сүйтгэсэн, гэмтээсэн, завшсан төдийгүй түүнийг устгах, хохирол учруулах, үрэгдүүлэхэд аливаа арга замаар санаатай оролцсон тохиолдолд гэм буруутан болдог. Мөн ийм төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд өөрийн эрх мэдлийн хүрээнд шаардлагатай, үндэслэлтэй бүх арга хэмжээг аваагүй, эсвэл мөрдөн байцаалтад оруулах, шаардлагатай бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад хүргүүлэх үүргээ санаатай эсвэл санамсаргүй байдлаар биелүүлээгүй цэргийн командлагч нар гэм буруутан болно.

С. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ДҮРЭМ

(i) Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль (ЗМТХ)

7. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах олон улсын гол хууль нь олон улсын хүмүүнлэгийн хууль гэгддэг. Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль болно. ЗМТХ-ийн зүйл заалтууд нь хэд хэдэн олон талт гэрээ, олон улсын заншлын эрх зүйд тусгалаа олсон байдаг.

(a) 1954 оны Гаагийн Конвенц, түүний I, II Протокол

8. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай конвенц (1954 оны Гаагийн Конвенц) болон 1954 онд батлагдсан тус Конвенцыг хэрэгжүүлэх тухай журам нь соёлын үнэт зүйлийг хамгаалах гэрээний эрх зүйн гол баримт бичиг юм. 1954 оны Конвенцод нэмэлт хоёр протокол дагалдах бөгөөд одоо I Протокол гэж нэрлэгддэг 1954 оны Протокол болон 1999 онд байгуулагдсан II Протокол орно. Энэ гурван гэрээ нь зэвсэгт мөргөлдөөн, цэргийн хүчээр эзлэх ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хамгаалах нарийвчилсан заалт бүхий олон улсын эрх зүйн зохицуулалт болдог. Энэхүү эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээний асуудлуудыг 1999 оны II Протоколыг хэрэгжүүлэх удирдамжид тодорхойлсон байдаг ба ингэхдээ Протоколд нэгдэн орсон талуудын уулзалтаар батлах, нэмэлт өөрчлөлт оруулах буюу заавал биелүүлэх албагүй байдлаар тодорхойлсон байна.

9. 1954 оны Гаагийн Конвенцод соёлын үнэт зүйлийг хамгаалах хоёр үе шаттай дэглэм тогтоосон. Үүний дийлэнх заалт нь 1-р зүйлд заасан “соёлын үнэт зүйл”-д хамаарах бүх объект, барилга байгууламж, дурсгалт газрыг хамгаалахад үйлчилдэг (§§44–49-р зүйлийг харах), харин цөөн хэдэн заалт нь зөвхөн “тусгай хамгаалалт” бүхий соёлын үнэт зүйлийн ангилалд хамаарна (§§50–52-р зүйлийг харах). 1999 оны II Протоколд

тусгай хамгаалалт бүхий гэдэг ангиллыг илүү өргөн хүрээтэй хамгаалалт болгон өөрчлөх үндсэн зорилгын үүднээс соёлын үнэт зүйлийн “өргөтгөсөн хамгаалалт” (§§53–55-р зүйлийг харах) хэмээх түвшнийг тодорхойлон заасан бөгөөд Конвенцын 1 дүгээр зүйлд заасан бүх соёлын үнэт зүйлийг Конвенц болон II Протоколд зааснаас гадна нэмэлт хамгаалалтад авах тухай зүйл заалтууд юм.

(б) 1949 оны Женевийн Конвенцын нэмэлт 1977 оны протоколууд

- 10.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай товч заалтуудыг 1949 оны 8-р сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцын Нэмэлт протоколын 53 дугаар зүйл, 1977 оны Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах (“Нэмэлт I протокол”) болон 1949 оны 8-р сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцын Нэмэлт протоколын 16-р зүйл, 1977 оны олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах (“Нэмэлт II протокол”) зэргээс харж болно. Нэмэлт I протоколын 53 дугаар зүйл, Нэмэлт II протоколын 16 дугаар зүйл аль аль нь 1954 оны Гаагийн Конвенц, холбогдох тохиолдолд 1954 оны Гаагийн Конвенцын 1999 II протоколын болон бусад холбогдох олон улсын баримт бичгийн заалттай зөрчилдөхгүй. Женевийн нормативтай зөрчилдсөн тохиолдолд Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах Гаагийн дэглэм тэргүүлэх байр суурьтай болохыг 1977 оны 6-р сарын 7-ны өдрийн Дипломат бага хурлаас баталсан 1974-1977 оны Женев дэх Зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэгдэх олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг дахин батлах, хөгжүүлэх тухай Дипломат бага хурлын 20(IV) тогтоолд дахин дурджээ.

(в) Зэвсэгт мөргөлдөөний тухай олон улсын заншлын эрх зүй

- 11.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах асуудлыг зохицуулах аливаа гэрээнд нэгдэн ороогүй улс орнууд ч зэвсэгт мөргөлдөөний тухай олон улсын заншлын хуулиар үүрэг хариуцлага хүлээнэ. Цаг хугацааны явцад улс орнуудад хууль болон хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг практикийг дагаж мөрдөх замаар олон улсын эрх зүйн хэм хэмжээ болсон “бичигдээгүй” гэж нэрлэж болохуйц хуулийн дагуу улс орнуудад үүрэг оногддог. Соёлын үнэт зүйлтэй холбоотой зэвсэгт мөргөлдөөний тухай энэхүү олон улсын заншлын хуулийн агуулга нь 1954 оны Гаагийн Конвенц болон дагалдах хоёр протоколд гэрээний хэлбэрээр тусгагдсан зүйл, заалтуудтай ижил төстэй байдаг.

(ii) Олон улсын эрүүгийн эрх зүй (ОУЭЭЗ)

12. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах олон улсын эрх зүйн хэм хэмжээний чухал эх сурвалж нь олон улсын эрүүгийн хууль (ОУЭЭЗ) бөгөөд олон улсын эрх зүйд хувь хүний эрүүгийн хариуцлага, түүнтэй холбоотой улс орнуудын эрх, үүргийг тусгасан байдаг.

(a) Дайны гэмт хэрэг

13. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хүрээнд Олон улсын эрүүгийн эрх зүйн хамгийн гол хууль бол дайны гэмт хэргийн тухай хууль юм. Заншлын болон гэрээнд үндэслэсэн олон улсын эрх зүйн дагуу гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийг зөрчсөн үйлдэл дайны гэмт хэрэг болдог. Дайны гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн улсын эсвэл өөр улсын цэргийн болон иргэний эрүүгийн шүүхээр шийтгэл хүлээлгэнэ. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн гэрээнд зааснаар Конвенцод нэгдэн орсон улс орнуудад эдгээр хуулийн үндсэн заалт нутаг дэвсгэрээс гадна ч мөн үйлчилнэ. Түүнчлэн дайны гэмт хэрэгт буруутгагдсан этгээдийг олон улсын эрүүгийн шүүхээс яллаж болно.

14. Олон улсын зэвсэгт мөргөлдөөн, цэргийн хүчээр эзлэх ажиллагаа, олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах, завших нь дайны гэмт хэрэгт тооцогдох бөгөөд гэм буруутныг үндэсний болон олон улсын шүүхээр шийтгэсэн тохиолдол элбэг байдаг. Нюрнбергийн Олон улсын цэргийн шүүх, хуучин Югославын асуудлаарх олон улсын эрүүгийн шүүх, Олон улсын эрүүгийн шүүх энэ төрлийн гэмт хэргийг шүүж байжээ (IV Хавсралтыг харах).

15. Зарим тохиолдолд холбогдох дайны гэмт хэргийг соёлын үнэт зүйлийн онцлог байдлаас хамааран тодорхойлж болно. Жишээлбэл, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмээр Олон улсын зэвсэгт мөргөлдөөн, олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үеэр “цэргийн зориулалттай биш ... урлаг, шинжлэх ухааны ... болон түүхэн дурсгалт газрууд зориудаар халдан довтлох”-д үйлдэгдсэн дайны гэмт хэргийн харьяаллыг Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлжээ. Соёлын үнэт зүйлийн эсрэг дайны гэмт хэргийг “дайны хэрэгцээ шаардлагаар зайлшгүй шаардсанаас бусад тохиолдолд эсрэг талын эд хөрөнгийг сүйтгэх, хураах”, “довтлон орсон хот эсвэл газар орныг дээрэмдсэн” бол Ромын дүрмийн Ерөнхий заалт ангиар хянан шийтгэх тохиолдол мөн гардаг.

16. 1954 оны Гаагийн Конвенцын 28 дугаар зүйлд зааснаар Конвенцод нэгдэн орсон улсууд “өөрсдийн байнгын шүүх эрх мэдлийнхээ хүрээнд

Конвенцыг зөрчсөн эсвэл зөрчихийг тушаасан этгээдийг аль улсын харьяат байхаас үл хамааран хэргийг хянан шийдэх, эрүүгийн болон сахилгын шийтгэл ногдуулах шаардлагатай бүх арга хэмжээг авах” үүрэгтэй. 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протоколын “Эрүүгийн хариуцлага ба шүүн таслах эрх”-ийн тухай 4-р бүлэгт Конвенц болон II Протоколыг зөрчихтэй холбоотой, Протоколыг “ноцтой зөрчсөн”-д тооцогдох хэд хэдэн үйлдлийг дайны гэмт хэрэгт холбогдохоор тодорхойлсон байдаг. Түүнчлэн Протоколыг ноцтой зөрчсөн хэрэгт сэжиглэгдэж буй хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд эрх зүйн онцгой үндэслэлээр яллах зэрэг Конвенцод нэгдэн орсон улс орнуудын хүлээх үүрэг хариуцлагыг нарийвчлан заасан. II Протоколын 21 дүгээр зүйлд Конвенцод нэгдэн орсон улс орнуудад үүрэг хүлээлгэхдээ Конвенцын 28 дугаар зүйлд заасанчлан соёлын үнэт зүйлийг Конвенц эсвэл Хоёрдугаар Протоколыг зөрчсөн байдлаар санаатайгаар ашиглах, мөн эзлэгдсэн нутаг дэвсгэрээс соёлын үнэт зүйлийг санаатайгаар хууль бусаар экспортлох, нүүлгэн шилжүүлэх, өмчлөх эрхийг шилжүүлэх зэргээр Конвенц, Протоколыг зөрчсөн явдлыг таслан зогсоох зорилгоор хуулийн болон захиргааны, сахилгын шаардлагатай арга хэмжээ авахыг даалгасан.

- 17.** Олон улсын эрх зүйн хүрээнд дайны гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь зөвхөн биеэр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд төдийгүй гэмт хэрэг үйлдүүлэхээр захиалга өгөх, туслах, өдөөх, бусад хэлбэрээр туслах зэргээр тухайн гэмт хэрэгт ямар нэгэн байдлаар оролцож санаатайгаар гэмт хэргийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн хүмүүст ч мөн хамаарна. Түүнчлэн, энэ төрлийн үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд өөрийн эрх мэдлийн хүрээнд шаардлагатай, үндэслэлтэй арга хэмжээг санаатай эсвэл санамсаргүй байдлаар аваагүй, эсвэл мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах зорилгоор эрх бүхий байгууллагад хүргүүлээгүй бол командлагч нарт дайны гэмт хэрэг үйлдсэн хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

(б) Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг

- 18.** Энгийн иргэдийн эсрэг өргөн хүрээтэй эсвэл системчилсэн довтолгооны хүрээнд соёлын үнэт зүйлийг ялгаварлан гадуурхсан үндэслэлээр санаатайгаар устгах нь хүн төрөлхтний эсрэг хавчлагын гэмт хэрэг болох бөгөөд ийм төрлийн гэмт хэрэг үйлдэгсдийг Нюрнбергийн шүүх болон Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх (ХЮОУЭШ)-ээр таслан шийтгэсэн байна. (IV хавсралтыг харах). ХЮОУЭШ-ийн хэд хэдэн шүүх хурлаас соёлын үнэт зүйлд хамруулах нийтийн болон хувийн өмчийг ялгаварлан гадуурхах үндэслэлээр дээрэмдэх үйлдлийг зохих нөхцөлд

хүн төрөлхтний эсрэг хавчлагын гэмт хэрэгт тооцон шүүж болно хэмээн шийдвэрлэжээ (IV Хавсралтыг харах).

- 19.** Дайны гэмт хэрэгтэй адил олон улсын эрх зүйн хүрээнд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь зөвхөн гэмт хэрэг биечлэн үйлдсэн этгээд төдийгүй гэмт хэрэгт ямар нэгэн хэлбэрээр санаатайгаар оролцсон хүмүүсийг, мөн хуулийн хүрээнд шаардлагатай, үндэслэл бүхий бүх арга хэмжээг санаатай болон санамсаргүй байдлаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эсвэл мөрдөн байцаах, яллах зорилгоор эрх бүхий байгууллагад хүргүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй цэргийн командлагч нарт хамаарна.

(iii) Олон улсын хүний эрхийн хууль (ОУХЭХ)

- 20.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад олон улсын хүний эрхийн хууль (ОУХЭХ)-ийн хэд хэдэн баримт бичиг хамааралтай. Хамгийн түгээмэл хэрэглэгдэх зохицуулалт нь 1966 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Гэрээний 15(1)(а) зүйл бөгөөд хүн бүр соёлын амьдралд оролцох эрхийг баталгаажуулах тухай заалт юм. Энэхүү эрхийг тунхагласан зорилго нь Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Гэрээний тайлбар 21-р зүйлд дурдсанчлан уг гэрээнд нэгдэн орсон улс орнуудад “дайны үе болон тайван цагт соёлын өвийн бүх хэлбэрийг хүндэтгэх, хамгаалах” үүрэг хүлээлгэхэд оршино.
- 21.** Гэрээний тайлбар 21-р зүйлд дурдсанчлан зэвсэгт мөргөлдөөний үед ОУХЭХ үйлчилсээр байдаг. Үүний зэрэгцээ, Олон улсын шүүхийн эрх зүйн үзэл номлолд зааснаас үзэхэд тухайн улс зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлтэй холбоотой ОУХЭХ-д заасан үүргээ биелүүлсэн эсэхийг ЗМХ-ийн холбогдох дүрэмд заасан стандартын дагуу үнэлнэ.
- 22.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай асуудлаар цэргийн хүчин ОУХЭХ-иар хүлээлгэсэн үүрэг хариуцлагыг тусгайлан хэрэгжүүлэх шаардлагатай биш, учир нь ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн холбогдох заалтыг дагаж мөрдснөөр ОУХЭХ-ийн холбогдох дүрмийн заалтыг биелүүлэх баталгаа болдог. Гэвч ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн холбогдох заалтыг зөрчих нь ОУХЭХ-ийг давхар зөрчсөн хэрэг болно.

(iv) Дэлхийн Өвийн Конвенц

- 23.** 2016 оны 12-р сарын байдлаар олон улсын хэмжээнд “онцлох түгээмэл үнэ цэн бүхий” 814 соёлын дурсгалт газрыг ЮНЕСКО-ийн ивээл доор баталсан 1972 оны Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах

тухай Конвенцын (“Дэлхийн өвийн Конвенц”) дагуу “Дэлхийн өвийн жагсаалт”-д бүртгэсэн байна. Дэлхийн өвийн Конвенцын 4 дүгээр зүйлд зааснаар уг Конвенцод нэгдэн орсон улс орнууд тус Конвенцод хамрагдсан нутаг дэвсгэрийнхээ аливаа соёлын дурсгалт газруудыг хамгаалах үүрэг хүлээсэн. Мөн 6 дугаар зүйлийн 3-т уг Конвенцын гишүүн өөр улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт байрлах аливаа соёлын дурсгалт газруудыг шууд болон шууд бусаар хохирол учруулж болзошгүй санаатай арга хэмжээ авахгүй байхыг үүрэг болгосон.

- 24.** Дэлхийн өвийн Конвенц зэвсэгт мөргөлдөөний үед үйлчилсээр байдаг. Энэ нь Дэлхийн өвийн Конвенцод нэгдэн орсон улс тус Конвенцод хамрагдсан нутаг дэвсгэрийнхээ соёлын дурсгалт газруудыг хамгаалах үүргээ биелүүлсэн эсэх эсвэл өөр улсын нутаг дэвсгэр дэх хамгаалалттай газарт хохирол учруулж болзошгүй санаатай арга хэмжээ авахгүй байх үүргээ биелүүлсэн эсэхийг Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн холбогдох дүрмийн дагуу үнэлнэ.
- 25.** Бодит байдал дээр ОУХЭХ-ийн нэгэн адил зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухайд цэргийн хүчин нь Дэлхийн өвийн Конвенцоор хүлээсэн үүргээ дангаар нь биелүүлэх шаардлагагүй. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн холбогдох дүрмийг дагаж мөрдөх нь Дэлхийн өвийн Конвенцыг дагаж мөрдөх баталгаа болно. Харин эсрэгээр, Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийг зөрчих нь Дэлхийн өвийн Конвенцыг зөрчсөн гэсэн үг. Түүгээр ч зогсохгүй соёлын үнэт зүйлийг устгаж, хохирол учруулахтай холбоотой дайны гэмт хэрэг үйлдсэн хэрэгт ял оноохдоо Хуучин Югославын Олон улсын эрүүгийн шүүх болон Олон улсын эрүүгийн шүүх аль аль нь Дэлхийн өвийн жагсаалтад орсон газар бол гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл болгож байв.
- 26.** Дэлхийн өвийн Конвенц нь цэргийн хүчинд Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийг дагаж мөрдөхөд туслах нэгэн төрлийн дэмжлэг болно гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн эсвэл Конвенцын 11-р зүйлийн 1-д заасны дагуу Конвенцод нэгдэн орсон улсын зүгээс Дэлхийн өвийн хороонд өргөн мэдүүлж Дэлхийн өвийн “урьдчилсан жагсаалт”-д оруулсан соёлын дурсгалт газар, Соёлын дурсгалт газарт Дэлхийн өвийн ялгах тэмдэг байрлуулсан байх (III хавсралт харах) эсвэл түүний ойролцоо байрлалтай байх нь 1954 оны Гаагийн Конвенц болон Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн бусад холбогдох хууль дүрэм (§§44–49-р зүйлийг харах)-д заасны дагуу тус улсын “соёлын өв”-д тооцогдох ач холбогдол бүхий газар болохыг харуулдаг. Эдгээр жагсаалтыг онлайнаар үзэх боломжтой.

(v) 1970 оны ЮНЕСКО-ийн Конвенц

27. ЮНЕСКО-ийн ивээл дор дахин батлагдсан Соёлын үнэт зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга замын тухай 1970 оны Конвенц нь соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх олон улсын эрх зүйн баримтын гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү Конвенц нь зэвсэгт мөргөлдөөн, цэргийн хүчээр эзлэх ажиллагаанд оролцож буй цэргийн хүчинд шууд бус хамааралтай бөгөөд хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх хоёр талт үүрэгтэй. Нэгдүгээрт, Конвенцын 8 дугаар зүйлийн заалт нь алба хааж байгаа, эсвэл албаа гүйцэтгэж дуусах үед аль нэг улсаас соёлын эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх, эсвэл өөр улс руу хууль бусаар дамжуулсан ажилтныг эрүүгийн хариуцлагад татах магадлалыг нэмэгдүүлнэ. 8-р зүйлд зааснаар Конвенцод нэгдэн орсон улс орнууд өөрийн нутаг дэвсгэрээс соёлын үнэт зүйлийг хууль бусаар гаргасан, эсвэл нутаг дэвсгэртээ музей, дурсгалт газар болон түүнтэй адилтгах газраас хулгайлагдсанаар бүртгэгдсэн соёлын үнэт зүйлийг хууль бусаар оруулж ирсэн аливаа этгээдэд торгууль, захиргааны шийтгэл ногдуулах ёстой. Хоёрдугаарт, 7, 13-р зүйлд заасан Конвенцод нэгдэн орсон улсуудын хүлээх үүрэг нь цэргийн алба хаагчдын хууль бусаар худалдаалсан аливаа соёлын объектыг хураан авч, эх оронд нь буцаахад чиглэнэ. 7(b)(ii) зүйлд заасны дагуу Конвенцод нэгдэн орсон улсууд Конвенцод нэгдэн орсон өөр улс өөрийн улсаас гарал үүсэлтэй музей, дурсгалт газар болон түүнтэй адилтгах газраас Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хулгайлагдсан, хилээр нэвтэрсний дараа импортолсон соёлын үнэт зүйлийг олж авах, буцаах талаар хүсэлтээ гаргавал зохих арга хэмжээ авах ёстой. Мөн 13(c) зүйлийн дагуу Конвенцод нэгдэн орсон улсууд тус тусын улсын хууль тогтоомжид нийцүүлэн хууль ёсны өмчлөгч нь эсвэл түүний нэрийн өмнөөс нэхэмжилсэн аливаа хулгайлагдсан соёлын үнэт зүйлийг эргүүлэн авах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх ёстой. 13(b) зүйлийн дагуу Конвенцод нэгдэн орсон улсууд соёлын өвийн албадаар дамжуулан хууль бусаар экспортлогдсон соёлын үнэт зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгоход дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах ёстой. Үүнтэй холбогдуулан, Конвенцын зорилгод нийцэх үүднээс 11-р зүйлд зааснаар Конвенцод нэгдэн орсон улс орнууд цэргийн хүчээр эзлэх ажиллагааны улмаас шууд болон шууд бусаар үүссэн албадлагын дор экспортлохыг хууль бус гэж үзнэ.

(vi) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолууд

28. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулж буй цэргийн хүчин соёлын үнэт зүйлтэй холбоотой арга хэмжээ авах үүрэг хүлээж, эрх мэдлээр хангагдахын зэрэгцээ дэмжлэг авна.

Аюулгүйн Зөвлөлийн 2013 оны 4-р сарын 25-ны өдрийн 2100 (2013) тогтоолоор Мали улс дах НҮБ-ын олон талт нэгдсэн тогтворжуулах комисс (ОТНТК) байгуулсан бөгөөд Аюулгүйн зөвлөлөөс ОТНТК нь Мали улсын түр эрх баригчдад шаардлагатай бөгөөд боломжтой туслалцаа үзүүлэх, Мали дахь соёл, түүхийн дурсгалт газруудыг довтолгооноос хамгаалах чиглэлээр ЮНЕСКО-той хамтран ажиллаж, энэхүү даалгаврыг хэрэгжүүлэхийн тулд “өөрийн хүчин чадал, байршуулах бүсийнхээ хүрээнд шаардлагатай бүх арга хэмжээг” авахыг зөвшөөрөл олгожээ. Аюулгүйн Зөвлөл мөн ОТНТК-г “соёлын болон түүхийн дурсгалт газруудын ойр орчимд анхаарал сэрэмжтэйгээр үйл ажиллагаа явуулах”-ыг дэмжжээ. Уг комисст олгосон бүрэн эрхийг сунгаж, итгэл хүлээлгэж байгаагаа Аюулгүйн Зөвлөлийн дараа дараагийн тогтоолуудад ч мөн дурджээ.

Мөн НҮБ-ын дүрмийн 25-р зүйлд заасны дагуу НҮБ-ын гишүүн орнууд заавал биелүүлэх ёстой Аюулгүйн зөвлөлийн шийдвэр нь соёлын үнэт зүйлтэй холбоотой НҮБ-ын үйл ажиллагааны хүрээнээс гадуурх цэргийн ажиллагаанд мөн хамаарна.

Эвслийн хүчин Иракт цэргийн хүчээр эзлэх ажиллагаа явуулах үеэр батлагдсан Аюулгүйн Зөвлөлийн 2003 оны 5-р сарын 22-ны өдрийн 1483 (2003) тогтоолоор НҮБ-ын гишүүн бүх улсууд 1990 оны 8-р сарын 6-ны өдөр баталсан 661 (1990) дүгээр тогтоолоос хойших хугацаанд алдагдсан Иракийн соёлын үнэт зүйл болон Иракийн Үндэсний музей, Үндэсний номын сан, бусад газраас хууль бусаар алдагдсан археологи, түүх, соёл, шинжлэх ухаан, шашны ач холбогдол бүхий ховор эд зүйлсийг Иракийн байгууллагуудад аюулгүй буцааж өгөхөд туслах зохих арга хэмжээг авах, ингэхдээ эдгээр соёлын үнэт зүйл болон хууль бусаар шилжүүлсэн гэх үндэслэл бүхий сэжигтэй эд зүйлийг худалдаалах, бусдад шилжүүлэхийг хориглох арга хэмжээ авахыг үүрэг болгосон. Уг шийдвэр нь үндсэндээ гишүүн орнуудыг өөрийн газар нутагтаа Иракаас хууль бусаар гаргасан соёлын дурсгалт зүйлсийг импортлоход хязгаар тогтоох, худалдахыг хориглох арга хэмжээ авахыг үүрэг болгож байв. Гэвч хууль зүйн үр нөлөө нь Иракт цэрэг оруулсан гишүүн орнуудад эдгээр объектуудыг Иракийн байгууллагуудад аюулгүй буцааж өгөхөд туслах зохих арга хэмжээг авахыг үүрэг болгосон юм.

Аюулгүйн Зөвлөлийн 2015 оны 2-р сарын 12-ны өдрийн 2199 (2015) тогтоолд НҮБ-ын бүх гишүүн орнууд Ирак, Сирийн соёлын үнэт зүйл болон археологи, түүх, соёл, шинжлэх ухаан, шашны ач холбогдол бүхий ховор олдворууд, эд зүйлсийг 1990 оны 8-р сарын 6-аас Иракаас, 2011 оны 3-р сарын 15-аас хойш Сириэс, тэр дундаа эдгээр зүйлийг хил дамнуулан худалдахыг хориглох, хууль бусаар худалдаалахаас урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ авах ёстой гэж заасан. Дахин хэлэхэд, эдгээр үүргийг хүлээлгэсэн нь гишүүн орнууд өөрсдийн нутаг дэвсгэрт хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ авахад чиглэсэн ч энэ нь гишүүн орнуудын Ирак, Сирид байрлуулсан цэргийн хүчинд хамаатай.

Үүнээс дүгнэж үзвэл Аюулгүйн Зөвлөлийн өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа, түүнчлэн үүнд хамаарахгүй аливаа цэргийн хүчин соёлын үнэт зүйлийн талаар холбогдох тогтоол, тэдгээр тогтоолын үр дагаврыг мэддэг байх ёстой.

(vii) НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын бюллетень 1999/13

- 29.** 1999 оны 8-р сарын 6-ны өдөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга 1999 оны 8-р сарын 12-нд хүчин төгөлдөр болсон “НҮБ-ын Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг сахиулах нь” нэртэй 1999/13 (ST/SGB/1999/13) бюллетенийг нийтэлсэн. Үүнд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын удирдлага, хяналтад үйл ажиллагаа явуулж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүчинд хамаарах олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн зарчим, дүрэм”-ийг тодорхойлсон. Эдгээр үндсэн зарчим, дүрмийн 1(1)-д “Зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд байлдааны ажиллагаанд оролцож байгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүчин, тэдгээрийн байлдааны хамрах хүрээ, үргэлжлэх хугацаанд” дагаж мөрдөхөөр заасан бөгөөд үүний үр дүнд “хүч хэрэглэхийг зөвшөөрсөн тохиолдолд, эсвэл энхийг сахиулах ажиллагаа”-ны үед ашигладаг. Эдгээр зарчим, дүрмийн зарим нь соёлын үнэт зүйлийг хамгаалахад хамааралтай. Бюллетений 6(б)-д соёлын үнэт зүйлийг хүндэтгэх тухай наад захын заалтууд нь НҮБ-ын хүчин соёлын үнэт зүйлд довтлохыг хориглож, ийм эд хөрөнгө болон түүний эргэн тойронд байгаа газрыг эвдэрч сүйдэхэд хүргэж болзошгүй зорилгоор ашиглах ёсгүй гэж заасан байдаг. Мөн соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, завших, эвдэн сүйтгэх аливаа үйлдлийг хатуу хориглох тухай тусгасан. 6(9)-д НҮБ-ын хүчнийг 6-р хэсэгт заасны дагуу хамгаалагдсан соёлын үнэт зүйл зэрэг объектуудыг хохирол учруулах аливаа үйлдэл хийхийг хориглосон. Нэмж дурдахад уг бюллетений 5-р хэсэгт НҮБ-ын хүчнийхний үйл ажиллагаатай холбогдуулан соёлын үнэт зүйлийн талаарх Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн хэд хэдэн ерөнхий заалтыг давхар тусгажээ. Үүнд цэргийн бодит болон шууд давуу талтай холбоотойгоор иргэний объектод санамсаргүй байдлаар хохирол учруулж болзошгүй халдлагыг хориглох, иргэний объектыг цэргийн ажиллагааны улмаас үүсэх аюулаас хамгаалахын тулд шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэг багтана.
- 30.** Ерөнхий нарийн бичгийн даргын бюллетений нь өргөн ач холбогдолтойн зэрэгцээ соёлын үнэт зүйлтэй холбоотой НҮБ-ын нэвтрэн орсон улс орнуудын өмнө хүлээсэн үүргийг цагаатгах боломж олгодог. Жишээлбэл, 1995 оны 12-р сарын 15-нд байгуулсан НҮБ-ын Ливан дахь түр хүчний статусын тухай НҮБ, Ливан хоорондын хэлэлцээр (НҮБЛТХ)-ийн 7(а)-д НҮБ-аас 9-р ээлжийн үүргээ 1954 оны Гаагийн Конвенцын зарчим, үзэл санааг бүрэн хүндэтгэн биелүүлэхийг үүрэг болгосон.
- 31.** НҮБ-ын зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд оролцож байгаа цэргийн хүчин НҮБ-ын бус тухайн улсын захиргаа, удирдлагын дор ЗЭВСЭГТ

МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-д заасан үүрэг хариуцлагыг дагаж мөрдөх ёстой гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

(viii) Бүс нутгийн зохицуулалт

- 32.** Бүс нутагт мөрдөгдөх олон улсын хууль дүрмийн дагуу цэргийн ажиллагааг зохицуулах нэмэлт нөхцөл байдал үүсэж болно. Эдгээр дүрмүүд нь бие даасан бүс нутгийн гэрээнээс үүдэлтэй байх магадлалтай. Жишээлбэл, “Рерихийн гэрээ” нэрээр танигдсан 1935 оны Урлаг, Шинжлэх Ухааны байгууллага болон Түүхэн Хөшөө Дурсгалыг Хамгаалах тухай Гэрээ нь Америк тивийн арван нэгэн улсад тайван цагт болон зэвсэгт мөргөлдөөний үед ч хүчинтэй хэвээр байна. Ийм төрлийн дүрмүүд нь бүс нутгийн аюулгүй байдлын гэрээ, бүс нутгийн хэмжээн дэх засгийн газар хоорондын байгууллагын баримт бичиг, эсвэл бусад бүс нутгийн олон улсын эрх зүйн зохицуулалтыг заавал дагаж мөрдөх нэг ижил нөхцөлтэй байдаг.
- 33.** Цэргийн хүчнүүд нь зэвсэгт мөргөлдөөний ажиллагааг явуулах тохиолдолд олон улсын эрх зүйн хязгаарлалтыг орлох бүс нутгийн аливаа дүрэм журамтай үргэлж танилцаж байваас зохино.

Г. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛСАН ЦЭРЭГ АРМИЙН ШИЛДЭГ ТУРШЛАГА

- 34.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалсан цэрэг армийн шилдэг туршлагын талаар олон эх сурвалж бий.
- 35.** Үүнд холбогдох шилдэг туршлагын талаарх жишээнүүдийг 1954 оны Гаагийн Конвенц болон 1999 оны II Протоколд нэгдсэн улсуудын уг Конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу ЮНЕСКО-д ирүүлсэн тайлангаас харж болно. Үүнээс гадна муж улсууд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын боловсруулсан төрөл бүрийн тайлан, материал, эрдэм шинжилгээний ном зохиолууд зэрэг холбогдох эх сурвалжаас мөн үзэж болно.
- 36.** Олон улсын байгууллага, гэрээт байгууллагуудаас баталсан тунхаглал, зөвлөмж, заавар зэрэг заавал биелүүлэх үүрэг хүлээдэггүй норматив баримт бичиг нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад цэргийн хүчний дагаж мөрдөх ерөнхий зарчмуудыг тусгасан байдаг. Үүнтэй холбоотой чухал баримт бичгүүдэд 2003 онд тус

байгууллагын Ерөнхий бага хурлаас баталсан Соёлын өвийг санаатайгаар устгах тухай ЮНЕСКО-ийн тунхаглал; 1978 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас баталсан Соёлын хөдлөх үнэт зүйлийг хамгаалах зөвлөмж; 1956 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар баталсан Археологийн малтлагад холбогдох олон улсын зарчмуудын талаарх зөвлөмж; 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протокол, Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протоколыг хэрэгжүүлэх удирдамж зэрэг багтана.

- 37.** Эцэст нь, 1954 оны Гаагийн Конвенц болон дагалдах хоёр Протоколын аль нэг эсвэл хоёуланд нь нэгдэн ороогүй улс орнуудын цэргийн хүчний хувьд, эдгээр гурван гэрээний заалтууд, тэр дундаа 1999 оны II Протокол нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах талаар заавар зөвлөмж болдог.

Д. ХОЛБОГДОХ ДҮРМИЙГ ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

- 38.** Улс орнуудын хувьд 1954 оны Гаагийн Конвенц болон түүний хоёр протокол, 1977 оны Женевийн Конвенцын I, II нэмэлт протоколууд нь зөвхөн нэгдэн орсон улсуудад үйлчилнэ. Эдгээр гэрээнд нэгдэн ороогүй улс орнууд ("гуравдагч орнууд") зөвшөөрч байгаагаа илэрхийлээгүй нөхцөлд үүрэг хүлээлгэх боломжгүй. Харин зэвсэгт мөргөлдөөний тухай олон улсын заншлын хууль нь наад зах нь аль нэг хуулийн заалтыг тууштай эсэргүүцэх байр суурь баримтлаагүй гэгдэх бүх улсад хамаатай. Энэ ялгаа нь зэвсэгт мөргөлдөөний үе дэх соёлын үнэт зүйлийг хамгаалахад хоёр дугаар зэргийн ач холбогдолтой. Олон улсад мөрдөгддөг заншлын хуульд холбогдох дүрмүүд нь 1954 оны Гаагийн Конвенц болон түүний протоколд гэрээний эрх зүйн зорилгоор тусгагдсан заалтыг агуулсан байдаг. Тиймээс улс орнууд Конвенцод болон түүний хоёр Протоколын аль нэгэнд нэгдэн орсон эсэхээс үл хамааран ихэнх тохиолдолд олон улсын заншлын эрх зүйн заалтыг дагаж мөрдөх үүрэгтэй. Гэвч 1954 оны Гаагийн Конвенц болон түүний хоёр Протоколын заалт бүрт дүйцэх заншлын эрх зүйн заалт байхгүй бөгөөд аливаа заалт зөвхөн гэрээний эрх зүйн хүрээнд мөрдөгдөх ёстой бол энэ гарын авлагад тодорхой тайлбарласан.
- 39.** Зарчмын хувьд Олон улсын шинжтэй зэвсэгт мөргөлдөөн (ОУЗМ), эзлэн түрэмгийллийн үед дагаж мөрдөх Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль, мөн Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн (ОУБЗМ)-ий үед дагаж мөрдөх хууль дүрэм нь ижил байх албагүй. Гэвч эзлэн түрэмгийлэл гэдэг нь хуулийн тодорхойлолтод заасан утгаараа Олон улсын шинжтэй зэвсэгт

мөргөлдөөний үед л явагдана гэж үзвэл, практикт зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалах хууль дүрмүүд нь ОУЗМ ба ОУБЗМ-тай адил гэрээний эсвэл заншлын эрх зүйн шинжтэй байдаг. Зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн хүчинд шаардагдах соёлын үнэт зүйлтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээ ОУЗМ эсвэл ОУБЗМ байхаас үл хамааран бүх зорилго, зорилт ижил байна.

- 40.** Эцэст нь, Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн соёлын үнэт зүйлийг хамгаалахтай холбоотой дүрэм нь цэргийн ажиллагаа нь хуурай газар, далай, агаарын замаар явагдсан эсэхээс үл хамааран ижил байна.

Е. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХАД ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ҮҮРЭГ

- 41.** Бүх шатны цэргийн командлагчид Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн Зэвсэгт хүчний ЗХЖШ-ын дүрмийг дагаж мөрдөж, зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах шилдэг туршлагыг хэрэгжүүлэх хариуцлагыг хүлээнэ.
- 42.** Командлагч нарын үүрэг хариуцлага нь зөвхөн үйл ажиллагааны төдийгүй хууль эрх зүйн шинжтэй байна. Командлагч нар өөрийн улсын цэргийн хууль дүрмийг дагаж мөрдөх, зөрчсөн тохиолдолд тухайн хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Олон улсын хууль тогтоомжийг мөн дагаж биелүүлэх ёстой. Зэвсэгт хүчний командлагч нар удирдаж байгаа бие бүрэлдэхүүнийг зохих ёсоор удирдан чиглүүлэх үүргээ биелүүлээгүйгээс үүдэн дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон бусад олон улсын гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөлд олон улсын хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Цэргийн ажиллагааны үеэр соёлын үнэт зүйлийг хамгаалахад чиглэсэн дээд шатны командлагч нарын тушаал, заавар гэх мэт олон түүхэн жишээ бий. 1943 оны 12-р сарын 29-нд холбоотнууд Анциод буухаас хэдхэн долоо хоногийн өмнө тухайн үеийн Газар дундын тэнгис дэх Холбоотны командлагч генерал Эйзенхауэрын 68 тоот ерөнхий тушаал ('Түүхийн дурсгалууд'-ын тухай)-д Итали дахь байлдааны ажиллагааны үеэр түүхэн барилгуудыг цэргийн зориулалтаар ашиглах, дээрэм тонуулд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар нарийвчилсан зааварчилгаа гаргаж, соёлын үнэт зүйлийн эсрэг гэмт хэргийн ноцтой үйлдэлд хариуцлага хүлээлгэхийг холбоотны бүх бие бүрэлдэхүүний командлагч нарт анхааруулсан байна. 68-р тушаал нь 1943 оны 4-р сард Холбоот хүчний төв штабын тушаалтай утга

агуулгаараа ижил ч илүү тодорхой анхааруулга болсон бөгөөд Эйзенхауэр цэргийн хэрэгцээг “сул дорой, хайхрамжгүй байдлыг нууж” хэрэгсэл болгохыг хүсэхгүй байгаагаа онцлон тэмдэглэж, уг тушаалын биелэлтийг хангаж ажиллахыг удирдах тушаалтнуудад үүрэг болгосон. Эйзенхауэр Холбоотны экспедицийн дээд командлагчийн хувиар 1944 оны 5-р сарын 26-ны өдрийн заавар, санамж бичигт өмнөх тушаалын санааг дахин тусгажээ. Нормандад буухын өмнөхөн командлагчдад “тэвчээр, сахилга баттай байх замаар” түүх, соёлын ач холбогдол бүхий төв, объектуудыг хамгаалахыг даалгасан. Газар дундын тэнгис дэх Холбоотны хүчний төв штабын дээд командлагч генерал Александр 1945 оны 1-р сарын 12-нд үүнтэй төстэй удирдамж гаргасан зэрэг олон жишээг дурдаж болно.

- 43.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн заалтыг дагаж мөрдөх, шилдэг туршлагыг хэрэгжүүлэх талаар командлагч нар арга замыг эрэлхийлэх хэрэгтэй. Албан үүрэг, бие бүрэлдэхүүний тоо хэмжээ, гүйцэтгэх даалгавар, үндэсний цэргийн уламжлал зэргээс хамааран өөр өөр арга тохиромжтой ч эцсийн дүндээ дайны үеийн соёлын үнэт зүйлийн хувь заяа командлагч нар үйл ажиллагааны болон хуулийн хариуцлагаа үр дүнтэй биелүүлэх эсэхээс хамаарна.

II. “СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ”-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1954 оны Гаагийн Конвенцод тодорхойлсноор “соёлын үнэт зүйл” гэдэг нь гарал үүсэл, өмчлөлийн хэлбэрээс үл хамааран тухайн улсын соёлын өвд чухал ач холбогдол бүхий, иргэний болон шашны, хөдлөх болон үл хөдлөх өмчийг хэлнэ. Жишээлбэл, түүх, урлаг, архитектурын ач холбогдолт бүхий барилга байгууламж, бусад дурсгалт газрууд, археологийн дурсгалт газрууд, урлагийн бүтээл, эртний эдлэл, гар бичмэл, ном, цуглуулга болон архивын байр зэрэг болно. Энэ нэр томъёонд соёлын хөдлөх үнэт зүйлсийг хамгаалах, дэлгэн үзүүлэх зориулалттай барилга байгууламж, хадгалж хамгаалах зориулалт бүхий хоргодох байр мөн хамаарна.

- 44.** 1954 оны Гаагийн Конвенцын 1 дүгээр зүйлд тодорхойлсон “соёлын үнэт зүйл” гэдэг нь тухайн улсын соёлын өвд онцгой ач холбогдол бүхий бүх өмчийг хэлнэ. Соёлын үнэт зүйлд тооцогдох эд хөрөнгийн төрлүүдийн жишээг Конвенцын 1 дүгээр зүйлд заасан болно. Эдгээрт түүх, урлаг, архитектурын ач холбогдолтой барилга байгууламж, бусад дурсгалт газрууд, түүнчлэн археологийн дурсгалт газрууд зэрэг соёлын үл хөдлөх үнэт зүйлс болон урлагийн бүтээл (уран зураг, зураг, баримал гэх мэт), эртний эдлэл, гар бичмэл, ном дангаар болон тэдгээр зүйлсийн цуглуулга, түүнчлэн архив зэрэг соёлын хөдлөх үнэт зүйлс орно. Энд тодорхойлсноос үзэхэд гарал үүсэл, хэний өмч болох, шашин, шүтлэгийн шинжтэй эсэх, сэргээн засварласан эсэхээс үл хамааран соёлын хөдлөх болон үл хөдлөх үнэт зүйлсийг хэлнэ. Балгас хийгээд тансаг ордон аль аль нь соёлын үнэт зүйл юм. Соёлын үнэт зүйл газар дээр байх, усан дор байх ялгаагүй. Тухайн улсын соёлын өвд онцгой ач холбогдол бүхий хөдлөх, үл хөдлөх хөрөнгө бүхэн соёлын үнэт зүйл болно.
- 45.** Аливаа эд зүйл, барилга байгууламж, газар талбай нь чухал ач холбогдолтой эсэх нь юуны өмнө тухайн нутаг дэвсгэрийг эзэмшигч улсын тодорхойлох асуудал юм. Хэрэв энэ улс шударгаар хөдлөх болон үл хөдлөх өмчийг өөрийн соёлын өвд чухал ач холбогдолтой гэж үзвэл уг өмчийг “соёлын үнэт зүйл” гэж үзнэ.

- 46.** 1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон бараг нэг ч улс зэвсэгт мөргөлдөөнд оролцож болзошгүй талуудад хандан өөрийн нутаг дэвсгэр дэх Гаагийн Конвенц болон түүний Протоколоор хамгаалагдсан “соёлын үнэт зүйл” гэж үзэх эд зүйл, барилга байгууламж, газар талбайг тодорхой заагаагүй байдаг нь байлдааны ажиллагааг төлөвлөгч, цэргийн хүчнийхэнд тулгамдсан асуудал болдог. Конвенцод нэгдэн орсон улс зарим үл хөдлөх буюу соёлын хөдлөх үнэт зүйл болон тэдгээрийг байрлуулсан барилга байгууламжид соёлын үнэт зүйлийн ялгах тэмдэг (§§213–218-р зүйлийг харах) эсвэл бусад таних тэмдэглэгээ хийсэн байж болох ч бодит байдал дээр улсаас соёлын үнэт зүйлд нэг бүрчлэн тэмдэглэдэггүй бөгөөд ихэнх улсад ялгах тэмдгийг огт ашигладаггүй. Иймд тухайн улсад зохих ёсоор хөтөлсөн үндэсний соёлын үнэт зүйлийн бүртгэл эсвэл түүнтэй адилтгах дотоодын хууль, эрх зүйн болон засаг захиргааны бүртгэл жагсаалт байгаа тохиолдолд тэдгээр баримт бичигт үндэслэн тодорхой өмчийг төрийн зүгээс өөрийн соёлын өвд чухал ач холбогдолтой гэж үздэг эсэхийг тодорхойлж болно. Гэвч бодит байдал дээр байлдааны ажиллагааг төлөвлөгчид, цэргийн хүчнийхний хувьд ийн өөр улсын соёлын үнэт зүйлийн бүртгэл, жагсаалтыг ашиглах боломж хомс, бараг үгүй юм.
- 47.** Өөр улсын нутаг дэвсгэр дээр түүх, урлаг, архитектурын ач холбогдолтой хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг эргэлзээтэй гэж үзсэн тохиолдолд командлагч болон бусад цэргийн албан хаагчид тэрхүү өмчийг тухайн улсын соёлын өвд онцгой ач холбогдолтой гэж хандах ёстой. Өөрөөр хэлбэл, зэвсэгт мөргөлдөөний хуулийг дагаж мөрдөх улс орныхоо хүлээсэн үүргийг биелүүлэх үүднээс, нөгөөтээгүүр дайны гэмт хэрэг үйлдсэн хэрэгт хувийн хариуцлага хүлээхээс зайлсхийхийн тулд командлагч болон бусад цэргийн албан хаагчид гадаад улсын нутаг дэвсгэр дэх түүх, урлаг, архитектурын ач холбогдол бүхий бүх объект, байгууламж, дурсгалт газрыг 1954 оны Гаагийн Конвенц болон дагалдах хоёр протокол, олон улсын заншлын эрх зүйн дагуу хамгаалагдсан “соёлын үнэт зүйл” гэж үзэх ёстой.

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон цөөн хэдэн улсын иш татсан тоо баримтаас үзэхэд улс болгон хэдэн арван мянгаар тоологдох үл хөдлөх соёлын үнэт зүйлийг тоочсон байх бөгөөд хөдлөх өмчийн тухайд улс болгонд 100-250 музей, урлагийн галерей, номын сан, архивд агуулагдаж байдаг эд зүйл байдаг болохыг багцаагаар тогтоосон. Өөрөөр хэлбэл, Конвенцод тодорхойлсон “соёлын үнэт зүйл” гэдэг нэр томьёо нь асар их хэмжээний үл хөдлөх болон хөдлөх өмчийг хамаардаг. Энэ нь тодорхой хэдэн шилдэг бүтээлээр хязгаарлагдахгүй нь ойлгомжтой.

48. 1977 оны Женевийн Конвенцын нэмэлт протоколуудын холбогдох заалтууд өөр өөр нэр томьёо хэрэглэдэг боловч тэдгээрээр хамгаалагдсан соёлын ач холбогдол бүхий өмч нь 1954 оны Гаагийн Конвенц болон түүний протоколоор хамгаалагдсан “соёлын үнэт зүйл”-тэй үндсэндээ ижил байна.
49. Боловсролын байгууллага, номын сан, архив, мөргөлийн газар зэрэг барилга байгууламж, урлагийн бүтээл, ном зэрэг эд зүйлс болон иргэний объект, хувийн өмч зэрэг нь албан ёсны утгаараа “соёлын үнэт зүйл” биш боловч Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулиар хамгаалагдсан гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

“Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйл” гэдэг нэр томьёо нь 1954 оны Гаагийн Конвенцод заасны дагуу “Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын бүртгэлд” орсон соёлын үнэт эд зүйлийг хэлнэ.

50. 1954 оны Гаагийн Конвенцын 8 дугаар зүйлд зааснаар хатуу нөхцөлийн дагуу хязгаарлагдмал тооны соёлын хөдлөх үнэт зүйлийг хамгаалах зориулалт бүхий хоргодох байр, их хэмжээний соёлын үнэт зүйлийг агуулсан төвүүд (“Хөшөө дурсгал агуулсан төвүүд” гэх) болон бусад маш чухал ач холбогдол бүхий соёлын үл хөдлөх хөрөнгийг “тусгай хамгаалалт”-д авч болно. Ийм өмчийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын тушаалаар Конвенцод заасны дагуу “Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын бүртгэл”-д оруулснаар тусгай хамгаалалтад авдаг. Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын бүртгэлийг онлайнгаар хялбархан үзэх боломжтой.

- 51.** Конвенцын тусгай хамгаалалтын тогтолцоо нь төрөл бүрийн шалтгааны улмаас дэлхий даяар цөөн тооны хөшөө дурсгал хадгалах зориулалт бүхий хоргодох байр, төвүүдээс илүү гарч хэрэгжиж байсангүй. Энэ гарын авлагыг хэвлэх үеийн Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн нийт тоог авч үзвэл Германд нэг, Нидерландад гурван хөшөө дурсгал хадгалах зориулалт бүхий хоргодох байр, Мексик дэх хөшөө дурсгал бүхий есөн төв, Ватикан хот бүхэлдээ хөшөө дурсгал бүхий төв зэрэг газрууд бүртгэгдсэн байна.
- 52.** Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлд хамаарах хууль дүрэмтэй зөрчилдөхөөс бусад тохиолдолд Конвенцын 1 дүгээр зүйлд заасан бүх эд зүйл, барилга байгууламж, газар талбайг хамгаалах зорилго бүхий 1954 оны Гаагийн Конвенц, 1954 оны I Протокол, 1999 оны II Протоколын заалтууд нь Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйл болон бусад соёлын үнэт зүйлд нэгэн адил үйлчилнэ.

"Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл" гэдэг нэр томъёо нь 1999 оны II Протоколын дагуу "Өргөтгөсөн хамгаалалтад байх олон улсын соёлын үнэт зүйлийн жагсаалт"-д оруулсан соёлын үнэт зүйлийг хэлнэ.

- 53.** 1954 оны Гаагийн Конвенцын II Протоколын 3-р бүлэгт заасны дагуу "хүн төрөлхтөнд нэн чухал ач холбогдол бүхий соёлын өв"-д Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалах Хорооноос эцэслэн гаргасан шийдвэрт үндэслэн тодорхой нөхцөлөөр сонгосон (§§232–233-р зүйлийг харах) цөөн тооны соёлын өвийг тусгай дэглэмийн дор "өргөтгөсөн хамгаалалт"-д авч болно. Соёлын үнэт зүйлийг "Өргөтгөсөн хамгаалалтад байх олон улсын соёлын үнэт зүйлийн жагсаалт"-д оруулснаар өргөтгөсөн хамгаалалтад авдаг. Өргөтгөсөн хамгаалалтад байх олон улсын соёлын үнэт зүйлийн жагсаалтыг онлайн аргаар авах боломжтой (Хавсралт II-р зүйлийг харах).
- 54.** Өргөтгөсөн хамгаалалтын тухай заалт нь харьцангуй шинэ зохицуулалт учраас төдий л олон газар ороогүй байна. 2016 оны 12-р сарын байдлаар Конвенцод нэгдэн орсон 7 улсын нийт 12 газрыг "Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын жагсаалт"-д оруулсан байна. Эдгээрт Азербайжанд хоёр, Бельгид гурав, Кипрт гурав, Гүржид нэг, Италид нэг, Литвад нэг, Малид нэг газар багтжээ.
- 55.** Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлтэй холбоотой аливаа тусгай заалттай зөрчилдөхөөс бусад тохиолдолд, 1954 оны Гаагийн Конвенц, 1954 оны I Протокол, 1999 оны II Протоколын бүх объектыг

хамгаалах үүрэг бүхий заалтууд нь бусад соёлын үнэт зүйлийн нэгэн адил Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлд хамаарна.

III. БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ

A. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЗААВАРЧИЛГАА

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улс орнууд Конвенцыг дагаж мөрдөхөд чиглэсэн заалтуудыг тайван цагт Зэвсэгт хүчний хууль, дүрэм, зааварчилгаандаа оруулж, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүндээ бүх ард түмний соёл, соёлын үнэт зүйлийг хүндэтгэх сэтгэлгээг төлөвшүүлэх ёстой. Конвенцод нэгдэн ороогүй улсууд ч мөн энэ заалтыг дагаж мөрдөх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн орсон улс орнууд Конвенцыг дагаж мөрдөхөд чиглэсэн зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг зохих ёсоор хамгаалах заавар, зааварчилгааг Зэвсэгт хүчний хууль, дүрэмдээ тусгах ёстой.

Протоколд нэгдэн ороогүй улсууд ч мөн энэ заалтыг дагаж мөрдөх ёстой.

- 56.** 1954 оны Гаагийн Конвенцын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Конвенцод нэгдэн орсон улс орнууд тайван цагт Зэвсэгт хүчний хууль, дүрэм, зааварчилгаандаа Конвенцыг дагаж мөрдөхтэй холбоотой шаардлагатай заалтуудыг оруулах ёстой гэж заасан. Мөн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд “бүх ард түмний соёл, соёлын үнэт зүйлийг хүндэтгэх сэтгэлгээг” төлөвшүүлэхийг шаарддаг. 1999 оны II Протоколын 30 дугаар зүйлийн 3/а-д зааснаар Конвенцод нэгдэн орсон улс орнууд Зэвсэгт хүчний хууль, дүрэмдээ зөвхөн II Протоколын заалтууд төдийгүй, зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай “удирдамж, заавар”-т хамаарах заалтыг тусгах нь зүйтэй гэж заасан байдаг. Энэ үүрэг чухал ач холбогдолтой, учир нь 1954 оны Гаагийн Конвенц, түүний 1999 оны II Протокол болон өргөн утгаар нь авч үзвэл ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн дүрэм журмууд дах дайны үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай заалт нь ихэнх тохиолдолд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний хэрэгжүүлэх үүрэг байдаг учир эдгээр үүргийг тайван цагт Зэвсэгт хүчний хууль, дүрэм, зааварчилгаандаа тусгах нь маш чухал юм.
- 57.** 1954 оны Гаагийн Конвенц эсвэл 1999 оны II Протоколд нэгдэн ороогүй улс орнууд Гаагийн Конвенцын 7(1) зүйл, II Протоколын 30(3)(а) зүйл дэх

заалтыг дагаж мөрдөх ёстой. Шилдэг туршлагуудаас харахад эдгээрт заасан арга хэмжээ ихээхэн практик ач холбогдолтой нь тогтоогджээ.

- 58.** 1954 оны Гаагийн Конвенц, 1999 оны II Протокол болон Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн бусад дүрмийг дагаж мөрдөхөд ихээхэн чухал зүйл нь зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд болон командлагчдын зүгээс доод албан тушаалтнууддаа 'оролцооны дүрэм' (ОД)-ийг таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх явдал юм. Оролцооны дүрэм нь улс орон бүрт өөр өөр хэлбэртэй байх бөгөөд тухайлбал, гүйцэтгэх тушаал, байршуулах тушаал, цэргийн ажиллагааны төлөвлөгөө эсвэл байнгын удирдамж хэлбэрээр илэрдэг. Гэвч оролцооны дүрэмд нийтлэг байдаг зүйл бол эдгээрийг зэвсэгт хүчний эрх бүхий байгууллагаас Зэвсэгт хүчнийг ашиглаж болох нөхцөл байдал, зорилгодоо хүрэхийн тулд тэдгээрийн ажиллах ёстой хязгаарлалтыг тодорхой болгох зорилгоор гаргадаг. Оролцооны дүрэм нь зэвсэгт хүч хэрэглэх, хүчний байрлал ба төлөв байдал, тодорхой хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгож, хязгаарлалт тавих харилцааг зохицуулах бөгөөд Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль болон үндэсний хууль тогтоомжийн аль алинд нь нийцсэн байх ёстой.
- 59.** Цэргийн эрх баригчид цэргийн хүчээ байлдааны ажиллагаанд оруулах бүрд соёлын үл хөдлөх болон хөдлөх үнэт зүйлийг хамгаалахад тусгайлан зориулсан оролцооны дүрмийг боловсруулж, хэрэгжүүлэх нь шилдэг туршлага болно. Цэргийн ажиллагааны үеэр соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор оролцооны дүрэм боловсруулж байсан олон түүхэн жишээ бий.
- 60.** Зэвсэгт хүчнийхээ бүрэлдэхүүнд “бүх ард түмний соёл, соёлын үнэт зүйлийг хүндэтгэх сэтгэлгээг” төлөвшүүлэх тухайд цэргийн эрх бүхий байгууллагууд олон төрлийн арга барилтай байдаг.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд бүх ард түмний соёл, соёлын үнэт зүйлийг хүндэтгэх сэтгэлгээг төлөвшүүлэх шинэлэг аргын жишээнд АНУ-ын Батлан хамгаалах яам, Нидерландын үндэсний засгийн газар, Нидерландын ЮНЕСКО-ийн үндэсний комисс, Норвегийн Соёлын үнэт зүйлийн газар, Норвегийн Зэвсэгт хүчин, Норвегийн Урлагийн зөвлөл, Норвеги болон Олон улсын музейн зөвлөл үйлдвэрлэж тараасан хөзөр юм. Дэлхийн өнцөг булан бүр дэх соёлын хөдлөх болон үл хөдлөх үнэт зүйлийн гэрэл зураг бүхий хөзөр дээр практик бөгөөд санаа авах олон мессежийг бичсэн байдаг. Жишээлбэл:

- Соёлын өв бол түгээмэл үнэт зүйл юм. Үүнийг хамгаалах нь бидний нийтлэг үүрэг юм.
- Өөрийн хийгээд бусдын өнгөрсөн түүхийг ойлгох нь чухал.
- Соёлын үнэт зүйл нь орон нутгийн иргэдэд чухал ач холбогдолтой. Хүндэтгэл үзүүлж, хариуд нь хүндлэл хүлээцгээе!
- Хэн нэгэн энэ зургийг гэмтээвэл танд ямар санагдах вэ?

Мөн хуарангуудын танхимд ийм төрлийн зурагт хуудас байрлуулж болно.

2003 оноос хойш Иракт тогтворжуулах үүрэг гүйцэтгэсэн Польшийн цэргүүдэд Иракийн түүх, соёлын талаар археологичдын лекц, мультимедиа илтгэл сонсгох, товхимол тараах зэргээр тус улсын соёлын өвийн талаар сургалтад тогтмол хамруулжээ.

- 61.** Боломжтой бөгөөд тохиромжтой тохиолдолд танил бус соёлын орчинд байрлуулсан цэргийн хүчийг орон нутгийн ард иргэдтэй уулзах болон харилцах боломж олгох замаар соёлын өвийг нь үнэлдэг болгох хэрэгтэй. Байршуулахын өмнө ямар нэгэн хэлбэрээр “соёлын мэдлэг олгох сургалт” явуулах ёстой. Соёлын үнэт зүйлийг заналхийлэхийн зэрэгцээ соёлыг үл тоомсорлох нь цэргийн хүчний үйл ажиллагаа явуулж буй талын цэрэг дайчдын амь нас, даалгавраа амжилттай биелүүлэхэд сөрөг үр дагавартай.

Б. ЦЭРГИЙН СУРГАЛТ

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улс орнууд цэргийн сургалтын хөтөлбөртөө конвенцыг судлах талаар тусгах ёстой. Конвенцод ороогүй улсууд ч мөн дагаж мөрдөх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн орсон улсууд зохих тохиолдолд ЮНЕСКО болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах чиглэлээр тайван цагийн цэргийн сургалт, хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Протоколд ороогүй улсууд ч мөн дагаж мөрдөх ёстой.

62. 1954 оны Гаагийн Конвенцын 25 дугаар зүйл, 1999 оны II Протоколын 30 дугаар зүйлийн 3-ын (b) хэсэгт Конвенцод нэгдэн орсон улс орнууд тайван цагт зэвсэгт хүчиндээ мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах чиглэлээр сургалт явуулж, мэдлэг олгохыг үүрэг болгосон. Дайны үед соёлын үнэт зүйлийг хамгаалах, цэргийн албан хаагчдыг дайны гэмт хэрэгт буруутгагдахаас зайлсхийхийн тулд ийм төрлийн арга хэмжээ авах нь маш чухал тул эдгээр гэрээнд оролцогч бус улс орнуудад энэ чиглэлийн сургалт явуулж, мэдлэг олгох нь чухал юм.
63. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад цэргийн хүчнийг сургах, мэдлэг олгох чиглэлд хийсэн шилдэг туршлагын олон жишээ бий.

Хэд хэдэн улс зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах чиглэлээр зэвсэгт хүчнийхээ салбарт мэдлэг олгож, зарим тохиолдолд сургалтыг явуулдаг. Тухайлбал, Австри Улс Соёлын үнэт зүйлийн цэргийн хамгаалалт (2009 оны 12-р сар), Соёлын өвийг цэргийн хамгаалалтад авах удирдамж, Бельгийн Зэвсэгт мөргөлдөөний хуулийн зөвлөхүүдэд зориулсан тусгай хамгаалалттай газар, эд хөрөнгийн талаарх сургалт ('Les lieux et biens protégés', CDCA-DCA-07, 2011 оны 5-р сар); Эль Сальвадорын зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах зааварчилгааны гарын авлага ('Protección de los bienes culturales en caso de munaqışa armado. Convención de La Haya y sus dos dos protocolos. Versión Didáctica', 2000 оны 11-р сар); Италийн Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай удирдамж (SMD-UGAG-002/12, 2012), Францын Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах гарын авлага (PFT. 5.3.2 (EMP 50.655), 2015) зэрэг болно.

Нидерланд, Норвег, АНУ зэвсэгт хүчиндээ зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах талаар албан ёсны боловсрол олгож, сургалт явуулахаас гадна соёлын үнэт зүйлийн гэрэл зураг, хууль эрх зүйн заалт бүхий хөзөр (§60-р зүйлийг харах) тараасан байна. Сануулгад:

- Номын сан, архив, музей олон улсын хуулиар хамгаалагдсан байдаг.
- Дээрэмдсэн эд өлгийн зүйлийг худалдаж авах нь хууль бус үйлдэл юм. Тэднийг хурааж авах бөгөөд та эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй.
- Усан доорх соёлын үнэт зүйлс хуулиар хамгаалагдсан байдаг бөгөөд хөдөлгөхийг хориглоно!
- Олон улсын эрх зүйд цэргийн албан хаагчид соёлын өвийг хамгаалахыг шаарддаг.

Мөн АНУ өөрийн цэргийн албан хаагчдад зориулан соёлын өвийг хамгаалах талаар гарын авлага гаргажээ. Нью-Йоркийн Форт Драмд бэлтгэгдсэн АНУ-ын цэргүүдийг байрлуулахын өмнө “ухаж болохгүй” орчинтой танилцуулж, археологийн болон соёлын бусад дурсгалт зүйлсийг “хуулбарлан” бүтээсэн орчинд соёлын эд зүйлийг үзүүлж, тэдгээрийг таних боломжийг олгодог.

Британийн батлан хамгаалахын нэг баг цэргийн сургалтын хөтөлбөртөө археологийн “хязгаарлагдмал” газруудын талаар оруулж, тонон дээрэмдэх ажиллагааны үед арга хэмжээний талаар дадлага хийх хөдөлгөөнт музей байгуулжээ.

2003 оноос хойш Иракт явуулсан Польшийн тогтворжуулах ажиллагааны үеэр археологичид цэргийн хүчинд холбогдох олон улсын хууль тогтоомжийн талаар тогтмол зааварчилгаа өгч, археологийн дурсгалт газрууд болон түүхийн дурсгалт газруудын ойр орчимд мөрдөх зохих ёс зүй, түүнчлэн олдворыг худалдан авч, Иракаас гаргах хууль эрх зүйн үр дагаврын талаар дэлгэрэнгүй тайлбарласан товхимол тарааж, Иракийн эртний эд зүйлсийг хууль бусаар тээвэрлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар цэргийн цагдаа нарыг сургаж, зарим төрлийн соёлын үнэт зүйлийг таних талаар сургалт хийжээ.

64. ЮНЕСКО зэвсэгт мөргөлдөөн болон тогтворжуулах ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хамгаалах талаар цэргийн болон холбогдох албан хаагчдад зориулсан сургалтын олон төрлийн материалыг боловсруулсан. Үүнд Мали дахь НҮБ-ын Олон хэмжээст нэгдсэн тогтворжуулах ажиллагаанд оролцогч цэргийн болон цагдаагийн албан хаагчдад зориулан 1999 оны II Протокол болон Мали Улсын соёлын өвийг хамгаалах нь (2013) цэргийн гарын авлагын хавсралт, товхимол зэргийг дурдаж болно.
65. ЮНЕСКО, Олон улсын Улаан загалмайн хороо (ОУУЗХ) болон Цэнхэр бамбайн зарим үндэсний хороод (§§229–231, 234–238-р зүйлийг харах) зэрэг байгууллагууд зэвсэгт хүчинд соёлын үнэт зүйлийг хамгаалах талаар зааварчилгаа өгөх боломжтой. Зэвсэгт хүчнээ энэ талаар хангалттай сургах туршлага, чадавх дутмаг улс орнууд ЮНЕСКО, ОУУЗХ болон тухайн улсад нь Цэнхэр бамбайн үндэсний хороо байдаг бол холбоо тогтоож, тусламж авахыг зөвлөж байна.

В. ЦЭРГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНУУД

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улсууд зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг хүндэтгэх, тэдгээрийг хамгаалах үүрэгтэй иргэний байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажиллахад чиглэсэн ажлыг төлөвлөх болон зэвсэгт хүчиндээ тайван цагийн алба байгуулах эсвэл мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ёстой. Конвенцод нэгдэн ороогүй улс орнууд ч мөн адил хүчин чармайлт гаргах ёстой.

66. 1954 оны Гаагийн Конвенцын 7 дугаар зүйлийн 2-т Конвенцод нэгдэн орсон улсууд зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг хүндэтгэх, тэдгээрийг хамгаалах үүрэгтэй иргэний байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажиллахад чиглэсэн ажлыг төлөвлөх болон зэвсэгт хүчиндээ тайван цагийн алба байгуулах эсвэл мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ёстой гэж заасан байдаг. 1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн ороогүй улс орнууд ийм төрлийн мэргэжилтнүүдтэй цэргийн нягт уялдаа холбоотой ажиллах нь практик ач холбогдол ихтэй тул зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд соёлын үнэт зүйлийг хамгаалах үүрэгтэй ийм албадыг байгуулах, үйл ажиллагаагаа төлөвлөх нь шилдэг туршлага болно.
67. 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хамгаалалт” гэдэг нь гал түймэр, барилга байгууламжийн нуралтаас онцгой байдлын үед соёлын хөдлөх

үнэт зүйлийг хамгаалах, эрдэлтэй газраас зайлуулах, газар дээр нь зохих хамгаалалтаар хангах зэрэг соёлын үнэт зүйлийг зэвсэгт мөргөлдөөний урьдчилан таамаглахуйц үр дагавраас хамгаалах арга хэмжээг хэлнэ. “Соёлын үнэт зүйлийг хамгаалахад үүрэг бүхий Иргэний байгууллагын удирдах албан тушаалтнууд” гэдэгт эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх эрх бүхий үндэсний байгууллагууд орно.

- 68.** Төрөөс зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд байгуулахаар тайван цагт төлөвлөж байгаа бол холбогдох алба нь байнгын бүрэлдэхүүнтэй байх шаардлагагүй. Үүний нэгэн адил зэвсэгт мөргөлдөөн гарсан үед соёлын үнэт зүйлийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цэргийн тусгай алба хаагчид байнгын орон тооны цэргийн мэргэжилтэн байх шаардлагагүй. Улсаас нөөцийн алба хаагчид эсвэл мөргөлдөөн дэгсэн үед үүрэг гүйцэтгэх ажилтнууд, ялангуяа тайван цагт археологич эсвэл соёлын үнэт зүйлийн бусад холбогдох мэргэжлээр ажиллаж байсан албан хаагчдаар үүрэг гүйцэтгүүлэхээр зохион байгуулж болно. Эдгээр мэргэжилтнүүд нь хуурай зам, тэнгисийн цэрэг болон агаарын нисэх хүчний цэргийн албан хаагчид байх албагүй. Цэрэгжсэн хууль сахиулах байгууллагад харьяалагдах мэргэжилтнүүдэд түшиглэн зохион байгуулсан албадын жишээнд Италийн *Arma dei Carabinieri*, Франц дахь *Gendarmerie* эсвэл Испани дахь *Guardia Civil* зэргийг дурдаж болно. Түүгээр ч барахгүй улсаас нэг албаны боловсон хүчинд цэргийн төлөвлөлтөд зөвлөх үүрэг оноох, өөр нэг албанд эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх музей, археологийн дурсгалт газруудыг хамгаалах зэрэг бусад үүрэг даалгаврын талаар зөвлөгөө өгүүлэхээр үүрэг оноох зэрэг тодорхой үүрэг даалгаврыг хуваарилан өгч болно. Мэргэшсэн байдал, туршлагаас үүдэн практик дээр ийн зөвлөх боломж өргөн байдаг. Товчдоо энэ төрлийн үүрэг гүйцэтгүүлэхээр төрөөс мэргэшсэн боловсон хүчнийг төр өөрийн үзэмжээр зохион байгуулах эрхтэй.

1954 оны Гаагийн Конвенцын 7(2)-д заасан төрөлжсөн алба, боловсон хүчний нэг жишээ нь Дэлхийн 2-р дайны үед байгуулсан Европ дахь урлаг, түүхийн дурсгалыг хамгаалах Америкийн комисс ("Roberts Commission")-ын Хөшөө дурсгал, дүрслэх урлаг, архивын алба (MFA&A) бөгөөд тус албаны ажилтнуудыг "хөшөө дурсгалын албаныхан" гэж нэрлэж байсан нь түүхэнд тэмдэглэгджээ. Уг албанаас АНУ-ын армийн жанжин штабт музейн албаны хүмүүс, урлагийн түүхчдийг татан оролцуулж, мэргэшсэн офицер болгон бэлтгэж, эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх урлаг соёл, түүхийн объект, барилга байгууламж, дурсгалт газруудын байршлыг тогтоох, хамгаалалтад анхаарал тавих талаар командлагч нарт зөвлөгөө өгөх зорилгоор АНУ-ын цэргийн бие бүрэлдэхүүнд оролцуулан, армийн штабуудад харьяалуулж байв. Үүний зорилго нь соёлын үнэт зүйлийг шаардлагагүй нөхцөлд сүйтгэх, хохирол учруулахаас сэргийлэх, түүнчлэн АНУ-ын цэрэг болон нутгийн ард иргэд хулгайлах, сүйтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох, шийтгэл хүлээлгэхэд оршиж байв. 1920-иод онд Иракийн Ур хотод малтлага хийж байсан археологич Сэр Леонард Вулли Британийн армидалба байгуулан Дайны албаны иргэний асуудал эрхэлсэн даргын Археологийн зөвлөхөөр ажиллаж байв. Ийм төрлийн үйлчилгээг анх АНУ ч биш, Их Британи ч биш, харин Герман Улс зохион байгуулж байжээ. Дэлхийн нэгдүгээр дайны үед урлагийн түүхийн тэргүүлэх профессорын удирдсан Кунстчуцын (урлагийг хамгаалах) корпусыг байгуулсан бөгөөд Кунстчуцууд дэлхийн 2-р дайны үед баруун болон өмнөд Европт идэвхтэй ажиллаж, Германы анги нэгтгэлүүд соёлын үнэт зүйлийг дээрэмдсэн тохиолдлыг шалгаж байв.

- 69.** Орчин цагт газар газрын улс орны зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах үүрэг бүхий албан хаагчид байдаг болжээ.

Arma dei Carabinieri албаны бүрэлдэхүүнд багтах цэрэгжүүлсэн цагдаагийн алба болох Италийн Соёлын өвийг хамгаалах Карабиниери алба (Соёлын үнэт зүйлийг хамгаалах Карабиниери төв 'TPC') Косово, Ирак зэрэг мөргөлдөөн дэгдсэн бүс нутагт соёлын дурсгалт газруудыг дээрэмдэх, сүйтгэхээс урьдчилан сэргийлэх, хулгайлагдсан эд зүйлийг илрүүлэн, буцаан авах чиглэлд амжилттай ажиллаж байна. (Косовогийн тухай баримтыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1244 (1999) тогтоолын хүрээнд ойлгоно.)

Австри Улсын соёлын үнэт зүйлсийг цэргийн хүчээр хамгаалах, Соёлын өвийг цэргийн хамгаалалтад авах тухай удирдамж (2009 оны 12-р сар), мөн иргэн-цэргийн харилцах албаны тухай зэвсэгт хүчний удирдамжаар үйл ажиллагааны чиг үүргийг нь тодорхойлсны үндсэн дээр байгуулагдсан Австрийн армийн соёлын өвийг цэргийн хамгаалалтад авахад зуучлах офицерын албаны туршлага мөн шилдэг жишээ болдог.

АНУ, Польш улсууд мөн мэргэжлийн археологичдыг цэргийн хүчиндээ харьяалуулан ажиллуулах талаар санаачилгатай ажилласан туршлагатай ажээ.

- 70.** Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон төрөлжсөн алба үүрэг гүйцэтгэхээр томилогдохдоо зөвхөн эрх бүхий иргэний байгууллага төдийгүй орон нутгийн соёлын өв хариуцсан бусад мэргэжилтнүүд, орон нутгийн иргэдтэй харилцаа холбоотой ажиллах ёстой бөгөөд ингэснээр цэргийн ажиллагааны явцад соёлын үнэт зүйлийг хамгаалах талаар үр дүнтэй ажиллаж чадна.

IV. ЦЭРГИЙН ДАЙСАГНАСАН АЖИЛЛАГААНЫ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

A. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЯЛГАН ТОДОРХОЙЛОХ

- 71.** Цэргийн дайсагнасан ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хамгийн үндсэн урьдчилсан нөхцөл бол хаана, ямар соёлын үнэт зүйл байгааг тодорхойлж, цэргийн ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх ажиллагаанд оролцох талуудад уг мэдээллийг үр дүнтэй арга замаар хүргэх явдал юм.
- 72.** Тухайн нутаг дэвсгэрт байгаа соёлын үнэт зүйлийг тодорхойлох практик ажил нь тус нутаг дэвсгэрт байгаа түүх, урлаг, архитектурын ач холбогдолтой ямар объект, байгууламж, дурсгалт газрууд нь “соёлын үнэт зүйл”-ийн хамгаалалтад хамрагдахуйц чухал ач холбогдолтой вэ гэдэг эрх зүйн асуудлаас ялгаатай. Цэргийн хүчнийхэн тухайн улсын соёлын өвд чухал ач холбогдолтой аливаа объект, тухайлбал аль нэгэн музей байдгийг, түүний байршлыг урьдчилан мэдсэнээр хуулийн хамгаалагдах ёстой “соёлын үнэт зүйл”-д хамаарна гэдгийг мэдэх нь илэрхий боловч нэн түрүүнд тухайн музей байгаа тухай, түүний байршлыг анхааралдаа авах ёстой. Тиймээс цэргийн дайсагнасан ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хамгаалахын тулд цэргийн хүчний хамгийн чухал үүрэг бол тухайн нутаг дэвсгэрт хаана, ямар түүх, урлаг, архитектурын ач холбогдолтой объект, байгууламж, дурсгалт газрууд байгааг нарийвчлан тогтоох явдал юм.
- 73.** Соёлын үнэт зүйл байдаг гэдгийг, тэдгээрийн байршлыг тогтооход цэргийн хүчин янз бүрийн арга замуудыг ашигладаг.
- 74.** 1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улс нь соёлын үл хөдлөх болон хөдлөх үнэт зүйлсэд эсвэл түүнийг байршуулсан барилгад ялгах

тэмдэг нааж болно (§§213–218 дугаар хуудаснаас үзнэ үү). Гэвч бодит байдал дээр аль ч улс өөрийн соёлын үнэт зүйл болгонд ялгах тэмдэг наадаггүй бөгөөд ихэнх улсууд үүнийг огт ашигладаггүй. Үүнээс гадна, ялгах тэмдэг нь далд газар байх, энгийн нүдээр болон ердийн харах хэрэгсэл технологийн тусламжтайгаар харах боломжгүй бол цэргийн хүчинд мэдэгдэхгүй болдог.

- 75.** Цэргийн мэргэжилтнүүд тухайн улсын соёлын өвийг бүрдүүлдэг соёлын үл хөдлөх үнэт зүйлийн бүх сангуудыг бүртгэсэн ямар нэгэн бүртгэл болон соёлын хөдлөх үнэт зүйлсийн тооллогын баримт материал зэргийг олох шаардлагатай болдог. Ихэнх тохиолдолд энэ нь бусад улсын соёлын үнэт зүйл гэхээсээ илүү цэргийн хүчний өөрийн улсын үнэт зүйлстэй холбоотой байдаг. Зарим улс өнгөрсөн хугацаанд цэргийн дайсагнасан ажиллагааны үеэр, эсвэл түр зогсох үеэр үндэсний соёлын үнэт зүйлийн бүртгэлийг бусад улсуудад түгээхээр ЮНЕСКО-д шилжүүлсэн тохиолдол гарч байсан бөгөөд цэргийн хүчин ийм бүртгэл хүлээн авсан эсэх, эсвэл өөр хэлбэрээр олох боломжтой эсэхийг холбогдох иргэний эрх бүхий байгууллагаар дамжуулан байнга шалгаж байх ёстой.
- 76.** Зэвсэгт хүчний өөрийн улсын соёлын өвтэй холбоотой газар зүйн координатууд эсвэл бусад заалт мэдээллийг цэргийн мэргэжилтнүүдэд дамжуулснаар наад зах нь анхан шатны үндсэн мэдлэгтэй байх боломжийг олгодог. Ховор тохиолдолд, жишээлбэл Эль Сальвадор улс ЮНЕСКО-д зарим соёлын дурсгалт газруудын газрын зургийг олон улсад түгээх зорилгоор өгч байсан жишээ бий. Мөн Ливи улс 2011 онд Олон улсын музейн зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт “анхаарал хандуулах зүйлсийн жагсаалт” бэлтгэн хүргүүлсэн, 2013 оны 7-р сард Энх тайвны төлөөх өв, “UK Blue Shield” байгууллагаас Алеппо хотын “цохилт өгөхгүй байх объектын жагсаалт” гэх албан бус жагсаалт (§98-р зүйлийг харах) гаргаж байв. Засгийн газрын бус байгууллагаас соёлын онцгой ач холбогдолтой үл хөдлөх эд зүйлийн жагсаалт, байршлыг цахим хэлбэрээр нийтэд нээлттэй түгээж болно.

2012 онд Мали Улсын Соёлын яам ЮНЕСКО-ийн дэмжлэгтэйгээр Малигийн хойд хэсэг дэх хамгаалагдсан түүхэн байгууламж, дурсгалт газруудын тайлбар, газрын зураг, гэрэл зураг, газарзүйн координатыг агуулсан “Өв соёлын паспорт” Passeport pour le patrimoine нэртэй товхимлыг 2012 оны 11-р сард гаргажээ. Уг товхимол нь зэвсэгт хүчний гишүүдэд зориулагдаагүй ч 1954 оны Гаагийн Конвенц болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бусад хуулиар хамгаалагдсан соёлын үнэт зүйлийг тодорхойлоход ач холбогдолтой эх сурвалж юм.

- 77.** Хамгийн наад зах нь Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн аливаа соёлын дурсгалт газруудын оршин байгаа байдал, багцаа координатыг Дэлхийн өвийн Конвенцын вэб сайтаар дамжуулан онлайнаар хялбархан авах боломжтой. Гэвч уг жагсаалтад соёлын хөдлөх үнэт зүйлийн цуглуулга ороогүй юм. Нэмж дурдахад, Олон улсын бүртгэлд орсон Тусгай болон Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн оршин байгаа, ерөнхий байршлыг онлайнаар шууд үзэх боломжтой (§§50–55 болон хавсралт II-р зүйлийг харах). Мөн Дэлхийн өвийн Конвенцын вэб сайтаас Конвенцод нэгдэн орсон улсуудаас Дэлхийн өвийн хороонд ирүүлсэн “урьдчилсан жагсаалт”-ыг онлайнаар авах боломжтой (Хавсралт II-р зүйлийг харах). Гэсэн хэдий ч эдгээр төрөл бүрийн жагсаалт, бүртгэлд багтсан соёлын үнэт зүйл нь 1954 оны Гаагийн Конвенц, түүний протоколууд, олон улсын хүмүүнлэгийн заншлын эрх зүй, олон улсын эрүүгийн хэргийн заншлын эрх зүйн дагуу зэвсэгт мөргөлдөөний үед улс тус бүрд хамгаалагдсан соёлын үл хөдлөх хөрөнгийн багахан хэсгийг төлөөлдөг гэдгийг дахин хэлэх нь зүйтэй. Өгөгдсөн координатууд нь зорилтот төлөвлөлтөд шаардлага хангахуйц байж чаддаггүй гэдгийг ч мөн онцлон тэмдэглэх нь зүйтэй. Гэвч эдгээр мэдээлэл холбогдох газруудын байршлын талаарх ерөнхий ойлголтыг өгдгөөрөө үнэ цэнтэй байдаг.
- 78.** Эдгээр боломжит хувилбараас гадна цэргийн ажиллагааны өөр өөр үе шатаас ихээхэн шалтгаалан соёлын үнэт зүйлийг тодорхойлох олон хэлбэрийн цэргийн шилдэг туршлага бий.
- 79.** Урьдчилсан сургуулилтын бэлтгэлийг өргөн хүрээнд зохион байгуулж болно. Нэг талаас зэвсэгт хүчний мэргэшсэн ажилтнууд, нөгөө талаас археологи, түүхийн болон урлагийн түүх, архитектур, музейн эрхлэгчид зэрэг мэргэжилтнүүд, галерей, номын сан, архив, шинжлэх ухааны цуглуулга хариуцсан кураторууд, эдгээр салбарын мэргэжлийн холбоод, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудын холбогдох

боловсон хүчин хамтран зохион байгуулна. Энэ нь хүний нөөцийн боломж бололцоог бүрэн ашиглах, түүнчлэн 2015 онд ЮНЕСКО, НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн НҮБ-ын Үйл ажиллагааны хиймэл дагуул хөтөлбөр хооронд байгуулсан Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу боломжит хиймэл дагуулын зураг, дүрс ашиглах болон холын зайн төхөөрөмжийн хүчин чадлыг, тухайлбал нисгэгчгүй онгоц (дрон)-ыг бүрэн ашиглах шаардлагатай гэсэн үг юм. Гол зорилго нь цэргийн ажиллагаа явагдах “соёлын газар нутаг”-ийн талаар аль болох нарийвчилсан газрын зураг ба баримт бичиг урьдчилан бэлтгэх замаар зэвсэгт ажиллагааны явцад соёлын өвийг хамгаалах цэргийн ажиллагааг хөнгөвчлөхөд оршино. Чингэхдээ соёлын өвийг явган цэргийн болон агаарын довтолгооноос хамгаалах, хээрийн бааз барих явцад санамсаргүй гэмтээх эсвэл гэмт хэргийн бүлэглэлүүд тонож дээрэмдэхээс сэргүүлэх юм.

- 80.** Гэвч мэдээлэл цуглуулах нь зөвхөн эхний алхам юм. Цуглуулсан мэдээллийг цэргийн ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх ажиллагаанд оролцож буй хүмүүст хүртээмжтэй хүргэж, ашиглах боломжоор хангах ёстой. Үүнийг хэрхэн гүйцэтгэх нь тухайн цэргийн ажиллагаанаас ихээхэн шалтгаална. Цохилт өгөх шийдвэр гаргах тохиолдолд албан ёсны “цохилт өгөхгүй байх байршил”-ын жагсаалтуудыг нэгтгэж, цэргийн холбогдох мэдээллийн санд оруулах нь (§98-р зүйлийг харах) зүйтэй. Хуурай газрын довтолгоо болон түүний дараах цэргийн хүч хэрэглэн эзлэх ажиллагааг төлөвлөх тохиолдолд нарийвчилсан, тусгайлан тэмдэглэсэн газрын зургийг бэлтгэх, түгээх ажлыг хамруулан хийж болно.

АНУ-ын цэргийн археологичид бүс нутгийн асуудлаар мэргэшсэн албаныхан болон байгаль орчны газарзүйн мэдээллийн системийн шинжээчидтэй хамтран Афганистан болон Иракийн археологийн зургийг цэргийн зориулалтаар тусгайлан бэлтгэсэн бөгөөд АНУ-ын Агаарын цэргийн хүчний хэлний төвөөс Иракийн Эртний эдлэлийн Төрийн Зөвлөлийн боловсруулсан атласыг англи хэл рүү хөрвүүлэх ажлыг хийж байв.

- 81.** Цэргийн мэргэжилтнүүдэд зориулан бэлтгэн хүргүүлсэн мэдээлэл нь боломжтой бол тухайн объект, барилга байгууламж, талбайн харьцуулсан түүх, урлаг, архитектурын ач холбогдлын талаарх харьцуулсан заалт, объектын бүтэц зэрэг мэдээллийг агуулсан байх ёстой бөгөөд ингэснээр эрэмбэлэх, түүнчлэн аливаа дайралтад цэргийн давуу тал ашигласнаар соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учирч болзошгүй эсэх, учруулах

хохирлыг багасгахад тусална. Ийм төрлийн мэдээллийг довтолгооны байг тодорхойлох шийдвэр гаргагчдын төлөвлөлтөд үндэслэн “дагалдах хохирлын үнэлгээ”-д оруулах нь ашигтай байх болно. (§121 дүгээр зүйлийг үзнэ үү).

- 82.** Цэргийн анги нэгтгэлүүд хуурай газар эсвэл байлдааны хөлөг онгоцнууд усанд байраа эзэлсний дараа урьд өмнө мэдэгдээгүй байсан соёлын өв байгаа тухай, тэдгээрийн байршил, төлөв байдлыг нь тогтоох шаардлага үүсэх тохиолдол бий. Түүх, урлаг, архитектурын ач холбогдол нь тодорхойгүй объект, байгууламж, археологийн болон бусад түүхийн ач холбогдолтой газар (жишээлбэл булш, усалгааны суваг, хамгаалалтын далан) чулуун хөшөө, соёлын болон уугуул нутгийн дурсгалт газрууд, тэр ч байтугай зарим архивын цуглуулгуудыг соёлын үнэт зүйл мөн болохыг нь баталгаажуулах шаардлага гардаг. Цэргийн хүчнийхний дайран өнгөрөх объект, барилга байгууламж, газар талбайн талаар тодорхой болоогүй үед соёлын ач холбогдлыг нь үнэлэх ажлыг шинжээчдээр хийлгэнэ. Мөн археологийн болон бусад түүхэн дурсгалт газрын периметрийг тухайн улсын эрх бүхий байгууллагууд хангалттай нарийн тодорхой заагаагүй байж болох учир эдгээрийн газар зүйн хувьд хамрах цар хүрээг нарийвчлан тогтооход шинжээчдийн баг ажиллуулна. Цэргийн хүчин соёлын үнэт зүйлийг хамгаалах үүрэг бүхий тусгай алба, мэргэжилтэнтэй бол юуны өмнө тэдэнд хандах ёстой. Эдгээр ажилтнууд иргэний байгууллагын мэргэжилтнүүдээс тусламж хүсэх нь зүйтэй эсвэл шаардлагатай гэж үзэж болно. Ямар ч тохиолдолд ЮНЕСКО эсвэл бусад холбогдох байгууллагаас зөвлөгөө болон тусламж авах нь зүйтэй. Зэвсэгт хүчнийхний хувьд соёлын үнэт зүйлийг тодорхойлохдоо зөвхөн мэргэжилтнүүдийн туслалцаагаар хязгаарлах ёсгүй. Нутгийн иргэд, ялангуяа шашны болон бусад нөлөө бүхий хүмүүс нь түүхэн барилга байгууламжаас эхлээд гар бичмэлийн цуглуулга, архив зэрэг соёлын үнэт зүйлийн байршил, ач холбогдлын талаарх мэдээллийн үнэ цэнтэй эх сурвалж болдог.

Б. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ОНИЛГОО

- 83.** Соёлын үнэт зүйлтэй холбоотой асуудлуудыг байгаа тодорхойлох шийдвэрт тусгах нь олон улсын эрх зүйн үүрэг төдийгүй бодит хэрэгцээ юм. Хууль эрх зүйн хувьд энэ нь хоёр тусдаа асуудал. Нэгдүгээрт, цэргийн шийдвэр гаргагч буюу удирдлагууд тухайн соёлын үнэт зүйл довтолгоонд өртөх эсэхийг үнэлэх ёстой. Хууль эрх зүйн хүрээнд болон ихэнх тохиолдолд соёлын үнэт зүйлийг онилохыг хориглодог. Хоёрдугаарт, цэргийн шийдвэр гаргагчид цэргийн байгууламж зэрэг

хуулиар зөвшөөрсөн объектод цохилт өгөх бол ойролцоо байгаа соёлын үнэт зүйлд санаандгүй хохирол учруулах эсэх, тус хохирол нь тухайн цохилтыг өгснөөр олж авах аливаа цэргийн шууд давуу талаас илүү гарах эсэх дээр үнэлгээ хийх шаардлагатай. Энэхүү хоёр дүрэм нь халдлагыг гүйцэтгэхтэй холбоотой нэмэлт дүрмүүдээр баталгаажсан болно.

84. Гагцхүү байгаа тодорхойлох төлөвлөгөөг албажуулж, сахилга баттай дагаж мөрдсөнөөр хуурай зам, тэнгисийн болон агаарын довтолгооны үед соёлын үнэт зүйлийг хамгаалахтай холбоотой доорх дүрмийг биелүүлэх боломжтой.

(i) Соёлын үнэт зүйлийг довтолгооны объект болгох

(a) Ерөнхий заалт

Цэргийн ажиллагааны зорилгоор ашиглаагүй бөгөөд ижил төстэй цэргийн ажиллагааны давуу тал олж авах өөр арга зам байхгүй байхаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйлд довтлохыг хориглоно.

85. Дайсагнасан ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хүндэтгэхийг шаардсан хамгийн чухал үндсэн заалтуудын нэг бол тухайн соёлын үнэт зүйлсийг цэргийн ажиллагааны зорилгоор ашиглаагүй бөгөөд ижил төстэй цэргийн ажиллагааны давуу тал олж авах өөр арга зам байхгүй байхаас бусад тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудад соёлын үнэт зүйлсийг газар, тэнгис, агаарын довтолгооны бай болгохыг хориглосон явдал. Соёлын үнэт зүйлд довтлох үед энэ нь цэргийн ажиллагааны зорилгоор ашиглагдаагүй байх, эсвэл соёлын үнэт зүйлд халдсантай дүйцэхүйц цэргийн ажиллагааны давуу тал олж авах боломжтой бусад арга зам байгаа тохиолдолд соёлын үнэт зүйлд довтолсныг зөвтгөх хууль эрх зүйн үндэслэл байхгүй. Соёлын үнэт зүйлд санаатайгаар болон хууль бусаар довтолохыг дайны гэмт хэрэгт тооцох бөгөөд гэмт этгээдүүдэд олон улсын болон улсын эрүүгийн шүүх, арбитрайн шүүхээс зохих шийтгэлийг оноосон байдаг.

86. Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн тодорхойлолтын хүрээнд “довтолгоо” гэж довтолгоо эсвэл хамгаалалт гэдгээс үл хамааран эсрэг талыг хүчирхийлэх үйлдлийг хэлнэ. Соёлын үнэт зүйлийг довтолгооны объект болгох дүрэм нь тухайн соёлын үнэт зүйл халдагч талын нутаг дэвсгэрийн эсвэл бодит хяналтад ороогүй байх нөхцөл байдалд хамааралтай.

- 87.** Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулиар "Цэргийн ажиллагааны зорилго"-ыг "үндсэн шинж, байршил, зорилго, ашиглалтаараа цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулж, тухайн нөхцөл байдалд бүрэн буюу хэсэгчлэн устгах, олзолж авах, идэвхгүй болгох үйлдэл нь цэргийн ажиллагаанд бодит давуу талыг олгодог объект" гэж тодорхойлсон. Уг тодорхойлолт дахь агуулгыг хоёр шалгуураар тодорхойлно. Цэргийн ажиллагааны зорилго гэж үзэхийн тулд соёлын үнэт зүйл нь нэг буюу хэд хэдэн үндсэн шинж, байршил, зориулалт, ашиглалтаараа цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулахаас гадна довтолгооны үеэр тухайн соёлын үнэт зүйлийг устгах, олзолж авах, идэвхгүй болгох нь халдагч талд цэргийн ажиллагааны бодит давуу талыг олгоно. Мөн энэхүү тодорхойлолт нь "үр дүнтэй" ба "бодит" гэх үгсээр соёлын үнэт зүйлийн цэргийн ажиллагаанд оруулсан хувь нэмэр болон түүнийг цэргийн үйл ажиллагааны бай болгосноор үүсэж болох цэргийн ажиллагааны давуу тал нь онолын эсвэл таамаглал төдий зүйл биш харин бодит зүйл байх ёстойг онцолсон. Түүнчлэн, цэргийн "ажиллагаа"-г цэргийн ажиллагааны "оролдлого" гэх өргөн ойлголтоос илүүтэй бодит мөргөлдөөн гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, соёлын үнэт зүйл нь үндсэн шинж, байршил, зориулалт, ашиглалтаараа тулаанд хувь нэмэр оруулж буй бол цэргийн ажиллагааны зорилго хэмээн үзэж болох юм. Соёлын үнэт зүйлийг устгах, олзолж авах, цуцлах нь халдагч этгээдэд цэргийн ажиллагааны бодит давуу талыг олгодог эсэх нь өөрчлөгдөж болох бөгөөд энэ асуултад довтлох үеийн нөхцөл байдлыг харгалзан хариулах ёстой гэдгийг онцлон тэмдэглэх нь чухал.
- 88.** Соёлын үнэт зүйл нь зарим тохиолдолд цэргийн үйл ажиллагааны зорилго байж болох ч ийм тохиолдол ховор байдаг. Түүхт цайз, хуаран, зэвсгийн агуулах болон цэргийн ажиллагааны зориулалтаар баригдсан бусад түүхт зүйл зэрэг соёлын маш онцгой үнэт зүйлс нь үндсэн шинжээрээ цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулдаг гэж хэлж болно. Хэрэв ашиглахаа больсон бол тэдгээр үнэт зүйлсийг үндсэн шинжээр нь цэргийн объект гэхээсээ илүү түүхэн хөшөө дурсгал гэж тодорхойлох нь зүйтэй; хэрэв одоог хүртэл ашиглаж байгаа бол үндсэн шинжээрээ бус ашиглалтаараа цэргийн ажиллагаанд илүү үр дүнтэй хувь нэмэр оруулдаг гэж үзнэ. Үүний нэгэн адил зориулалтын хувьд дийлэнх соёлын үнэт зүйл цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулж чадахгүй ч түүхт гүүр, төмөр замын буудал, боомт зэргээр түүний "ирээдүйд ашиглах зориулалт нь чухал. Гэвч ерөнхийдөө өөр эрин үед баригдсан дэд бүтэц өнөөдөр жинхэнэ цэргийн үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж болохгүй. Байршлын тухайд тулалдааны талбарт соёлын үнэт зүйлийн байршлыг довтолж буй талын галын шугамыг хаах хаалт болгон

ашиглах боломжтой. Үүнийг эсрэг талын цэргийн ажиллагаанд оруулах хувь нэмрийг соёлын үнэт зүйлийг идэвхгүй эсвэл де факто хэлбэрээр цэргийн ажиллагаанд ашигласнаас үүдэлтэй гэж харах хэрэгтэй. Эцэст нь дүгнэж хэлэхэд ашиглалтаараа соёлын үнэт зүйл нь цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулна гэсэн хүлээлт үүснэ. Өөрөөр хэлбэл соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд ашигласан гэх нь зэвсэгт мөргөлдөөнд оролцогч тал соёлын үнэт зүйлсэд халдсан байдлаа зөвтгөх гол үндэслэл болж өгөх магадлалтай. Өдгөө соёлын үнэт зүйлийн мөн чанар, зорилго, байршил зэргийг ашиглан соёлын үнэт зүйлсэд халдсан байдлаа зөвтгөх явдал нь бараг байх боломжгүй болсон.

89. Соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор зэвсэгт харуул гаргасныг тэдгээрийг цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашигласан хэмээн үзэх үндэслэл болохгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. 1954 оны Гаагийн Конвенцод зөвхөн тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлтэй холбоотой асуудлыг тодорхой заасан боловч уг зарчим нь бүх соёлын үнэт зүйлд хамаарах нийтлэг зарчим юм.
90. Эсрэг тал цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор соёлын үнэт зүйлийг ашиглах олон янзын арга зам байж болох юм. Тухайлбал өндөрлөг газарт байрлах түүхэн цайзыг хамгаалалтын тулгуур эсвэл тулалдааны талбарыг ажиглах талбай болгон ашиглах, дундад зууны үеийн цамхаг дээр мэргэн буудагч байрлуулах зэргээр соёлын үл хөдлөх зүйл буюу түүхэн дурсгалт газруудад байршил эзлэх нь хамгийн тод жишээ юм. Мөн хүчээ зузаатгах, нэмэгдүүлэх зорилгоор түүхт гүүр, төмөр замын өртөөг ашиглах зэргээр довтлох эсвэл хамгаалах байрлалд нэвтрэх, гарахдаа соёлын үл хөдлөх хөрөнгийг ашиглах, музей, галерей, түүхийн дурсгалт байшинд зэвсэг, бусад цэргийн хэрэгсэл, сум хадгалах зэрэг арга байж болох юм.
91. Иймэрхүү бүх тохиолдолд дараах гурван санааг давтан сануулж хэлэх нь чухал байна. Үүнд:
92. Нэгдүгээрт, аль нэг тал цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор соёлын үнэт зүйлийг ашигласан явдал нь дангаараа эсрэг тал тухайн үнэт зүйлд довтлохыг хууль ёсны болгодоггүй. Цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглагдаж байгаа соёлын үнэт зүйл нь гагцхүү цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулсан тохиолдолд л цэргийн үйл ажиллагааны зорилго болох боломжтой.
93. Хоёрдугаарт, соёлын үнэт зүйл нь цэргийн ажиллагаанд ямар хувь нэмэр оруулах болон хувь нэмэр оруулж чадах эсэхээс үл хамааран зөвхөн

тухайн үеийн нөхцөл байдалд соёлын үнэт зүйлийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн устгах, олзолж авах, идэвхгүй болгох нь цэргийн ажиллагааны бодит давуу тал олгох тохиолдолд л тэдгээр соёлын үнэт зүйлийг цэргийн үйл ажиллагааны зорилго гэж үзнэ.

- 94.** Эцэст нь соёлын үнэт зүйлийг цэргийн үйл ажиллагааны зорилго болгох эсэх нь түүнийг довтолгооны объект болгохоос өмнө даван туулах ёстой хоёр саадын эхнийх юм. Соёлын үнэт зүйл нь цэргийн үйл ажиллагааны зорилго болсон ч үүнтэй төстэй цэргийн давуу тал олж авах өөр хувилбар байхгүй тохиолдолд л соёлын үнэт зүйлд довтлохыг зөвшөөрнө. Товчоор хэлбэл, соёлын үнэт зүйл рүү довтлох нь эцсийн арга юм. Эсрэг тал соёлын үл хөдлөх үнэт зүйлийн дотор байрласан бол дайтагч тал дотор нь байгаа эсэргүүцэгчдийг бүслэн авч бууж өгөхийг хүлээх эсвэл соёлын үнэт зүйлийг хохирол учруулахгүйгээр зэвсэгт этгээдүүдийн заналхийллийн хүчийг сулруулахаар мэргэн буудагчдыг байрлуулснаар дээрх аргыг хэрэгжүүлэх боломжтой. Эсрэг тал түүхт гүүр, төмөр замын өртөөг хүчээ зузаатгах, нэмэгдүүлэхэд ашиглаж байгаа тохиолдолд тэдгээр түүхт өвүүдийг бус харин түүнд дөхөж очих зам эсвэл төмөр замыг устгах эсвэл хангалттай доройтуулах боломжтой. Өөрөөр хэлбэл, цэргийн хүчин соёлын үнэт зүйл рүү довтлох тушаал өгөхөөсөө өмнө цэргийн ажиллагааны өөр боломжийн талаар удаан, нухацтай бөгөөд бүтээлчээр сэтгэж бодох ёстой.

Мөргөлдөөнд оролцогч талууд довтолгоонд өртөх объектууд нь соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулахын тулд боломжит бүх арга хэмжээг авах ёстой.

- 95.** Соёлын үнэт зүйлд довтлохыг зохих ёсоор хориглох эсэх нь бодит байдал дээр довтолгоонд өртөх объектыг соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулахаас хамаарна. Иймээс зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд энэ зорилгоор боломжтой бүх зүйлийг хийх үүрэгтэй.
- 96.** Довтолгоонд өртөх объектууд нь соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулах арга хэмжээ авах боломж нь тухайн нөхцөл байдлаас хамаарна. Тухайлбал цэргийн хүчний энэхүү баталгаажуулалтыг хийх боломж нь урьдаас бэлтгэсэн дайралт хийж байна уу эсвэл өөрийгөө хамгаалах байдлаар яаралтай гал нээж байгаа юу гэдгээс үүдэн харилцан адилгүй байж болох бөгөөд урьдаас бэлтгэсэн дайралт хийх үед төрөл бүрийн аргаар шаардлагатай мэдээлэл олж авах боломж байдаг. Үүний нэгэн адил газраас агаар хооронд эсхүл агаараас агаарт довтлоход хамгаалах систем байхгүй тохиолдолд соёлын үнэт зүйлс

байх магадлалтай объектуудыг нам дор газарт өдрийн цагаар нислэг үйлдэж мэдээлэл цуглуулах боломжтой. Харин эсрэгээрээ тухайн объектын ойролцоо агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах гал эсвэл сөнөөгч онгоцны довтолгооноос хамгаалах хүчтэй хамгаалалт байгаа тохиолдолд тухайн объектыг соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулах өөр арга хэмжээ авахад хүргэнэ. Гэсэн хэдий ч тухайн үеийн нөхцөл байдалд хууль ёсны дагуу тухайн соёлын үнэт зүйл нь цэргийн үйл ажиллагааны зорилго байхаас бусад тохиолдолд нөхцөл байдал ямар байгаагаас үл хамааран цэргийн хүчин нь соёлын үнэт зүйлд цохилт өгөхөөс зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийх ёстой. Бүх мэдээллийг хянаж, үнэлэн хэрэгжүүлж боломжтой бүх зүйлийг хийхийг энэхүү зорилт нь шаарддаг билээ.

97. Төлөвлөсөн довтолгооны хүрээнд довтолгоонд өртөх объектууд нь соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулахын тулд онилох процессыг боловсруулж, тогтмол ашиглах нь чухал. Онилох процесс нь ажиллагааны явцад онилох шийдвэр гаргадаг цэргийн шийдвэр гаргагчдын стандартчилагдсан, дэс дараатай ажиллагаа юм.
98. Байгаа сонгох ажиллагааны чухал үе шат бол "байгаа онилох" бөгөөд энэ үед цэргийн удирдлага байгаа сонгохдоо урьдчилсан байдлаар хязгаарлалт тогтоож болно. Ийм хязгаарлалтын нэг нь "довтлохыг хориглосон" жагсаалт бөгөөд цэргийн удирдлага энэ жагсаалтад цохилт өгөхийг хориглосон тодорхой барилга байгууламж, объектуудыг оруулж болох бөгөөд үүнд Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль эсвэл холбогдох Оролцооны дүрмээр хамгаалагдсан болон өөр ямар ч тохиолдолд довтолхогүй байх объектуудыг багтааж болно.
99. Байгаа сонгох явцад цэргийн удирдлагуудад ашиглахыг хориглосон объектын жагсаалтад онцгой ач холбогдол бүхий соёлын үнэт зүйлийг оруулахыг зөвлөдөг.

Цохилт өгөхийг хориглох соёлын дурсгалт газруудын жагсаалтыг Ирак, Ливи, Сири, Мали зэрэг соёлын дурсгалт газрууд ихтэй улсуудад явуулсан цэргийн ажиллагаанд амжилттай ашиглаж ирсэн.

Иймэрхүү жагсаалтыг нэгтгэн гаргахын тулд соёлын үнэт зүйлийн мэргэжилтнүүд, археологич, урлаг судлаач, архитектор, музейн куратор зэрэг бусад мэргэжилтнүүд, түүнчлэн холбогдох төрийн бус байгууллагууд, Цэнхэр бамбайн олон улсын хороо буюу Зэвсэгт мөргөлдөөний үед

соёлын өвийг хамгаалах дотоодын сайн дурын байгууллага болон ЮНЕСКО-г оролцуулбал зохино.

Үйл ажиллагааны нэгдсэн хамгаалалт буюу улс орнууд нэгдэн Ливи дэх газар дах байнд агаараас цохилт өгөх үеэр боловсруулсан байг онилох төлөвлөгөө нь цохилт өгөхийг хориглох соёлын үнэт зүйлийн жагсаалтыг боловсруулж, хэрэгжүүлсний жишээ юм. Шинжээчид, батлан хамгаалахын тагнуулын ажилтнууд зэрэг хүмүүстэй тогтоосон хувийн холбоо харилцаанд тулгуурлан тэрхүү жагсаалтад оруулах соёлын үнэт зүйлийн мэдээллийг цуглуулсан. Үүний зэрэгцээ, Ливийн түүхч, археологич, засгийн газар хоорондын, төрийн болон төрийн бус байгууллага, АНУ-ын Цэнхэр бамбайтнуудын хорооны иргэний эрх зүйн хуульчидтай хамтран Ливийн соёлын дурсгалт газруудын нарийвчилсан жагсаалтыг гаргажээ. Энэ жагсаалтыг байг онилох төлөвлөгөө боловсруулах тагнуулын ажилтнуудад дамжуулж, мэдээллийн санд байршуулсан. АНУ-ын Цэнхэр бамбайтнуудын хорооны жагсаалтад орсон газрууд, түүнчлэн мэдээллийн санд байгаа соёлын ач холбогдол бүхий бусад газруудыг байгаа онилох явцад албан ёсны жагсаалтад оруулсан. Ажиллагаа эхэлснээс хойш хэдхэн хоногийн дараа ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Ливийн хамгаалах ёстой соёлын үнэт зүйлийн нэмэлт жагсаалтыг НАТО-ийн Ерөнхий нарийн бичгийн даргад илгээсэн.

Байг онилох ажиллагааг төлөвлөх үйл явцад civilian expert/иргэний мэргэжилтэн оролцуулах нь зүйтэй бөгөөд үүнийг түр зуурын шинжтэй биш стандарт болгон тогтоох нь зүйтэй.

Довтолгооны объект нь соёлын үнэт зүйл болох нь тогтоогдвол мөргөлдөөнд оролцогч талууд довтолгоог цуцлах эсвэл түр зогсоох ёстой.

- 100.** Хамгийн боломжит, шилдэг тагнуулын мэдээ ч буруу байж болно. Мэдээллийг бүрэн цуглуулах боломж хомс, хугацаа давчуу нөхцөлд довтолох талаар анхны шийдвэрийг гаргах тохиолдол бас бий. Аль ч тохиолдолд довтолгооны байг баталгаажуулах дараа дараагийн үйл явцад довтолгоонд өртөх объект нь соёлын үнэт зүйл болохыг тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд халдагч этгээд довтолгоог цуцлах буюу түр зогсоох үүрэгтэй.

- 101.** Объект соёлын үнэт зүйл гэдэг нь тогтоогдсон нөхцөлд довтолгоог цуцлах, түр зогсоох үүрэгтэй гэдэг нь тухайн халдлагыг зогсоох эсвэл цуцлах боломжтой арга замаар үйлдэхийг шаарддаг гэсэн үг. Тагнуулын мэдээ алдаатай байсан талаар мэдээ авбал довтолгоог удирдаж эсвэл гүйцэтгэж байгаа албан тушаалтанд техникийн талаасаа довтолгоог зогсоох боломжтой байх ёстой. Жишээлбэл өмнөх тушаалыг цуцлах, гал зогсоох, алсын удирдлагат зэвсгийг байндаа хүрэхээс нь өмнө устгах эсвэл наад зах нь зогсоох зэрэг арга хэмжээ авах боломжтой байх ёстой. Энэ үүрэг мөн оролцооны дүрэм болон тусгай заавар бусад дагаж мөрдөх заавар тушаалд тусгагдсан байна. Жишээлбэл, цэргийн объект гэж үзэж байсан зүйл нь хамгаалалтад байх соёлын үнэт зүйл болох нь тогтоогдох үед нисгэгчид даалгавраа гүйцэтгэхгүй.

Соёлын үнэт зүйл цэргийн ажиллагааны зорилго байх үед түүнд довтолхоос өөр хувилбар байхгүй тохиолдолд 1999 оны II Протоколын дагуу мөргөлдөөнд оролцогч талын соёлын үнэт зүйлд довтолж шийдвэрийг нөхцөл байдалд нийцэхгүй байгаагаас бусад тохиолдолд нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг командалж буй офицер гаргах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй тал соёлын үнэт зүйлд довтолж шийдвэр гаргах тохиолдолд энэ заалт мөн хамаарна.

- 102.** Олон улсын болон олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн ажиллагааны объект соёлын үнэт зүйл байх, түүнд довтолхоос өөр боломжит хувилбар байхгүй тохиолдолд 1999 оны II Протоколын б(с)-д зааснаар Протоколд нэгдэн орсон улсын эсвэл Протоколд нэгдэн орсон улстай тулалдаж буй зэвсэгт бүлэглэлийн соёлын үнэт зүйлд довтолж шийдвэрийг нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг командалж буй офицер гаргах ёстой. Энэ заалтын логик нь шийдвэр гаргах албан тушаалтны цол өндөр байх тусам холбогдох мэдээлэл олж авах боломж нэмэгддэг, мөн шийдвэр гаргагчийн нөхцөл байдалд тохируулах чадвар, туршлага их байна гэж үзэхтэй холбоотой. б(с) заалт нь нөхцөл байдалд тохирохгүй бол энэхүү процедурын шаардлагыг сулруулдаг.
- 103.** б(с) заалт 1999 оны II Протоколыг заавал биелүүлэх үүрэг хүлээгээгүй зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талд ч мөн адил хамаарах учир уг заалт практик ач холбогдол ихтэй юм.

Соёлын үнэт зүйл цэргийн ажиллагааны объект байх үед, түүнд довтлохоос өөр хувилбар байхгүй тохиолдолд 1999 оны II Протоколын дагуу мөргөлдөөнд оролцогч тал соёлын үнэт зүйлд довтлохоор шийдсэн бол боломж олдмогц урьдчилан анхааруулах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй тал соёлын үнэт зүйлд довтлох шийдвэр гаргах тохиолдолд энэ заалт мөн хамаарна.

- 104.** Олон улсын болон олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн ажиллагааны объект соёлын үнэт зүйл байх, түүнд довтлохоос өөр боломжит хувилбар байхгүй тохиолдолд 1999 оны II Протоколын 6(d)-д зааснаар соёлын үнэт зүйлд довтлохдоо урьдчилан анхааруулахыг шаарддаг. Уг дүрмийн логик нь хоёр үндэслэлтэй. Нэгдүгээрт, соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглаж байгаа бол урьдчилан анхааруулах нь эсрэг талд тийнхүү ашиглахаа зогсоох боломжийг олгодог бөгөөд ингэснээр тухайн соёлын үнэт зүйл цэргийн объект байхаа больж, довтолгоонд өртөхөөс зайлсхийдэг. Хоёрдугаарт, ямар ч тохиолдолд урьдчилан анхааруулах нь эсрэг талд соёлын үнэт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх, эсвэл зохих ёсоор хамгаалах зэргээр соёлын үнэт зүйл болон байрлаж байгаа соёлын хөдлөх үнэт зүйлд учрах хохирлыг багасгах бодит арга хэмжээ авах боломжийг олгодог (145–149-р зүйлийг харар).
- 105.** 6(д) заалтын практик ач холбогдол нь 1999 оны II Протоколыг заавал биелүүлэх үүрэг хүлээгээгүй зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талд мөн адил хамаардагт байгаа юм.

(б) **Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн хувьд баримтлах тусгай заалт**

1999 оны II Протоколыг заавал биелүүлэх үүрэг хүлээсэн мөргөлдөөнд оролцогч талууд дараахаас бусад тохиолдолд өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг довтолгооны объект болгохыг хориглоно. Үүнд:

- **ашиглалтаараа цэргийн объект болгох;**
- **довтолгоо нь тийнхүү ашиглахыг зогсоох цорын ганц боломжит арга зам болох;**
- **соёлын үнэт зүйлд хохирол учрахаас зайлсхийх, учрах хохирлыг багасгах довтолгооны арга хэрэгслийг сонгохдоо бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;**
- **өөрийгөө даруй хамгаалах шаардлага зөвшөөрөхгүй байхаас бусад тохиолдолд довтолох тушаалыг командлалын дээд түвшинд гаргах, ашиглахаа зогсоохыг эсрэг талд урьдчилан анхааруулах, эсрэг талд нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах хугацаа өгөх зэрэг болно.**

- 106.** 1954 оны Гаагийн Конвенцын II Протоколын 12, 13-р зүйлээр Протоколын 3-р бүлэгт зааснаар өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг бусад соёлын үнэт зүйлээс үнэмлэхүй биш ч илүү өндөр түвшинд хамгаалдаг. 1954 оны Гаагийн Конвенцын дагуу тусгай хамгаалалтад байх цөөн тооны соёлын үнэт зүйл довтолгоонд өртөхөд тэдгээрт өргөтгөсөн хамгаалалтад орсон соёлын үнэт зүйлийн нэгэн адил хандах ёстой.
- 107.** Хуульд заасны дагуу соёлын үнэт зүйл нь нэг буюу хэд хэдэн үндсэн шинж, байршил, зориулалт, ашиглалтын байдлаараа цэргийн довтолгооны объект болох боломжтой (87–94-р зүйлийг харах) бол өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл нь хуулийн дагуу зөвхөн ашиглалтаараа цэргийн объект болох боломжтой. Өөрөөр хэлбэл үндсэн шинж, байршил, зориулалт нь цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулж, тухайн үеийн нөхцөл байдалд бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах, олзолж авах, идэвхгүй болгох нь цэргийн ажиллагааны бодит давуу тал олгох байсан ч өргөтгөсөн хамгаалалтад орсон соёлын үнэт зүйлийг цэргийн объект гэж үзэхгүй бөгөөд үүний үр нөлөө нь довтолгоонд өртөхөөс хамгаална.
- 108.** Үүний нэгэн адилаар өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл нь ашиглалтаараа цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулж, тухайн нөхцөл байдалд бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах, олзолж авах, идэвхгүй болгох нь цэргийн ажиллагааны бодит давуу талыг бий болгох

тохиолдолд өргөтгөсөн хамгаалалтад орсон соёлын үнэт зүйлийг албан ёсоор цэргийн объект гэж үзнэ. Довтолгоо нь энэхүү ашиглалтыг зогсоох цорын ганц боломжит арга хэрэгсэл бөгөөд соёлын үнэт зүйлд хохирол учрахаас зайлсхийх, эсвэл учрах хохирлыг багасгахын тулд довтолгооны арга хэрэгслийг сонгохдоо бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахаас бусад тохиолдолд тэрхүү соёлын үнэт зүйлд довтолохгүй. Үүнээс гадна өөрийгөө даруй хамгаалах шаардлагатай байхаас бусад тохиолдолд довтолох тушаалыг удирдах дээд албан тушаалтан өгч, эсрэг талд соёлын үнэт зүйлийг цэргийн зорилгоор ашиглахаа зогсоохгүй бол түүнд халдах гэж байгаа талаар анхааруулга өгч, тийнхүү зогсоох хугацаа өгөх ёстой.

- 109.** "Удирдах дээд албан тушаалтан" гэж байлдааны ажиллагааны хувьд цэргийн шийдвэр гаргах хамгийн өндөр албан тушаалтныг хэлнэ. Энэ нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалах болов ч өргөтгөсөн хамгаалалтад ороогүй соёлын үнэт зүйлд хамаарах заалттай харьцуулбал нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчнийг удирдаж буй офицероос өндөр албан тушаалтан байх ёстой.
- 110.** Соёлын үнэт зүйлийн ашиглалтыг зогсоох зөвшөөрөгдсөн хугацаа нь нөхцөл байдлаас шалтгаалах бөгөөд бодитой байх ёстой.

(с) Соёлын үнэт зүйлийг тээвэрлэх тусгай заалт

Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлийг тээвэрлэхэд тусгайлан ашиглах тээврийн хэрэгслийг довтолгооны объект болгохыг хориглоно.

- 111.** Соёлын хөдлөх үнэт зүйлийг зэвсэгт мөргөлдөөний урьдчилан таамаглаж болох үр нөлөөнөөс хамгаалах нэг арга бол түүнийг цэргийн объектын ойр орчмоос тухайн үнэт зүйл байрлаж буй улсын нутаг дэвсгэр дотор болон гадна байрлах аюулгүй газар руу шилжүүлэх юм (§§145–149-р зүйлийг хар). 1954 оны Гаагийн Конвенцын 12-р зүйлд үүнтэй холбоотой заалт байдаг. Энэхүү заалтад холбогдох улсын хүсэлтээр соёлын үнэт зүйлийг олон улсын хяналтан дор тусгай журмын дагуу тээвэрлэж болно гэж заасан. 12(3)-н дагуу Конвенцод нэгдэн орсон улсууд зөвхөн соёлын үнэт зүйлийг нүүлгэн шилжүүлэхэд зориулагдсан тээврийн хэрэгслийг довтолгооны объект болгохыг хориглодог. Зөвхөн Конвенцод нэгдэн орсон улсуудыг соёлын үнэт зүйлийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд довтолохыг хориглоно гэсэн үг биш юм. Үүнд газар, тэнгис, агаараар байхаас үл хамаараад соёлын хөдлөх үнэт зүйл тээвэрлэж байх явцад

хэзээ ч цэргийн ажиллагаанд үр дүнтэй хувь нэмэр оруулж чадахгүй учир соёлын үнэт зүйл болон тээврийн хэрэгслийг хэзээ ч цэргийн объект гэж үзэж болохгүй. 1954 оны Гаагийн конвенцод нэгдэн орсон улс эсэхээс үл хамааран олон улсын, олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд оролцогч ямар ч талд соёлын үнэт зүйлийг тээвэрлэх тээврийн хэрэгслийг довтолгооны объект болгохыг бүрэн хориглоно. Түүнчлэн энэхүү хориг нь Конвенцын 12-р зүйлд заасан тээвэрлэлтээс ашиг хүртэх эсэхээс үл хамааран зөвхөн соёлын үнэт зүйлийг тээвэрлэх бүхий л хэрэгсэлд хамаарна.

(ii) Цэргийн цохилт өгөх үеэр соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учруулах

Соёлын үнэт зүйлд цэргийн урьдчилан тооцоолсон бодит болон шууд давуу байдлаас илүү хэмжээний санамсаргүй хохирол учруулж болзошгүй довтолгоо хийхийг хориглоно.

- 112.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлд санамсаргүй (дагалдах) учруулах хохирлоос цэргийн бааз, цэргийн байгууламж зэрэг хууль ёсны байнд цохилт өгөх явцад хамгийн их хохирол учруулсаар ирсэн бөгөөд орчин үеийн бөмбөгдөлтийн шинэ хэлбэрүүд гарснаар хохирлын хэмжээ улам нэмэгдэх болсон. Дайны үед соёлын үнэт зүйлийг хуулиар хамгаалахад гарсан хамгийн чухал дэвшлийн нэг бол тухайн довтолгоог хийснээр олж авах цэргийн ажиллагааны бодит болон шууд давуу талаас илүү их хохирлыг соёлын үнэт зүйлд санамсаргүйгээр учруулж болзошгүй довтолгооны ажиллагааг хориглосон заалт юм. Зарим тохиолдолд ийм довтолгооны ажиллагааг дайны гэмт хэрэг гэж үзнэ.
- 113.** Цэргийн объектод довтлох явцад соёлын үнэт зүйлд санамсаргүй учрах урьдчилан тооцсон хохирол нь объектыг устгах, олзлох, саармагжуулах хэлбэрээр бий болгох цэргийн давуу талаас харьцаагаараа илүү гарах ёсгүй. "Бодит ба шууд" гэсэн үгнээс үзэхэд соёлын үнэт зүйлд учирч болзошгүй санамсаргүй хохиролтой харьцуулахдаа цэргийн үйл ажиллагааны давуу талыг онолын болон таамаглалын талаас авч үзэх бус харин цэргийн ажиллагааны биет үр нөлөөг нь тооцох ёстой.
- 114.** Соёлын үнэт зүйлийн хувьд энэхүү пропорциональ тооцоолол нь тоон үзүүлэлтээс гадна чанарын үзүүлэлтүүдийг агуулдаг. Соёлын үнэт зүйлд учрах санамсаргүй хохирлын хэмжээг тооцохдоо зөвхөн шоо метрээр хэмжихээс илүүтэй хохирол амсаж болзошгүй объект, барилга, талбайн

соёлын үнэ цэнийг харгалзан тогтооно. Иймд соёлын өвд хамаарах хөдлөх болон үл хөдлөх өмчийг тухайн нутаг дэвсгэр харьяалагдах улсын соёлын өвд чухал ач холбогдолтой (§§44-45-р зүйлийг харах) талаас нь ангилан тогтоосон байх нь чухал юм. Үүнээс гадна 1977 оны Нэмэлт протоколыг баталсан Женевийн Дипломат бага хурлын 20 (IV) тогтоол болон улс орнууд, олон улсын байгууллага, олон улсын шүүхийн байгууллагуудын тоо томшгүй олон мэдэгдэлд байнга тусгагддаг гол санаа буюу 1954 оны Гаагийн Конвенцын оршил хэсэгт "Аливаа ард түмний соёлын үнэт зүйлд хохирол учруулах нь хүн төрөлхтний соёлын үнэт зүйлд хохирол учруулсан хэрэг юм", "Соёлын өвийг хамгаалах нь дэлхийн бүх ард түмний хувьд чухал ач холбогдолтой" хэмээн чухалчлан тэмдэглэсэн зүйл байдаг. Соёлын өвийн ийм элементүүд нь ихэвчлэн үл орлуулагдах зүйлс байдаг бөгөөд гагцхүү цэргийн бодит, шууд давуу байдал, эсвэл илт давуу байдал олж авахын тулд хийсэн соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учруулж болзошгүй довтолгоог зөвтгөнө.

Соёлын үнэт зүйлд санамсаргүйгээр пропорциональ бус хохирол учруулахыг хориглосон заалтыг хэрэгжүүлсэн жишээ дурдъя. 1991 онд Персийн булангийн анхны дайны үеэр Ур дахь эртний зиггуратын ойролцоо Иракийн тал хоёр сөнөөгч онгоц байрлуулсан байв. "Соёлын үнэт зүйлийг хүндэтгэхийн зэрэгцээ агаарын хөлгийг Ур хотын дэргэд, ойр тойронд нь үйлчилгээний тоног төхөөрөмж, хөөрөх зурвас ч үгүй газар байрлуулсан нь эдгээр онгоц ажиллагаагүй гэсэн үнэмшил төрүүлсэн. Эвслийн цэргийн нисэх хүчин ариун сүмд хохирол учрах эрсдэлтэй харьцуулахад тэдгээрийг устгах нь төдийлөн ач холбогдолтой биш" гэж үзсэн учир Эвслийн командлагч нар агаарын хөлөгт цохилт өгөхийг хориглох шийдвэр гаргажээ.

- 115.** 1999 оны II Протоколын 10(a)-д зааснаар санамсаргүй хохирол учирч болзошгүй соёлын үнэт зүйлд "хүн төрөлхтний хувьд хамгийн чухал ач холбогдолтой соёлын өв" гэсэн тодотголтой, өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл хамаарна.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учрахаас сэргийлэх эсвэл учрах хохирлыг багасгахын тулд довтолох арга, хэрэгслээ сонгохдоо боломжит бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

- 116.** Соёлын үнэт зүйлд санамсаргүй хэт их хохирол учруулахуйц довтолгооноос зайлсхийхийн тулд довтолгооны тохирох арга, хэрэгслийг сонгох нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд довтолгооны арга, хэрэгслийг сонгохдоо соёлын үнэт зүйлд хохирол учрахаас сэргийлэх, учрах хохирлыг багасгахын тулд боломжит бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй. Довтолгоонд өртөх объектууд нь соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулах арга хэмжээний нэгэн адил (§§95–99-р зүйлийг харах) довтолгооны арга, хэрэгслийг сонгохдоо соёлын үнэт зүйлд хохирол учрахаас сэргийлэх, эсвэл учирч болзошгүй “дагалдах” хохирлыг багасгахын тулд авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тухайн нөхцөл байдлаас шалтгаална.
- 117.** Довтолгооны хэрэгсэл гэдэг нь зэвсгийн сонголттой хамааралтай. Энэ тохиолдолд соёлын үнэт зүйлд хохирол учрахаас сэргийлэх эсвэл учрах хохирлыг багасгахын тулд боломжтой бол нарийн чиглүүлэгч сум, бага тэсрэлттэй болон хуваагдлын радиус багатай сум ашиглах зэрэг арга хэмжээ авна. Усан доорх соёлын үнэт зүйлийн ойролцоо шумбагч онгоцонд цохилт өгөх үед урьдчилан сэргийлэх зорилгоор гүний цэнэгт хошуу бус торпедо ашиглахыг шаарддаг.
- 118.** Довтолгооны арга нь довтлох хэлбэртэй холбоотой. Энэ хүрээнд соёлын үнэт зүйлд хохирол учрахаас сэргийлэх эсвэл учрах хохирлыг багасгахын тулд агаарын дайралтыг өдрийн цагаар, нам-өндөрт хийх, бөмбөгдөхийн оронд ойрын зайд довтлох, өрсөлдөгч талын хүчийг сулруулахын тулд тэсрэх бодис, автомат галт зэвсэг ашиглахын оронд мэргэн буудагч байрлуулах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч болох бөгөөд ингэснээр цэргийн ажиллагаа санамсаргүй байдлаар хохирол учруулах эрсдэлийг бууруулна.
- 119.** Довтолгоонд өртөх объектууд нь соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулах үүргийн нэгэн адил (§§95–99-р зүйлийг харах) цэргийн хүчин соёлын үнэт зүйлд зүй бусаар санамсаргүй хохирол учруулахыг хориглох, хохирол учрахаас сэргийлэх эсвэл учрах хохирлыг багасгахын тулд довтолгооны арга хэрэгслийг сонгохдоо боломжтой бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүргээ биелүүлэхийн тулд довтолгооны ажиллагааг төлөвлөхдөө довтолгооны байг сонгох үйл явцыг тогтмолжуулах шаардлагатай.
- 120.** Санамсаргүй хохирол учруулах тохиолдолд довтолгооны байг тодорхойлох шатанд байг тодорхойлох процессын нэг чухал хэсэг нь "хориглосон бай"-н жагсаалтад байх зүйлийг онилохыг хориглох заалт юм. Хориглосон бай нь Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль эсвэл холбогдох

Оролцооны дүрмийн дагуу хамгаалагдсан объектуудтай ойролцоо байрлах, тодорхой хязгаарлалт тогтоосон цэргийн ажиллагааны объектыг хэлнэ. Ийм төрлийн хязгаарлалтад тухайн бай руу чиглэсэн довтолгоо хийхэд санамсаргүй хохирол учрахаас сэргийлэх эсвэл учрах хохирлын хэмжээг багасгахын тулд тусгай зэвсэг ашиглах ёстой гэж заадаг.

Соёлын үнэт зүйлтэй холбоотой асуудлыг тусгасан хориглосон байны жагсаалтыг Ирак, Ливи, Сири, Мали зэрэг түүх соёлын дурсгалт газрууд ихтэй орнуудад явуулсан цэргийн ажиллагаанд амжилттай ашигласан.

- 121.** Ерөнхийлөн хэлбэл бай-хөгжүүлэлт болон чадавх-шинжилгээний үе шатанд аль алинд нь “дагалдах хохирлын тооцоолол”-ыг эмпирик хэлбэрийн аргачлалаар дагалдах хохирлыг нарийвчлан тооцох бөгөөд ихэвчлэн зэвсгийн төрөл (түүний нарийвчлал, хүчин чадал, тэсрэх болон хуваагдлын радиусын мэдээллийг оруулах), агаараар илгээх зэвсгийн нислэгийн зам, объектын тохиргоо, материал, Зэвсэгт мөргөлдөөний тухай хууль, холбогдох Оролцооны дүрмийн дагуу хамгаалагдсан объектод ойр байгаа хүмүүс эсвэл эд зүйлийн зай болон холбогдох бусад өгөгдөл, тухайлбал хүмүүс ба эд зүйлийн талаарх мэдээллийг харгалзан үздэг. “Дагалдах хохирлын тооцоолол” нь тухайн объектод цохилт өгснөөр олж авах цэргийн давуу талыг мэдээлэлд үндэслэн илүү нарийвчлалтай үнэлэх боломжийг командлагчдад олгосноор дагалдах хохирлын эрсдэл болон хүрч болзошгүй ноцтой хэмжээг саармагжуулах замаар зорилтот онилгоо болон хохирлыг бууруулах аргыг сайжруулдаг. Дагалдах хохирлын тооцооллын үр дүн нь довтолгооны байг онилох шийдвэрийг ямар түвшинд гаргах асуудалд нөлөөлдөг. Командлагч нь хохирлын тооцоололд үндэслэн тодорхой арга хэрэгсэл сонгох (жишээ нь: нарийвчлалтай сум, тэсэлгээний болон хуваагдлын гэмтлийг хязгаарлах зориулалттай нэвтрэгч эсвэл гал хамгаалагч гэх мэт), довтолгооны тодорхой өнцөг гэх мэт зарим аргуудыг ашиглан довтолох эсвэл цохилт өгөхийг бүрмөсөн хориглох шийдвэр гаргаж болно.

Дэлхийн 2-р дайны үед Ром дахь цэргийн объектуудыг агаараас бөмбөгдөх даалгаврыг Британийн биш харин АНУ-ын бөмбөгдөгч онгоцонд даатгаж, тусгайлан сонгогдсон, туршлагатай багийнхныг хөөргөж байв. 2011 онд Ливийн засгийн газрын цэргүүдийн Лептис Магнагийн ойролцоох Расаймергиб дэх эртний Ромын бэхлэлтийн оройд байрлуулсан радарын байгууламжийг агаарын довтолгоогоор устгах даалгавар гүйцэтгэхдээ Эвслийн хүчнийхэн нарийвчлалтай сум хэрэглэжээ. Онилсон цохилт хийх замаар бэхлэлтэд хохирол учруулахгүйгээр устгаж чадсан юм.

Мали улсын шилдэг туршлагыг мөн жишээ болгон үзье. 2013 онд Дэлхийн өвд бүртгэгдсэн Тимбукту дахь Жингэрэбер сүмийн хажууд байрлах байшинд босогчид байрлажээ. Засгийн газар болон холбоотнууд сүмд хохирол учруулахаас сэргийлж агаарын цохилт өгөхөөс татгалзсан байна. 122 мм-ийн богино буугаар, сүмд хохирол учруулахгүйгээр байшинг устгахаар тусгайлан байрлуулсан байна. Үйл ажиллагаа амжилттай болсон.

- 122.** Соёлын үнэт зүйлийн ойролцоо байдал ба түүний ач холбогдол нь аливаа дагалдах хохирлын үнэлгээний салшгүй чухал хэсэг байх ёстой. Ойр орчмын соёлын үнэт зүйлийн байршил, хэлбэр, байгууламж, түүх, урлаг, архитектурын ач холбогдлын талаар цохилтын онилох шийдвэр гаргагчдад тогтмол хүртээмжтэй мэдээлэл олгож, зохих үнэлгээ хийснээр л тухайн эд хөрөнгийг санамсаргүй хохирлоос сэргийлэх боломжтой. Соёлын үнэт зүйлийн цэргийн объектод ойрхон байх нь объцктийг хязгаарлагдмал зорилтот жагсаалтад оруулах үндэслэл болох бөгөөд үүний дагуу объектод цохилт өгөх довтолгооны хэрэгсэл, арга барилын хувьд хатуу нөхцөлтэйгөөр хийгдэх ёстой.

Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлд санамсаргүй учруулж болзошгүй хохирол нь урьдчилан тооцоолсон цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад хэт их байх үед довтолгоог цуцлах буюу түр зогсоох ёстой.

- 123.** Довтолгооны объект нь нь соёлын үнэт зүйл болох нь тогтоогдвол довтолгоог цуцлах, түр зогсоох үүрэгтэй адилаар (§§100–101-р зүйлийг харах), довтолгоог хийснээр бий болох цэргийн тодорхой болон шууд давуу талтай харьцуулахад соёлын үнэт зүйлд учруулах хохирол нь хэт их байх нь тодорхой болсон тохиолдолд довтолгоог цуцлах, түр зогсоох

үүргийг биелүүлэхийн тулд тухайн довтолгоог цуцлах буюу зогсоож болохуйц боломжит хэрэгсэл, аргаар хийхийг шаарддаг. Мөн оролцооны дүрэм болон тусгай заавар эсвэл түүнтэй дүйцэхүйц баримтад заасныг дагаж мөрдөх үүрэгтэй.

Дэлхийн 2-р дайны үед Ром дахь цэргийн объектуудыг агаараас бөмбөгдөж байх үед онилгоо нь бүрхэг болсон тохиолдолд багийнхан бөмбөг хаяхгүйгээр бааз руугаа буцахыг хатуу зааварчилдаг байв.

- 124.** Санамсаргүй хохирлын тухай дээрх дүрмүүд нь бусад соёлын үнэт зүйлийн нэгэн адил өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлд хамаарах бөгөөд өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл нь “хүн төрөлхтөнд чухал ач холбогдолтой” гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

В. ӨӨРИЙН ХЯНАЛТАД БАЙГАА СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ УСТГАХ, ХОХИРОЛ УЧРУУЛАХ

(i) Ерөнхий заалт

Цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд өөрийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг хориглоно.

- 125.** Цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд цэргийн хүчинөөрийн мэдэлд байх соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг хориглоно. Энэ нь дайсагнагч талыг давшилтыг саатуулах, галын шугамыг цэвэрлэх эсвэл дайсагнагч тал халхавч болгон ашиглахаас сэргийлэх зорилгоор соёлын үнэт зүйлийг устгах, соёлын дурсгалт зүйлийг сүйтгэх, хохирол учруулах зэрэгт хамаатай болно. Соёлын үнэт зүйлийг дур мэдэн устгах, зүй бусаар хохирол учруулах, өөрөөр хэлбэл цэргийн ажиллагааны хангалттай үндэслэлгүйгээр нураах, хохирол учруулах мөн цэргийн ажиллагааны зайлшгүй шаардлагатай хэмжээнээс хэтэрсэн хохирол учруулахыг хатуу хориглоно. Соёлын үнэт зүйлийг цэргийн хэрэгцээ шаардлагын үндэслэлгүйгээр сүйтгэх нь дайны гэмт хэрэг бөгөөд гэмт этгээдийг олон улсын болон үндэсний эрүүгийн шүүх болон арбитрын шүүхээр шийтгэж байв.

- 126.** Цэргийн зайлшгүй шаардлага гэдэг нь цэргийн ажиллагаанд давуу талыг олж авах ижил төстэй боломжит хувилбар байгаагүй тохиолдлыг хэлнэ. Өнөөгийн соёлын үнэт зүйл гэж нэрлэж буй зүйлтэй холбоотой генерал Эйзенхауэрын хэлсэн алдарт үг бий. Тэрээр цэргийн хэрэгцээ шаардлага нь цэргийн тохиромжтой байдал биш гэдгийг онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ үзэл баримтлалыг улс орнууд цэргийн гарын авлагадаа байнга давтдаг төдийгүй хэрэгжүүлэхийг зорьдог болжээ. Дахин хэлэхэд, цэргийн хүчнүүд өөрсдийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахаас өмнө цэргийн ажиллагаа гүйцэтгэхдээ өөр бусад хувилбаруудыг нухацтай, харилцан уялдаатай, уран сэтгэмжтэй бодох ёстой. Өнөө цагт зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд зөвхөн онцгой тохиолдолд хамгаалалт болгох зорилгоор соёлын үнэт зүйлийг л нураах ажил хийдэг болсон.
- 127.** Цэргийн зайлшгүй шаардлага нь цэргийн хүчин зүйлээс үүдэлтэй аливаа сүйрэл, хохирлын хэмжээг тогтооход мөн үйлчилдэг. Цэргийн зайлшгүй шаардлагаас үүдэн соёлын үнэт зүйлд хохирол учруулах үйлдэл шаардлагатай хэмжээнээс хэтрэх ёсгүй. Цэргийн хүчин соёлын үнэт зүйлийг хамгаалалтын зорилгоор нураахаас өмнө болон гүйцэтгэх явцад түүнд учирч болох хохирлыг багасгахын тулд бүхий л хүчин чармайлт гаргах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн орсон улсын мөргөлдөөнд оролцогч тал өөрийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах цэргийн зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ тухай шийдвэрийг нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг удирдаж байгаа цэргийн албан тушаалтан гаргах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй улсын мөргөлдөөнд оролцогч тал өөрийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах цэргийн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөн адил хамаарна.

- 128.** §§104–105-р зүйлийг харах

(ii) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн тусгай заалт

1999 оны II Протоколд нэгдэн орсон улсын мөргөлдөөнд оролцогч талуудын цэргийн хүчин өөрийн хяналтад байгаа өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг хатуу хориглоно.

- 129.** 1999 оны II Протоколд нэгдэн орсон улсын мөргөлдөөнд оролцогч талуудын цэргийн хүчин өөрийн хяналтад байгаа өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг хатуу хориглоно. Бусад соёлын үнэт зүйлийн тухай хууль эрх зүйн байдал (§§125-127-р зүйлийг харах)-аас ялгаатай нь цэргийн хэрэгцээ шаардлага нь цэргийн хүчний өөрийн мэдэлд байгаа аливаа өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор нураах, санаатайгаар устгах, хохирол учруулах үйлдлийг хуулиар зөвтгөх боломжгүй юм. Ийм эд зүйлийг устгах, хохирол учруулах нь туйлын хориотой.

Г. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ БУЮУ ТҮҮНИЙ ОРЧНЫГ АШИГЛАХ

(i) Ерөнхий заалт

Зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойронд байх эд зүйлийг устгах буюу хохиролд өртөж болзошгүй аливаа зориулалтаар ашиглахыг хориглоно.

- 130.** Цэргийн дайсагнасан ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хүндэтгэх тухай өөр нэг үндсэн дүрэмд зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойронд байх эд зүйлийг устгах буюу хохирол учруулж болзошгүй аливаа зорилгоор ашиглахыг хориглоно. Энэ нь соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын газрыг устгах ба хохирол учруулж болзошгүй зорилгоор ашиглах, ийнхүү ашигласнаар ямар нэгэн цэргийн давуу тал олж авах боломжгүй, эсвэл давуу тал олж авах өөр боломжит арга зам байгаа тохиолдолд соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойрныг дайны үед ашиглах эрх зүйн үндэслэл байхгүй гэсэн үг юм.
- 131.** Энэ заалтад соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойрныг зэвсэгт мөргөлдөөний зориулалтаар ашиглахыг хориглохоос гадна холбоотой нөхцөлүүд мөн хамаарна.
- 132.** Соёлын үнэт зүйлийг сүйрэл, хохиролд учруулж болзошгүй аливаа зорилгоор ашиглах гэдэг нь соёлын үнэт зүйлийг де факто эсвэл идэвхгүй байдлаар ашигласнаар түүнийг халдлагад өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг хамруулж ойлгоно. Иймээс уг заалтаар

соёлын үнэт зүйлийг галын шугамд зориудаар хамруулах, тухайлбал, түүхэн байгууламжаар халхавчлагдсан байрлал эзлэхийг хориглоно. Энэ заалтын дагуу түүхэн байгууламж, дурсгалт газрыг хамгаалалтын зурваст оруулахыг хориглоно. Жишээлбэл, Дэлхийн 2-р дайны үед Монте Касино дахь сүмийн эргэн тойронд Германы “Густавын зурвас” байгуулсан түүхийг дурдаж болно.

- 133.** Дүрэмд зөвхөн байлдааны зориулалтаар ашиглахыг хориглодоггүй. Соёлын ач холбогдол бүхий байгууламжийг хээрийн штаб, зэвсгийн агуулах гэх мэт зориулалтаар ашиглах нь довтолгоонд өртөх магадлалтай бол уг барилга байгууламжийг ашиглахыг хориглоно. Цэргийн нисэх онгоцны зогсоолын талбайг довтолгооноос хамгаалах зорилгоор соёлын үнэт зүйлээр халхавч хийхийг хориглоно. 1991 онд Персийн булангийн анхны дайны үеэр Ирак улс ийм үйлдэл хийж байжээ.
- 134.** Соёлын үнэт зүйлийг довтолгоонд өртөх эрсдэлд оруулахаас гадна өөр тохиолдолд энэ заалт үйлчилнэ. Тус дүрмийн дагуу зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг гэмтээж болзошгүй аливаа ашиглалтыг хориглоно. Ингэснээр түүх, урлаг, архитектурын ач холбогдол бүхий барилга байгууламж бага боловч гэмтэх, улмаар нурах эрсдэл орох, мөн соёлын үнэт зүйлийг төв байр болон үүнтэй төстэй зориулалтаар ашиглах замаар түүнийг эвдэн сүйтгэх, дээрэмдэх эрсдэлд оруулахыг хориглоно гэсэн үг. Археологийн дурсгалт газарт хуаран байрлуулахыг мөн адил хориглоно. Мөн соёлын үнэт зүйлийг байг онолох сургуулилтад ашиглаж болохгүй. Соёлын үл хөдлөх үнэт зүйлийн эргэн тойрны ашиглалтын талаар дурдахад археологийн дурсгалт газруудын ойролцоо нисдэг тэрэг буух үед эргэлдэх төхөөрөмжийн хөдөлгөөнөөс үүдэх агаарын урсгалд өртөх, хүнд даацын машин ашиглах, хүнд чингэлэг байрлуулах, газар тэгшлэх, шуудуу ухах, бие засах газар, түлшний савны нүх ухах, элс уутлах зэрэг газар шорооны ажил хийх, олзолсон зэвсгийг дэлбэлж устгах зэрэг үйлдлээс сэргийлэх ёстой. Эргэн тойрон гэдэгт усан доорх соёлын өвийн ойр орчим дахь далай тэнгисийн ус болон тэнгисийн ёроолд дайны үед хохирол учруулж болзошгүй аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно хэмээн ойлгоно. Байлдааны хөлөг онгоцнууд зангуу буулгах мөн шумбагч онгоцны үйл ажиллагааны нөлөөллийг үүнд хамруулна.
- 135.** Гэвч цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын улмаас соёлын үнэт зүйлийг ашиглахыг хориглоогүй бөгөөд энэ нь цэргийн тодорхой давуу талыг бий болгох, давуу тал олж авах боломжтой өөр хувилбар байхгүй тохиолдолд соёлын үнэт зүйлийг ашиглахыг хориглоогүй гэдгийг санах нь зүйтэй. Ийм нөхцөл байдал байж болох ч цэргийн хүчинд өөр боломжит хувилбарууд олон байдаг тул ховор байх магадлалтай.

- 136.** Соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор зэвсэгт харуул байрлуулсан нь тухайн эд хөрөнгийг цэргийн довтолгооны бай болгосон хэмээн үзэхгүйтэй адилаар тухайн эд хөрөнгийг устгах, гэмтээж болзошгүй зориулалтаар ашигласанд тооцохгүй. Хэдийгээр 1954 оны Гаагийн Конвенцод зөвхөн Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлтэй холбоотой асуудлыг тодорхой заасан боловч уг зарчим нь бүх соёлын үнэт зүйлд хамаарах нийтлэг зарчим юм.
- 137.** Цэргийн хүчээр эзлэх ажиллагааны нөхцөлд мөрдөгдөх дүрмийн талаар дэлгэрэнгүйг §§182–184-ээс үзнэ үү.

1999 оны II Протоколд зааснаар зэвсэгт мөргөлдөөний үед мөргөлдөөнд оролцогч тал соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулж болзошгүй зориулалтаар ашиглах цэргийн зайлшгүй шаардлагатай гэж үзвэл тухайн шийдвэрийг нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг удирдаж байгаа цэргийн албан тушаалтан гаргах ёстой.

1999 оны II Протоколд үл хамаарах мөргөлдөөнд оролцогч тал зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг түүнийг устгах, хохирол учруулах зорилгоор ашиглах шаардлагатай тохиолдолд дээрх нөхцөл мөн адил хамаарна.

- 138.** §§104–105-р зүйлийг харах.

(ii) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн тусгай заалт

1999 оны II Протоколд заасан мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн ажиллагааг дэмжих зорилгоор өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын аливаа зүйлийг ашиглахыг хориглоно.

- 139.** Соёлын бусад үнэт зүйлстэй холбоотой нөхцөл байдлаас (§§130–137-р зүйлийг харах) ялгаатай нь 1999 оны Гаагийн II Протоколд нэгдэн орсон мөргөлдөөнд оролцогч талууд өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын аливаа зүйлийг цэргийн ажиллагааг дэмжих зорилгоор ашиглахыг хориглоно. Цэргийн хэрэгцээтэй холбоотой ямар ч үндэслэл нь ийм хэрэглээг хууль ёсны дагуу зөвтгөхгүй. 1954 оны Гаагийн Конвенцын дагуу тогтоосон тусгай хамгаалалтын дэглэмд хамрагдсан эдгээр цөөн хэдэн соёлын үнэт зүйлийг ашиглалтын хувьд өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлтэй адил авч үзэх нь зүйтэй.

- 140.** Өргөтгөсөн хамгаалалд буй соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааг дэмжих зорилгоор ашиглахыг хориглох заалт нь 1999 оны Гаагийн II Протоколд нэгдэн орсон мөргөлдөөнд оролцогч аль ч талд хамаарах бөгөөд эд хөрөнгийг хянах эрхтэй улс байсан ч хамаарна. 10-р зүйлийн в-д зааснаар соёлын үнэт зүйлийг өргөтгөсөн хамгаалалтад авахаас өмнө тухайн улсаас тэрхүү соёлын үнэт зүйлийг цэргийн зориулалтаар ашиглахгүй гэдгээ баталгаажуулсан мэдэгдэл хийхийг шаарддаг байна.
- 141.** “Цэргийн ажиллагаа” гэдэг нь байлдааны ажиллагааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойронд байгаа газрыг ашиглахыг хориглох нь зөвхөн байлдааны ажиллагааг дэмжих зорилгоор ашиглахад хамаарна. Гэхдээ энэ нь 1999 оны Гаагийн II Протоколд оролцогч талууд зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд устгах буюу хохирол учруулах эрсдэлтэй бусад зорилгоор өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг ашиглаж болно гэсэн үг биш юм. Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлд хамаарах аливаа тусгай заалт хүчингүй болсон тохиолдолд бүх соёлын үнэт зүйлд хамаарах Ерөнхий заалтыг мөрдөж эхэлнэ. Үүний үр дүнд бусад бүх соёлын үнэт зүйлийн нэгэн адил зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд тус соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааг дэмжих зорилгоор ашиглахыг хориглохоос гадна өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг зэвсэгт мөргөлдөөний үед устгах, гэмтээж бэртээх аливаа зорилгоор ашиглахыг хориглоно. Энэ нь хэрэв цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа бол өөрөөр хэлбэл цэргийн ижил төстэй давуу талыг олж авах боломжтой өөр арга зам байхгүй тохиолдолд хамаарахгүй.

Д. ЦЭРГИЙН АЖИЛЛАГААНААС ҮҮДЭН СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛД АЮУЛ УЧРАХ

Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааны улмаас үүсэх аюулаас хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

- 142.** Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд өөрийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахаас татгалзах нь зөвхөн тэдний үүрэг биш юм. Тал бүр өөрийн болон дайсны цэргийн ажиллагаанаас үүдэн гарах аюулаас өөрийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйлийг хамгаалахын тулд

шаардлагатай бүхий л арга хэмжээг аль болох идэвхтэй хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Энэхүү өөрийн мэдэлд буй соёлын үнэт зүйлийг цэргийн үйл ажиллагааны аюулаас хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авах үүрэг нь 1954 оны Гаагийн Конвенцын 3 дугаар зүйл, 1999 оны II Протоколын 5 дугаар зүйлд заасан соёлын үнэт зүйлийг зэвсэгт мөргөлдөөний урьдчилан таамаглаж болох үр дагавраас хамгаалах үүрэгтэй адил боловч илүү өргөн хүрээг хамардаг. Энэ нь тухайн улсын нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлээр хязгаарлагдахгүй бөгөөд илүү ерөнхий шинж чанартай байдаг.

- 143.** Үүргийг хэрэгжүүлэх боломжтой зүйлээр хязгаарлах нь аль нэг тал юу ч хийхгүй байх, эсвэл соёлын үнэт зүйлийг хамгаалахын тулд бодитой хүчин чармайлт гаргахгүй байхыг зөвтгөхгүй. Цэргийн нөхцөл байдал, логистикийн чадавхаас хамаарах хэдий ч энэхүү үүрэг нь бодит юм.
- 144.** Ерөнхий үүрэг нь хоёр нэмэлт, тусгай үүрэг (§§145–151-р зүйлийг харах) хэлбэрээр тусгагдсан бөгөөд тусгай үүрэг нь ерөнхий үүргийг хэрэгжүүлэхгүй гэсэн үг биш юм.

Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын дурсгалт зүйлсийг цэргийн объект, түүний ойр орчмоос холдуулах эсвэл тухайн байршил дээр нь зохих ёсоор хамгаалах боломжит арга хэмжээ авах ёстой.

- 145.** Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааны улмаас учирч болох аюулаас хамгаалахад шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг хамгийн дээд хэмжээгээр авах нийтлэг үүргийг хэрэгжүүлэхдээ цэргийн объектын ойр орчмоос соёлын үнэт зүйлийг зайлуулах, эсвэл зохих газар хамгаалалтаар хангана. Энэ үүргийг биелүүлэх нь зөвхөн цэргийн хүчинд хамааруулах нь тийм ч тохиромжтой биш юм. Шаардлагатай аливаа шийдвэрийг иргэний байгууллагын удирдах албан тушаалтнууд гаргаж болох бөгөөд аль болох холдуулах шаардлагатай бөгөөд газар дээр нь хамгаалах шаардлагатай аливаа арга хэмжээг эдгээр эрх бүхий байгууллага эсвэл бусад шинжээчид авч болно. Гэвч цэргийн хүчнийхэнд юун түрүүнд эдгээр үүргийг биелүүлэх шаардлага тулгарч болох бөгөөд энэ үүргийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр дуудагдах магадлалтай байдаг.
- 146.** Дахин хэлэхэд, үүргээ хэрэгжүүлэх нь боломжтой арга хэмжээ авснаар хязгаарлагдана гэдэг нь мөргөлдөөнд оролцогч тал юу ч хийхгүй, эсвэл өнгөц оролдлого хийхээс өөр зүйл хийхгүй гэсэн үг биш юм. Цэргийн

нөхцөл байдал, чадавхаас хамаарч өөр өөр байж болох ч эдгээр үүрэг нь бодитой хүлээх үүрэг байдаг.

- 147.** Соёлын хөдлөх үнэт зүйлийн цуглуулгыг цэргийн хүчин гартаа авсан тохиолдолд түүнийг илүү аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх үү эсвэл байгаа газарт нь хамгаалах уу гэдэг шийдвэрийг гаргахдаа тухайн эд хөрөнгийн эмзэг байдал болон түүний талаарх шаардлагатай, нарийн мэдлэг, ур чадварын онцлог шинж чанарыг харгалзан үзэх хэрэгтэй. Тэрхүү шийдвэрийг боломжтой бол зохих иргэний эрх бүхий байгууллагатай нягт зөвлөлдсөний үндсэн дээр холбогдох экспертүүдийг, тэдгээрийн дотор цэргийн хүчинд соёлын үнэт зүйлийг хамгаалах үүрэг хүлээсэн мэргэжлийн алба, боловсон хүчнийг оролцуулан холбогдох засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагатай хамтрах зөвшилцсөний үндсэн дээр гаргах шаардлагатай. Соёлын үл хөдлөх өмчийн тухайд аливаа арга хэмжээг зохион байгуулах, гүйцэтгэхэд мөн адил дээрх зарчмыг баримтална. Энэ асуудлаар ЮНЕСКО-ийн оролцоо онцгой ач холбогдолтой (§§229–231-р зүйлийг харарх). Түүнчлэн 2016 оны 2-р сарын 29-ний өдөр ЮНЕСКО болон Олон улсын Улаан загалмайн хороо хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 1(vi) зүйл мөн хамааралтай. Үүнд Олон улсын Улаан загалмайн хороо нь “цуглуулгыг нүүлгэн шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх ба/эсвэл яаралтай хамгаалах арга хэмжээ авахад шаардлагатай хангамж, тоног төхөөрөмжөөр хангах замаар” эрсдэлд орсон соёлын тодорхой үнэт зүйлийг хамгаалахад туслах тухай заасан байдаг. ЮНЕСКО эсвэл мөргөлдөөнд оролцогч талуудын тусламж авах хүсэлт дээр үндэслэж энэхүү туслалцааг олгох бөгөөд мөргөлдөөнд оролцогч бүх талууд зөвшилцсөн байх ёстойгоос гадна холбогдох орон нутгийн оролцогчид, тэр дундаа үндэсний эрх бүхий байгууллагуудтай нягт зөвлөлдсөний үндсэн дээр дээрх хүсэлтийг гаргах ёстой.
- 148.** Ховор тохиолдолд соёлын үнэт зүйлийг аюулгүй газар нүүлгэн шилжүүлэх эсвэл түүнийг газар дээр нь хамгаалах аливаа шийдвэрийг цэргийн хүчин гаргах шаардлага үүсдэг. Ийм тохиолдолд тухайн нөхцөл байдалд боломжийн хэмжээнд цэргийн үйл ажиллагааны командлалын өндөр түвшинд шийдвэрийг гаргана. Зөвхөн нэн яаралтай тохиолдолд цэргийн хүчин өөрсдөө соёлын үнэт зүйлийг аюулгүй газарт шилжүүлэх эсвэл газар дээр нь хамгаалах оролдлого хийж болох бөгөөд ийм тохиолдолд маш болгоомжтой байх хэрэгтэй. Соёлын хөдлөх үнэт зүйл, ялангуяа хуучин ном, гар бичмэлүүд нь мэргэжлийн бус харьцаж, арчлахад амархан гэмтдэг.

Испанийн иргэний дайн, Дэлхийн хоёрдугаар дайнаас эхлээд саяхны жишээ болох Афганистан, Ирак, Ливи, Мали, Сири дэх мөргөлдөөн хүртэлх дайны үед соёлын хөдлөх үнэт зүйлийг цэргийн довтолгооны объектын ойр орчмоос холдуулсан, зарим тохиолдолд гаднын улсад амжилттай нүүлгэн шилжүүлсэн олон жишээ бий. Соёлын хөдлөх ба үл хөдлөх үнэт зүйлийг газар дээр нь хамгаалсан сайн туршлага ч бий. Тодруулбал, соёлын хөдлөх үнэт зүйлийг агуулах хонгилд хадгалах, соёлын үл хөдлөх үнэт зүйлийг чичиргээнээс хамгаалах зорилгоор элсээр дарах, шороо овоолон далдлах, цонхыг тавцан хадаж хаах зэрэг жишээг дурдаж болно. Гэвч ихэнх тохиолдолд чухал шийдвэрүүдийг гаргах болон нүүлгэн шилжүүлэх ажлыг цэргийн хүч гэхээсээ илүү эрх бүхий иргэний байгууллагын удирдах албан тушаалтнууд, техникийн мэргэжилтнүүд гүйцэтгэж, нарийн хянадаг байв.

- 149.** Франц, Швейцарь, Их Британи, АНУ зэрэг улсууд мөргөлдөөнтэй бүс нутгаас хамгаалалтад байх соёлын хөдлөх үнэт зүйлийг тус тусын нутаг дэвсгэрт хүлээн авч хамгаалах тухай хуулийн зохицуулалт хийсэн. Гэхдээ энэхүү нутаг дэвсгэрээс гадуурх "аюулгүй бүс"-ийн давуу талыг ашиглах эсэх шийдвэрийг цэргийн хүчнийхэн гаргах нь ховор байдаг.

Мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн объектуудыг соёлын дурсгалт газрын ойролцоо байрлуулахаас аль болох зайлсхийх ёстой.

- 150.** Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг эсрэг талын цэргийн ажиллагааны улмаас учирч болох аюулаас хамгаалах шаардлагатай урьдчилсан арга хэмжээ авахдаа эдгээр эд зүйлсийн ойролцоо цэргийн объект байрлуулахаас боллоцоот дээд хэмжээнд зайлсхийх ёстой. Өөрөөр хэлбэл, цэргийн нөхцөл байдал болон бусад холбогдох хүчин зүйлүүдийг хүлээн зөвшөөрсөн хэмжээнд аль нэг тал соёлын үнэт зүйлийн ойр орчимд пулемётын үүр, их буу, пуужин харвах төхөөрөмж, танк, зэвсгийн анги, хээрийн бааз, штаб, хээрийн цэргийн нисэх зурвас, цэргийн нисэх онгоц, усан онгоцны зогсоол, тэнгисийн цэргийн хөлөг онгоц, радарын станц, радио эсвэл хөдөлгөөнт холбооны цамхаг гэх мэт урьдчилан таамаглах боломжтой цэргийн байг байрлуулахаас зайлсхийнэ. "Ойр орчим" гэдгийг тодорхой тогтоогоогүй. Энэ нь тухайн тохиолдол бүрээс шалтгаалах асуудал бөгөөд тодорхой байг онилсон зэвсгийн хүчин чадлаас хамаарна.

151. Дахин хэлэхэд, “бололцоот дээд хэмжээнд” гэсэн шалгуур нь цэргийн хүчнийг зүгээр л мөрөө хавчиж, цэргийн объектоо тохиромжтой гэсэн газраа байрлуулахыг зөвтгөдөггүй. Хэдийгээр энэ үүрэг нь нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байж болох ч энэ нь хуулиар хүлээсэн үүрэг хэвээр байна.

E. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХУУЛЬ БУСААР ЭЗЭМШИХ, САНААТАЙГААР ХОХИРОЛ УЧРУУЛАХ

152. Олон улсын эрх зүйгээр цэргийн дайсагнасан ажиллагаанд оролцогч талуудад байлдааны ажиллагааны явцад соёлын үнэт зүйлийг завших, сүйтгэхтэй холбоотой ялгаатай боловч хоорондоо холбоотой хоёр үүрэг хүлээлгэдэг. Талууд өөрсдөө аливаа хэлбэрээр соёлын үнэт зүйлийг завших, сүйтгэхийг хориглоно. Түүнчлэн, бусад этгээд уг эд хөрөнгийг аливаа хэлбэрээр завших, сүйтгэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох үүрэгтэй. Энэхүү хоёр заалт нь олон улсын болон олон улсын бус байхаас үл хамааран орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг улам бүр чухалчлан хамгаалж буйн илрэл юм. Энэ хоёр нь байлдааны даалгавраа амжилттай гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой.
153. 1954 оны Гаагийн Конвенцын 4(3) зүйлийн 4(3) заалтаас гаралтай доор дурдсан эхний дүрэм нь соёлын үнэт зүйлийг “хулгайлах, дээрэмдэх [эсвэл] завших” тухай юм. Гурван нэр томъёог оруулсан бөгөөд хулгай, дээрэм нь хоёулаа завшихын нэг хэлбэр боловч “завших” гэдгийг тухайлан оруулсан нь эргэлзээ төрүүлэхээс зайлсхийсэн. Ямар ч үгээр нэрлэсэн байсан соёлын үнэт зүйлийг хууль бусаар авах бүх төрлийн гэмт хэргийг хамруулах зорилготой байв.

(i) Цэргийн хүчнийхэн

Соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр шамшигдуулах, эвдэн сүйтгэх үйл ажиллагаа явуулахыг бүрэн хориглоно.

154. Цэргийн дайсагнасан ажиллагаанд оролцогч талууд байлдааны явцад соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр шамшигдуулах, эвдэн сүйтгэх үйл ажиллагаа явуулахыг бүрэн хориглоно. Мөргөлдөөнд оролцож буй аль ч талын цэргийн хүчний ийм үйлдлийг

цэргийн зайлшгүй шаардлагатай гэсэн шалтаг шалтгаанаар хууль ёсны дагуу зөвтгөж үл болно. Энэ төрлийн үйлдэл нь дайны гэмт хэрэг болно.

155. Зэвсэгт хүчний удирдлагууд энэ хориг, түүний үр дагаврыг цэргийн хүчний бие бүрэлдэхүүнд тушаал хүргүүлэх зэрэг арга замаар ойлгуулж, сахилгын шийтгэл ногдуулах, зохих тохиолдолд уг асуудлыг холбогдох иргэний болон цэргийг шүүхийн байгууллагад шилжүүлэх замаар уг хоригийг чандлан хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа, цэрэг хүн ямар ч гэм хор учруулаагүй гэж бодож аливаа бэлэг дурсгалын зүйлийг өөрт авах эсвэл гэм зэмгүй гэж итгэн жирийн нэг граффити зурах зэрэг үйлдэл нь зэвсэгт мөргөлдөөний хууль тогтоомжийг зөрчиж байгаа тул дайны гэмт хэрэг үйлдсэн хэргээр хариуцлага хүлээх магадлалтай гэдгийг командлагч нар тодорхой хэлэх ёстой. Командлагч нар хулгай, дээрэм болон бусад хууль бус үйлдлээр соёлын үнэт зүйлийг сүйтгэх нь хориотой гэдгийг сануулах ёстой. Бүх төрлийн хулгай, дээрэм болон бусад хууль бусаар завших, соёлын үнэт зүйлийг эвдэхээс хатуу татгалзах нь цэргийн ажиллагааны амжилтын чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг доод албан тушаалтнуудад ойлгуулах хэрэгтэй. Учир нь эдгээр үйлдлүүд нь нутгийн иргэдийн дургүйцлийг төрүүлэх бөгөөд үндэсний хэмжээнд болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлснээр олон нийтийн санаа бодлыг эсрэг хандуулах үр дагавартай. Соёлын хөдлөх үнэт зүйл олдвол холбогдох байгууллагад мэдэгдэхийг цэргүүдэд хэлэх хэрэгтэй.

156. Цэргийн хүчээр эзлэх ажиллагааны нөхцөлд мөрдөх энэ дүрмийн талаар дэлгэрэнгүйг §§185–186-аас үзнэ үү.

(ii) Бусад талууд

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд бусад хүмүүс, тэр дундаа зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр үрэгдүүлэх, сүйтгэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох үүрэгтэй.

157. Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр үрэгдүүлэх, сүйтгэхээс зайлсхийх үүрэгтэйгээс гадна байлдааны ажиллагааны явцад бусад хүмүүс, тэр дундаа зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд ийм бүх үйлдлийг үйлдэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох үүрэгтэй.

- 158.** Бусад тал соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэх үйлдлийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох үүрэг нь зөвхөн цэргийн дайсагнасан ажиллагаанд хамаарахгүй гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй (§§ 187-194-р зүйлийг харах). Нэгдүгээрт, энэ нь олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед гадаадын цэргийн хүчний эзэмшилд байгаа боловч цэргийн хүчээр довтолгооны бүрэн хяналтад хараахан ороогүй байгаа нутаг дэвсгэрт хамаарна. Цэргийн хүчээр эзлэх ажиллагаа хараахан эхлээгүй байгаа үндэслэлээр аливаа улс соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ аваагүйгээ зөвтгөж болохгүй. Цэргийн хүчний хүчин чадалд нийцсэн, үндэслэлтэй гэж үзэх ямар арга хэмжээ авах нь нэг талаас цэргийн дайсагнасан ажиллагаа үргэлжилж байгаа нэгдсэн хяналтад хараахан ороогүй байгаа нутаг дэвсгэр, нөгөө талаас эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хооронд харилцан адилгүй байж болно. Хоёрдугаарт, соёлын үнэт зүйлийг бусад этгээд хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэхийг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох үүрэг нь олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үед ч үйлчилдэг.
- 159.** Бусад тал соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, эвдэн сүйтгэхийг хориглох үүргийг хатуу биелүүлэх ёстой. Зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй аль нэг тал одоогийн үйл ажиллагааныхаа хүрээнд хэн нэгэн этгээд ийм үйлдэл хийхийг хориглохгүй байх үндэслэл байхгүй. Харин ч мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлийг бусад этгээд, тэр дундаа зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох ёстой. Зохион байгуулалттай гэмт бүлэглэл эсвэл өөр хэн нэгэн соёлын үнэт зүйлийг завшиж, сүйтгэж байгаа нь мөргөлдөөнд оролцогч тал хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн үг биш юм. Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын хүлээх үүрэг нь ийм үйлдлээс урьдчилан сэргийлэх, зогсоохын тулд өөрийн эрх мэдлийн хүрээнд шаардлагатай, боломжийн бүхий л арга хэмжээг авах ёстой гэсэн үг. Хэрэв цэргийн хүчин эдгээр зорилгод хүрэхийн тулд чадах бүхнээ хийхгүй бол олон улсын үүргээ зөрчсөн хэрэг болно.
- 160.** Бусад тал соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон хууль бусаар завших, эвдэн сүйтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох нь даалгавраа амжилттай гүйцэтгэхийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг командлагч нар удирдлагадаа байгаа бие бүрэлдэхүүнд ойлгуулах ёстой. Соёлын үнэт зүйлийг дээрэмдэх нь дайсагнагч зэвсэгт

бүлэглэл, террорист байгууллагуудын орлогын эх үүсвэр болдог бол соёлын үнэт зүйлийг сүйтгэх нь зэвсэгт мөргөлдөөнийг хурцатгаж, уртасгах аюултай. Цэргийн албан хаагчид ийм үйлдлийг таслан зогсоох нь ноцтой чухал асуудал болохыг ухамсарлаж зохих ёсоор үүрэгтэй оролцох ёстой.

- 161.** Цэргийн хүчээр эзлэх ажиллагааны нөхцөлд энэ дүрмийн талаар дэлгэрэнгүйг §§187–194 зүйлээс үзнэ үү.

Ё. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАРИУ БАРИХ БАЙДЛААР АШИГЛАХ

Соёлын үнэт зүйлийг өш авах байдлаар хэлмэгдүүлэлтийн объект болгохыг хориглоно.

- 162.** Өмнө нь эсрэг талын цэргийн хүчийг Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийг дагаж мөрдөхийг албадах нэг арга бол хариу барих эсвэл өс авах явдал байв. Хариу барих (reprisal) арга хэмжээ нь Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийг зөрчсөн үйлдэл боловч дайснаа дайны хуулийг дагаж мөрдөхөд түлхэц өгөх зорилгоор түүний хийсэн үйлдэлтэй дүйцүүлэхүйц түвшинд хариу өгсөн гэх үндэслэлээр олон улсын эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөж байсан билээ. Жишээлбэл, хэрэв нэг улс өөр улсын хамгаалалтгүй хотыг бөмбөгдөж, олон мянган энгийн иргэнийг хөнөөсөн бол цаашид дайны хуулийг дагаж мөрдүүлэх зорилгоор бөмбөгдөлтөд өртсөн улс бөмбөгдсөн улсын цэргийн хүчнээс дайнд олзлогдсон зуун цэргийг цаазалж хариу барьж болох байв. Гэвч цаг хугацааны эрхэнд Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн дагуу ийм маягийн хариу барих үйлдэл нь аажмаар хууль бус болсон. Одоо дайнд олзлогдогсад болон бусдыг хариу барих үйлдлээр хэлмэгдүүлэх арга хэмжээ авахыг бүрэн хориглодогтой адил соёлын үнэт зүйлийг ийнхүү хариу барих арга хэмжээний объект болгохыг мөн бүрэн хориглоно. Цэргийн шаардлагатай гэж үзэж байгаа ямар ч үндэслэл нь ийм арга хэмжээг хууль ёсны дагуу зөвтгөхгүй бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд дайны гэмт хэрэг болно.

V. ЗЭВСЭГЛЭН ДОВТЛОХ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ

A. ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЭХЛЭХ, ДУУСГАХ

- 163.** “Зэвсэглэн довтолох” гэдэг нь энгийн үгээр “эзлэх” гэсэн утга бөгөөд аливаа улсын нутаг дэвсгэр хэсэгчлэн эсвэл нийтдээ өөр улсын хяналтад орж, түүний цэргийн хүчний эрхшээлд байх үед бий болох, ОУЗМ-ий хүрээнд тусгайлан ялгаж заасан эрх зүйн байдал юм. Энэхүү эрх зүйн байдал нь ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн дагуу эзлэгч гүрний эрх, үүрэг аль, алиныг нь үүсдэг. Эдгээр эрх, үүрэг нь ямар ч нөхцөлд эзлэгдсэн газар нутгийн бүрэн эрхийг эзлэгч гүрэнд шилжүүлснээр үүсэж байгаа хэрэг биш юм. Зэвсэглэн довтолох нь байлдан дагуулалттай адил биш бөгөөд байлдан дагуулах нь аливаа улс бусад улсын газар нутгийг өмчлөх эрх үүсэх хууль ёсны арга зам байхаа больсон. Харин эсрэгээрээ олон улсын эрх зүйд зааснаар эзлэгч гүрний статус төрийн дээд эрх мэдлийг түр хугацаагаар шилжүүлсэн үед газар нутгийг хамгаалагчаас илүү гарахгүй бөгөөд олон улсын эрх зүйн зүйл заалтууд үндсэндээ эзлэгч гүрэн энэхүү хамгаалах үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх эрхээр хангагдах талаар тусгасан байдаг. Зэвсэглэн довтолох нь бүрэн эрхт төрийн эрх мэдлийг сэргээн тогтоох хүртэл хугацаанд олгогдох түр статусын нэг хэлбэр юм.
- 164.** Эрх зүйн талаас зэвсэглэн довтолох байдал үүссэн эсэх тухай асуудал нь олон улсын эрх зүйд объектив асуулт бөгөөд үүнд хариулахын тулд олон улсын хууль эрх зүйн талаас (§§167–169-р зүйлийг харах) тодорхой шалгуураар тогтоож болно. Үүнийг тодорхойлоход эзлэгч гүрэн өөрийгөө эзлэгч төдий гэх, эсвэл өөрөөр үзэж байгаа нь чухал биш юм. Эзлэгч гүрэн энэ газар нутгийг өөрийн нутгийн бүрэлдэхүүн хэсэг эсвэл бие даасан тусгаар улс гэж үзэх нь мөн ач холбогдолтой биш. Гол нь эзлэгч гүрний субъектив байр сууриас үл хамааран олон улсын эрх зүйн хүрээнд заасны дагуу объектив байдлыг авч үзнэ. Нэгэнт олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр зэвсэглэн довтолох байдал үүссэн гэж үзвэл эзлэгч гүрэн

хүлээн зөвшөөрөх эсэхээс үл хамааран ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн дагуу зохих үүрэг хүлээж, эрхийг эдэлнэ.

- 165.** Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, хууль тогтоомжийн дагуу зэвсэглэн халдах түрэмгийлэлд хамаарахгүй боловч түүнтэй ижил төстэй нөхцөл байдал үүсэх бөгөөд үүнд жишээлбэл өөр улсын нутаг дэвсгэрт төрийн дээд эрх мэдлийг түр хугацаагаар шилжүүлэх эсвэл засаглах эрх мэдлийг бүрэн шилжүүлэх нөхцөл байдал хамаарна. Тухайлбал, нэг буюу хэд хэдэн гаднын улсын цэргийн хүчин хамтран НҮБ-ын гишүүн улсын нутаг дэвсгэрт байрлан Аюулгүйн Зөвлөлийн тогтоолоор НҮБ-ын иргэний засаглал эсвэл ижил төстэй бусад үйл ажиллагааг дэмжихээр тогтворжуулах үйл ажиллагаанд оролцох гэх мэт. Олон улсын эрх зүйн практикт зэвсэглэн халдахтай холбоотой хууль тогтоомж ийм төрлийн ажиллагаанд үйлчлэхгүй. Гэвч аюулгүйн зөвлөлийн бүрэн эрх болон тухайн улсын зүгээс шаардах аливаа шаардлагын дагуу ийм ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн үндэсний цэргийн анги нэгтгэлүүд үйл ажиллагаагаа зэвсэглэн халдах үеийн зохицуулалт ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ-ийн заалт, соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай хуульд үндэслэхгүй байх шалтгаан байхгүй. Энэ төрлийн үйл ажиллагаанд оролцож байгаа цэргийн анги нэгтгэлүүдийн ажиллагааг зэвсэглэн халдах үед соёлын үнэт зүйлийг хамгаалах шилдэг арга гэж үзэхгүй байх шалтгаан байна гэж үү?
- 166.** Зэвсэглэн халдах гэдэг нэр томъёоны тодорхойлолт ёсоор энэ ойлголт нь ОУБЗМ-д хамаарахгүй гэдгийг анхаарах шаардлагатай.

Дайсагнагч армийн мэдэлд орсон тохиолдолд тухайн газар нутгийг эзлэгдсэн гэж үзнэ. Эзлэн түрэмгийлэл нь зөвхөн эрх мэдлээ тогтоож, засаглах боломжтой болсон газар нутгаар хязгаарлагдана.

- 167.** Олон улсын заншлын эрх зүйд эзлэгч армийн удирдлага, захиргаанд орсон тохиолдолд тухайн газар нутгийг эзлэгдсэн гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, гадаад улсын цэргийн хүч тухайн газар нутаг дахь бүрэн эрх, өмнөх цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэгч, эсвэл хяналтаа тогтоосон өмнөх хүчний бүрэн эрхийг халж улсын дээд эрхийг гартаа авахад зэвсэглэн довтлох эрх зүйн нөхцөл байдал бүрдэнэ. Албан ёсны баримт, үйлдэл хийх шаардлагагүй, маш энгийн зүйл. Дайсагнагч арми аливаа өөр өрсөлдөгч эрх мэдэл, засаглалыг тухайн нутаг дэвсгэрээс гаргаж, өөрийн хяналтыг бодитоор тогтоосон бол олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлсны дагуу тухайн газар нутгийг цэргийн хүчээр

эзэлсэн гэж үзнэ. Эрх мэдэл, засаглалыг ийнхүү хяналтдаа авах мөчөөс эзлэлт эхэлж, хянахаас татгалзах эсвэл түүнийг алдах мөчид дуусна.

- 168.** Эзлэн түрэмгийлэх ажиллагааг нутаг дэвсгэрт хяналт тогтоох явцаар тодорхойлдог учир зөвхөн газар зүйн хувьд эрх мэдэл тогтоож, засаглах боломжтой нутаг дэвсгэрт хамааруулан ойлгоно. Иймээс эзлэгдсэн газар нутгийн эргэн тойронд дайсагнал үргэлжилсэн хэвээр байх эсвэл цэргийн дайсагнасан ажиллагаа дахин эхлэх тохиолдол бий.
- 169.** Өмнөх эрх мэдэл, засаглалыг түлхэн унагаах гэдэг нь орон нутгийн засаг захиргааг тараах гэсэн үг биш. Орон нутгийн засаг захиргааны эрх бүхий байгууллага, тэр дундаа соёлын үнэт зүйлийг хадгалах, хамгаалах асуудал эрхэлсэн байгууллагууд хэвээрээ байж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх нь зүйтэй. Зэвсэглэн довтолох гэдэг нь эзлэн түрэмгийлэх ажиллагаа үргэлжлэх хугацаанд эдгээр орон нутгийн эрх бүхий байгууллагууд эрх мэдлээ алдсан улс төрийн эрх баригчдаас аливаа нэгэн тушаал шийдвэр авч дагаж мөрдөхгүй байхыг хэлнэ.

B. ЭЗЛЭГЧ ГҮРНИЙ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

Эзлэгч гүрэн эрх мэдлийнхээ хүрээнд нийтийн хэв журам, иргэдийн амьдралыг аль болох хурдан хугацаанд хэвийн байдалд оруулах бүх арга хэмжээг авахын зэрэгцээ бүрмөсөн хязгаарснаас бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дээдэлнэ.

- 170.** Эзлэгч гүрний хүлээх ерөнхий үүрэг нь хоёр үүргээс бүрдэх бөгөөд эзлэгдсэн нутаг дэвсгэр, түүний оршин суугчдыг эзлэгч гүрэн нь түр хугацаанд хамгаалагч байхаас хэтрэхгүй гэсэн үндэслэл дээр суурилсан юм. Эдгээр ерөнхий үүргийн аль алинд нь эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг хамгаалах, хадгалах үүрэг хамааралтай.
- 171.** Хоёр дугаар үүргийг нэн тэргүүнд авч үзвэл эзлэгч гүрэн бүрмөсөн хязгаарлагдсанаас бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дээдлэх ёстой. Соёлын үнэт зүйлийн тухайд эзлэгч гүрэн өмнө тухайн нутаг дэвсгэрт (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоож чадсан бол далай тэнгис хамаарна) мөрдөгдөж байсан соёлын үл хөдлөх болон хөдлөх үнэт зүйлийг хамгаалах, хадгалах аливаа хуулийг хэвээр нь дагаж мөрдөх ёстой. Энэ нь эзлэгч тал орон нутгийн эрх бүхий байгууллагуудад

дээрх хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгох ёстой гэдэг нь ойлгомжтой.

- 172.** Энэхүү ерөнхий үүргийн нэг хэсэг нь бүрмөсөн хязгаарлагдсанаас бусад тохиолдолд эзлэгч гүрэн тухайн нутаг дэвсгэрт археологийн малтлага хийх зөвшөөрлийг зохицуулах хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой. Археологийн малтлага хийх хуулийн зохицуулалт хэрэгжиж байгаа тохиолдолд эзлэгч гүрэн холбогдох хуульд зааснаас бусад тохиолдолд тухайн нутаг дэвсгэрт малтлага хийхэд оролцох, ивээн тэтгэх эрхгүй. Мөн өөрөө малтлага хийх зөвшөөрөл олгох, соёлын үнэт зүйлийг экспортлох, өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, нүүлгэн шилжүүлэх соёлын үнэт зүйлийн зориулалтыг өөрчлөх зэргээр орон нутгийн эрх бүхий байгууллагын эрх мэдлийг булаан авахыг хориглоно.
- 173.** Нэгдүгээр ерөнхий үүргийн тухайд бол эзлэгч гүрэн тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэв журмыг сэргээх, ард иргэдийг амьдралыг баталгаажуулахын тулд олгогдсон эрх мэдлийн хүрээнд бүх арга хэмжээг авах ёстой. Энэ заалт соёлын үнэт зүйлийг хамгаалахад мөн хамаарна.
- 174.** Нэн тэргүүнд эзлэгч гүрэн тухайн нутаг дэвсгэр (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон далай тэнгис хамаарна)-т соёлын үнэт зүйлийг завших, хорлон сүйтгэхийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийг аль болох хангах ёстой. Соёлын үнэт зүйлийг илүү өргөн хүрээнд хадгалах тухай хуулиуд, тухайлбал, эмзэг байдалтай дурсгалт газрууд болон тэдгээрийн ойролцоох барилга байгууламжийн талаарх орон нутгийн төлөвлөлтийн хууль, түүхийн дурсгал барилгуудыг сэргээн засварлах, өөрчлөх тухай хууль, археологийн малтлага хийх зөвшөөрөл олгох тухай хууль, урлаг, эртний эдлэлийн худалдаа, түүний дотор экспортын хяналтын тухай хуулийг мөн адил хэрэгжүүлнэ. Энгийнээр хэлбэл хоёр дахь ерөнхий үүрэг нь тухайн газар нутгийн соёлын үнэт зүйлийн тухай хуулийг хэвээр нь үлдээж, дагаж мөрдөхийг шаарддаг бол, эхний үүрэг нь бусад этгээдүүдэд хуулийг дагаж мөрдүүлэх буюу хуулийн хэрэгжилтийг аль болох хангахыг шаардана. Энэ заалтыг хэрэгжүүлэхэд нөхцөл байдал ихээхэн нөлөөлнө. Зарим тохиолдолд энэ нь эрх бүхий захиргааны байгууллага, цагдаа, шүүхийн үйл ажиллагаанд аль болох хөндлөнгөөс оролцохгүй байхыг хэлэх бол өөр нөхцөлд соёлын үнэт зүйлийн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд туслахыг шаардаж болно. Түүгээр ч зогсохгүй онцгой нөхцөлд эзлэгч гүрэн газар дээр нь үзлэг хийх, гарал үүсэл нь эргэлзээтэй соёлын үнэт зүйлийг хураан авах, сэжигтнийг баривчлах, орон нутгийн шүүх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд цэргийн шүүхээр яллах зэрэг арга хэмжээ

авах замаар соёлын үнэт зүйлийн тухай хуулийг өөрөө хэрэгжүүлэхийг шаардлагатай байж болно.

- 175.** Мөн, нэгдүгээр ерөнхий үүрэг нь шаардлагатай тохиолдолд нийтийн хэв журам сахиулах, иргэдийн амьдралын баталгааг хангах зорилгоор эзлэгдсэн нутаг дэвсгэр (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, харьяаны далай тэнгис хамаарна)-т хууль батлахыг эзлэгч гүрэнд зөвшөөрдөг. Үүнд соёлын үнэт зүйлийг хамгаалах, хадгалах тухай хууль хамаарна. Түүнчлэн нэгдүгээр ерөнхий үүрэг нь эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлтэй холбоотой Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээсэн тодорхой үүргээ биелүүлэхэд шаардлагатай аливаа хууль тогтоомжийг батлахыг эзлэгч гүрэнд зөвшөөрдөг. Дээрх үүргүүдээс дараах жишээг дурдаж болно. Үүнд соёлын үнэт зүйлийн бүх хэлбэрийн хулгай, дээрэм, хувьдаа завших эсвэл эвдэн сүйтгэх үйлдлийг хориглохтой холбоотой заншлын болон гэрээнд суурилсан үүрэг (§§187–194-р зүйлийг харах); соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох болон хураах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой заншлын болон гэрээнд суурилсан үүрэг (§§203–205-р зүйлийг харах); соёлын үнэт зүйлийг хамгаалах, бүртгэх, хадгалахаас өөр зорилгоор археологийн аливаа малтлага хийхийг хориглох тухай гэрээнд суурилсан үүрэг (§§206–209-р зүйлийг харах); соёл, түүх, шинжлэх ухааны нотлох баримтыг нуун дарагдуулах, устгах зорилгоор соёлын үнэт зүйлийг өөрчлөх, зориулалтыг өөрчлөхийг хориглох тухай гэрээнд үндэслэсэн үүрэг (§§210–212-р зүйлийг харах)-тэй холбоотой хууль тогтоомж зэрэг болно.

V. ЦЭРГИЙН ДАЙСАГНАСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕЭР ХҮЛЭЭХ ҮҮРЭГТЭЙ ИЖИЛ БОЛОХ НЬ

- 176.** Цэргийн дайсагнасан ажиллагааны үеэр зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын хүлээх үүргийн дийлэнх нь эзлэн түрэмгийлэх ажиллагааны явцад эзлэгч гүрний хүлээсэн олон үүрэгтэй адил заавал биелүүлэх зарчмаар үйлчилнэ. Аль алиных нь хувьд IV хэсэгт дурдсан зүйлсийн ихэнх нь хамаарах бөгөөд шаардлагатай нэмэлт асуудлыг энэ хэсэгт тусгасан болно.

(i) Соёлын үнэт зүйлийг тодорхойлох

- 177.** Цэргийн дайсагнасан ажиллагааны үеэр (§§71–82-р зүйлийг харах)-д авах арга хэмжээтэй адилаар зэвсэглэн довтолох үед соёлын үнэт зүйлийг хамгаалах нэн тэргүүний үндсэн урьдчилсан арга хэмжээ бол

хамгаалах ёстой соёлын үнэт зүйлийг ялган тодорхойлох, байршлыг тогтоох, үүнтэй холбоотой мэдээллийг цэргийн ажиллагаанд оролцогч талуудад үр дүнтэй арга замаар хүргэх явдал юм.

Дэлхийн II дайны үед Европт өрнөсөн цэргийн үйл ажиллагааны үеэр соёлын ач холбогдол бүхий эд зүйлс, барилга байгууламж, дурсгалт газруудыг зүйлчилсэн жагсаалт бүхий бүсийн гарын авлагыг АНУ-ын цэргийн командлагч нарт тарааж байв. Эзлэгдсэн Германы тухайд Холбоотны цэргийн хүчний Дээд удирдлагаас “Германы тусгай хамгаалалттай хөшөө дурсгалын албан ёсны жагсаалт”, Герман дахь АНУ-ын бүс дэх архитектур, түүх, соёлын ач холбогдолтой тусгай хамгаалалттай байгууламж, байршлын (Холбоотны цэргийн хүчний Дээд удирдлага хянасан) албан ёсны жагсаалт болон “Герман дахь Сүм хийд, музей, номын сан болон бусад соёлын байгууллагуудын атлас” нэртэй М336–17 дугаартай Армийн үйлчилгээний хүчний гарын авлагын хамт тараажээ.

178. Цэргийн дайсагнасан ажиллагааны үеэр (§82-р зүйлийг харах)-д авах арга хэмжээний адилаар цэргийн хүч цөмрөн орсон объект, байгууламж, газар орны соёлын ач холбогдлыг үнэлэх, мөн периметрийг нь оновчтой тодорхойлоогүй археологийн болон бусад түүхэн дурсгалт газрын газарзүйн цар хүрээг тогтоох зэрэг ажлыг холбогдох мэргэжлийн шинжээчдээр хийлгэх ёстой. Эдгээр зорилгын үүднээс юуны түрүүнд тухайн улсын соёлын үнэт зүйлийн хадгалалт, менежментийг хариуцсан үндэсний эрх бүхий байгууллагуудад хандах ёстой. Хэрэв ийм эрх бүхий байгууллага байхгүй бол соёлын үнэт зүйлийг хамгаалах үүргийг эзлэгч гүрний цэргийн хүчний мэргэжлийн алба, боловсон хүчин хариуцна. Эдгээр алба, ажилтнууд нь археологич, урлагийн түүхч, орон нутгийн иргэд, шашны болон бусад нөлөө бүхий хүмүүс зэрэг иргэний нийгмийн мэргэжлийн хүмүүсээс тусламж хүсэх нь зүйтэй. Мөн ЮНЕСКО болон бусад зохих байгууллага, институцээс зөвлөгөө, тусламж авах нь зүйтэй юм.

(ii) Соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах

179. Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйл нь эзлэгч гүрний цэргийн хүчний хяналтад ордог. Иймээс, эзлэгч гүрэн цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд эдгээр өмчийг устгах, хохирол учруулахыг хориглоно (§§125–127-р зүйлийг харах). Цэргийн

дайсагнасан ажиллагааны үеэр үйлчлэх зохицуулалтын адилаар эзлэгдсэн нутаг дэвсгэрт цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад үндэслэлээр аливаа соёлын үнэт зүйлийг эвдэн сүйтгэх нь дайны гэмт хэрэгт тооцогдоно. Гэмт этгээдүүдэд олон улсын болон үндэсний эрүүгийн шүүхээс ял өгч байсан тохиолдол бий.

- 180.** Эзлэгч гүрэн 1999 оны II Протоколоор үүрэг хүлээсэн тохиолдолд нөхцөл байдалд нийцэхгүй байгаагаас бусад тохиолдолд цэргийн зайлшгүй шаардлагаар соёлын үнэт зүйлийг устгах, гэмтээх аливаа шийдвэрийг хамгийн багадаа нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг удирдаж байгаа цэргийн албан тушаалтан гаргах ёстой. (§128-р зүйлийг харах). Протоколоор үүрэг хүлээгээгүй улс орнууд ч мөн адил дээрх дүрмийг дагаж мөрдвөл зохино.
- 181.** Эрчимжүүлсэн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлийн тухайд 1999 оны II Протоколоор үүрэг хүлээсэн тохиолдолд эзлэгч гүрэн ямар ч нөхцөлд соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг бүрэн хориглоно (§129-р зүйлийг харах). Цэргийн хэрэгцээ шаардлагатай холбоотой ямар ч үндэслэл ийм үйлдлийг зөвтгөх боломжгүй. Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн хувьд мөн адил энэ дүрмийг баримтлах нь зүйтэй.

(iii) Соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын газрыг ашиглах

- 182.** Цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойронд байгаа газрыг устгах, хохирол учруулах нөхцөлд хүргэж болзошгүй аливаа зориулалтаар ашиглахыг хориглосон заалт (§§130–137-р зүйлийг харах) нь зэвсэглэн довтлох үед онцгой практик ач холбогдолтой болдог. Учир нь ашиглах боломжтой барилга байгууламжид штаб, цэргээ байрлуулах, хуаран барих зэргээр газар шорооны ажил хийх, хүнд машин механизм ашиглах, моторт тээврийн хэрэгсэл, нисдэг тэрэгний хөдөлгөөн өрнөх зэргээр соёлын үнэт зүйлийн хадгалалт, хамгаалалтад эрсдэл учруулах бусад үйл ажиллагаа явуулах магадлал өндөр байдаг. Зэвсэглэн довтлох үед цэргийн дайсагнасан ажиллагааны үеийнхтэй адилаар цэргийн зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын газрын хадгалалтын нөхцөл байдлыг дордуулах, эвдэн сүйтгэх, тонон дээрэмдэх эрсдэлд өртөхөд хүргэж болзошгүй байдлаар ашиглахыг хориглоно.
- 183.** Зэвсэглэн довтлох явцад соёлын үнэт зүйл, түүний эргэн тойронд байгаа эд хөрөнгийг сүйтгэх, хохирол учруулах эрсдэлд өртөхөд хүргэж болзошгүй байдлаар ашиглуулахгүй байхын тулд командлагч нарын зүгээс алсыг хараатай, төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Урьдчилан

сэргийлэхийн тулд командлагч нар хориглосон барилга байгууламж, байршлуудад цэрэг дайчдыг байрлахыг хориглох шаардлагатай.

Эйзенхауэрын 1943 оны 12-р сарын 29-ний өдрийн 68 тоот ерөнхий тушаалд (§42-р зүйлийг харах) дараах байдлаар тусгасан болно. Үүнд:

1. Барилга байгууламж.

(а) Холбоотны цэргийн засгийн газрын бүх офицеруудад Улс төрийн дайны удирдах газраас олгосон Италийн “Бүсийн гарын авлага”-ын “Урлагийн бүтээл” хэсгийн жагсаалтад орсон ямар ч барилгыг ямар ч тохиолдолд, 15-р армийн бүлгийн ерөнхий командлагч эсвэл ерөнхий офицер Холбоотны командлагчийн тодорхой зөвшөөрөлгүйгээр цэргийн зориулалтаар ашиглахыг хориглоно.

(б) Хариуцсан командлагч нар шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ болгон АМГ-ын “Бүсийн гарын авлага”-д орсон аливаа барилгыг хаах, цэргүүдийг байршлаас гаргах эрхтэй.

Энэ тухай мэдэгдлийг барилгуудад нааж, шаардлагатай тохиолдолд харуул хамгаалалт гаргана.

(в) Холбоотны цэргийн офицерууд командлагч нарт АМГ “Бүсийн гарын авлага”-ын жагсаалтад ороогүй түүхэн барилгуудын жагсаалтыг гаргаж өгнө. Эдгээр барилгууд нь хоёрдугаар зэргийн ач холбогдолтой бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цэргийн зориулалтаар ашиглаж болно. Ашиглах боломжтой өөр барилга байгууламж байгаа үед уран зургийн цуглуулга, шинжлэх ухааны бүтээл агуулсан барилга байгууламжийг ашиглахгүй байхыг командлагч нарт анхааруулна.

Эдгээр заалтыг 1944 оны 5-р сарын 26-нд гаргасан ижил төстэй цэргийн удирдамжид давхар тусгажээ.

- 184.** Орон нутгийн иргэдийн дургүйцлийг төрүүлж, улмаар цэргийн хүчний аюулгүй байдалд эрсдэл дагуулахгүйн тулд соёлын үнэт зүйл, ялангуяа шашны байгууллагад эзлэгч хүчний зүгээс хохирол учрахаас сэргийлэх хэрэгтэй. Командлагч нар түүхэн дурсгалт газар, археологийн дурсгалт газрууд, музей, галерей, номын сан болон бусад цуглуулга агуулсан урлаг, архитектурын ач холбогдолтой барилга байгууламжийн эргэн тойронд анхаарал болгоомжтой ажиллах шаардлагатайг бие бүрэлдэхүүндээ онцгойлон анхааруулахын тулд боломжтой бүх үйлдлийг хийх ёстой.

(iv) Соёлын үнэт зүйлийг завших, эвдэн сүйтгэх

(a) Цэргийн хүчнийхэн өөрсдөө завших, эвдэн сүйтгэх

185. Зэвсэглэн довтолох ажиллагааны үед цэргийн дайсагнасан ажиллагааны үеийнхтэй нэгэн адилаар (§§154–156) цэргийн хүчнийхэн соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, эвдэн сүйтгэхийг бүрэн хориглоно. Энэ төрлийн бүх санаатай үйлдэл нь дайны гэмт хэрэг болдог. Командлагчид энэ төрлийн хориг, түүний үр дагаврыг ерөнхий тушаал гаргах зэрэг арга замаар доод албан тушаалтнуудад ойлгуулж, сахилгын шийтгэл оногдуулж, шаардлагатай тохиолдолд хэргийг цэргийн эсвэл иргэний эрүүгийн шүүхэд хандан шийдвэрлүүлэх замаар хоригийг хатуу хэрэгжүүлэх ёстой. Цэргийн анги нэгтгэлийг соёлын ач холбогдол бүхий барилга байгууламж, газраас гадуур байрлуулах шаардлага гардаг.

Эйзенхауэрын 1943 оны 12-р сарын 29-ний өдрийн 68 тоот ерөнхий тушаалд (өмнөх §42-р зүйлийг харах) хэсэгчлэн заасан:

2. Дээрэм тонуул, зүй бусаар хохирол учруулах болон сүйтгэх

Барилга байгууламжийг дээрэмдэх, зүй бусаар хохирол учруулах, сүйтгэхээс урьдчилан сэргийлэх үүрэг командлагчид оногдоно. Ийм төрлийн аливаа үйлдэл ноцтойд тооцогдохыг Холбоотны бүх бие бүрэлдэхүүнд тайлбарлан таниулна.

Эдгээр заалтыг 1944 оны 5-р сарын 26-ны өдрийн ижил төстэй цэргийн удирдамжид давхар тусгажээ.

186. Цэргийн дайсагнасан ажиллагааны үетэй нэгэн адилаар (§155-р зүйлийг харах) цэрэг хүн ямар ч гэм хор учруулаагүй гэж бодож аливаа бэлэг дурсгалын зүйлийг өөрт авах эсвэл гэм зэмгүй граффити зурах зэрэг үйлдэл нь зэвсэгт мөргөлдөөний хууль тогтоомжийг зөрчиж байгаа тул дайныгэмт хэрэг үйлдсэн хэргээр хариуцлага хүлээх магадлалтай гэдгийг командлагч нар тодорхой хэлэх ёстой. Командлагч нар мөн эдгээр үйлдэл нь орон нутгийн иргэдийн дургүйцлийг төрүүлэх, улмаар үндэсний болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн шүүмжлэлд өртөж болзошгүй учир соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэх үйлдлийг хатуу хориглох нь цэргийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэх чухал элемент болдгийг доод албан

тушаалтнуудад онцгойлон анхааруулбал зохино. Цэрэг дайчид соёлын хөдлөх үнэт зүйл олдвол холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

(б) Бусад талууд завших, эвдэн сүйтгэх

- 187.** Эзлэгч гүрний зүгээс эзлэгдсэн газар нутгийн соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, эвдэн сүйтгэхээс зайлсхийхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд гэх мэт бусад этгээд ийм үйлдэл хийхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох үүрэгтэй. (§§157–161-р зүйлийг харах). Далай тэнгисийн эргийн газар нутгийг зэвсэглэн довтлох үед эргэн тойронд байгаа далай тэнгисийн орон зайг хяналтдаа авсан бол далай тэнгисийн ёроол дахь соёлын үнэт зүйлийг бүх төрлийн хулгай, дээрэм, хууль бусаар ашиглах, эвдэн сүйтгэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох үүрэгтэй.
- 188.** Эзлэгч гүрэн нь тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэв журмыг сэргээж, ард иргэдийн хэвийн амьдралыг аль болох хангахын тулд өөрийн эрх мэдлийн хүрээнд бүх арга хэмжээг авах нийтлэг үүрэгтэй. Тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэв журмыг сэргээж, ард иргэдийн хэвийн амьдралыг хангахын тулд олгогдсон эрх мэдлийн хүрээнд бүх арга хэмжээг авах нийтлэг үүргийг цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэгч гүрэн хүлээдэг. Энэ үүргийн хүрээнд мөн тухайн нутаг дэвсгэрт (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоож чадсан бол далай тэнгис хамаарна) соёлын үнэт зүйлийг завших, сүйтгэх үйлдлийг хориглосон хууль тогтоомжийг мөрдөх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ зорилгоор хууль тогтоомжийг батлах эрхтэй. (§175-р зүйлийг харах). Зэвсэглэн довтлох үеийн соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай тусгай журмаар шаардах нэг нэмэлт зүйл бол эзлэгч гүрэнд зохих эрхийг олгоод зогсохгүй тийнхүү үйлдэхийг шаардана. Үүнд соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэхийг хориглоно. Энэхүү үүрэг нь эзлэгч гүрний нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг хөндөхгүйгээр үлдээх ерөнхий үүрэгтэй зэрэгцэн, нэмэлт болно. Үүнтэй холбоотой уг хориг нь практикт тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд заасан ижил төстэй хоригт нэмэлт байж болно. Ялгаатай тал нь орон нутгийн шүүхээр бус эзлэгч гүрний цэргийн шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой.
- 189.** Эзлэгч гүрэн соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, хохирол учруулах үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нэмэлт үүрэг гэдэг нь эзлэгч гүрэн эдгээр зорилгоор өөрийн эрх мэдлийн хүрээнд шаардлагатай, боломжит бүхий л арга

хэмжээг авах ёстой гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл чадах бүхнээ хийх ёстой гэсэн үг. Цэргийн дайсагнасан ажиллагааны үеийнхтэй нэгэн адилаар (§160-р зүйлийг харах) командлагч нар эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох нь даалгаврыг амжилттай хэрэгжүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг доод албан тушаалтнуудад онцгойлон анхааруулах ёстой.

- 190.** Зэвсэглэн довтолох ажиллагааны үед соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, завших, сүйтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд командлагч нар музей, галерей, номын сан болон бусад цуглуулга, түүнчлэн археологийн дурсгалт газрууд, түүхэн барилга байгууламжид олон нийт орохыг хориглох, зэвсэгт харуул байрлуулах, дээрэм тонуулыг таслан зогсоох, шаардлагатай тохиолдолд зогсоох зорилгоор эргүүл хийх, тухайн нутаг дэвсгэрт эртний эд зүйлс, урлагийн бүтээл, гар бичмэл зэргийг худалдах, худалдан авахыг хориглох зэрэг арга хэмжээ авахаас гадна соёлын хөдлөх үнэт зүйлийг хулгайлсан, хууль бусаар ухсан, хууль бусаар наймаалсан хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийн байр, түүний дотор гэрт нь үзлэг хийх, хулгайлагдсан, хууль бусаар малтлага хийсэн, хууль бусаар ашигласан гэж сэжиглэгдэж буй соёлын үнэт зүйлийг хураан авах зэрэг арга хэмжээ авах үүрэгтэй. Далай тэнгисийн эргийн нутаг дэвсгэрийг эзлэн авсан үед хэрэв далай, тэнгисийн усанд шаардлагатай хяналтыг тогтоож чадсан бол тэнгисийн ёроол дахь аливаа усан доорх соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, зориулалтын бусаар завших, сүйтгэх бүх үйлдлийг таслан зогсоох үүрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд сүйрсэн болон живсэн байгууламжийн эргэн тойронд далай тэнгисийн бүсийг тогтоох, газар дээр нь очиж үзэх, эрэн сурвалжлах дэглэм тогтоох зэрэг шаардлагатай бөгөөд боломжтой бүхий л үйл ажиллагааг хийх ёстой.

Дэлхийн 2-р дайны үед эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх Их Британи, АНУ-ын цэргийн засгийн газрууд эзлэгч гүрний хувьд эрхээ хэрэгжүүлэх, нийтлэг үүргээ биелүүлэхийн тулд орон нутгийн хүн ам болон бусад иргэдээс соёлын үл хөдлөх болон хөдлөх үнэт зүйлийг хамгаалахтай холбоотой дүрэм журмыг баталж байв. Жишээлбэл, 1943 оны 11-р сарын 24-нд Италийн эзлэгдсэн колони болох Триполитани, Киренаика дахь Их Британийн цэргийн захиргаа, одоогийн Ливийн нутаг дэвсгэр дэх эртний дурсгалт зүйлсийг хадгалах тухай тунхаг гаргаж, цэргийн засгийн газарт бүх эртний олдворуудыг түр хугацаагаар өмчилж, тэдгээрийг зөвшөөрөлгүй ухах, нүүлгэх, худалдах, нуун дарагдуулах, устгахыг хориглох эрхийг олгож байв.

Аюулгүйн зөвлөлийн 1483 (2003) тогтоолын дагуу тогтворжуулах ажиллагаанд оролцуулахаар 2003 оноос хойш Иракт байрлуулсан олон үндэстний анги нэгтгэлүүд эзлэгч гүрний хувиар бус, Иракт археологийн дурсгалт газруудад нууцаар малтлага хийхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээ авчээ. Жишээлбэл, Испанийн цэргүүд Тел-Нуффар (эртний Нибру/Ниппур) дахь талбайг бүхэлд нь долоон километр төмөр утсаар бүслэн, нисдэг тэргээр тогтмол эргүүлийн нислэг үйлдэж, хяналтдаа авч байв. Үүний дараа Польшийн цэргүүд өөрийн хяналтад байсан археологийн дурсгалт газруудыг мөнадил хамгаалж байсан. Голландын цэргүүд Варка (эртний Урук) хотын уламжлалт Бедуины асран хамгаалагчдад Голландын Батлан хамгаалах яам болон Дойчес Археологийн Институтээс төлбөрийг тасралтгүй баталгаажуулан өгч байснаас гадна нэг удаа хамгаалалтын ажилд туслан дээрэмчдийг саатуулж, олзыг нь хураан авч буцаан өгөхөөр шаардлагатай байршлуудад очиж ажиллаж байв. Италийн Соёлын өвийг хамгаалах Карабиенири алба (§69-р зүйлийг харах) нь Ди Кар мужийн археологийн дурсгалт газруудыг дээрэмдэх, сүйтгэхээс сэргийлж, хулгайлагдсан олдворуудыг сэргээхэд чиглэсэн арга хэмжээ авч байв.

- 191.** Эзлэгдсэн нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийг завших, сүйтгэхээс урьдчилан сэргийлэх ажилд эзлэгдсэн арми болон нутгийн ард түмэн, түүний дотор иргэдийн болон шашны удирдагчдын хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа чухал үр дүнтэй. Нутгийн иргэд болон орон нутгийн удирдлага ийм үйлдлийн талаар, ялангуяа холбогдох хүмүүс нь гаднын хүмүүс байгаа тохиолдолд мэдээлэл өгөхөд бэлэн байдаг. Мөн

хэрэгт холбоотой эсвэл сэжиглэгдэж буй хүмүүс нь тухайн нутгийн иргэд байгаа тохиолдолд тэдэнд нийгмийн дарамт шахалт үзүүлэхэд бэлэн байдаг. Эзлэгч гүрнийхэн орон нутгийн соёлын үнэт зүйлийг хамгаалахын тулд чадах бүхнээ хийж, барилга байгууламж, ялангуяа шашны дурсгалт газруудыг хамгаалах, орон байр, ялангуяа байшинг нэгжих үедээ соёлын мэдрэмжтэй байх тохиолдолд нутгийн иргэд тэдэнтэй хамтарч ажиллах магадлалтай байдаг.

192. Эзлэгч хүчнийхэн соёлын үнэт зүйлийг бүх хэлбэрээр завшихаас урьдчилан сэргийлэх энгийн боловч чухал арга бол хулгайч, наймаачдыг зах зээлээр хангахгүй байх явдал юм. Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа цэргийн хүчин соёлын хөдлөх эд хөрөнгө худалдаж авахгүй байх хэрэгтэй ба “бэлэг дурсгал” худалдаж авах нь өөрсдийн аюулгүй байдал болон тухайн газар нутгийн оршин суугчдын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүйг захирагч нар доод албан тушаалтнуудад ойлгуулах ёстой. Командлагч нар цэргүүдийн худалдаж авсан хууль бусаар худалдаалагдсан соёлын эд зүйлсийг хураан авч боломжтой бол хууль ёсны эзэнд нь буцааж өгөх үүрэгтэй.

193. Зэвсэглэн довтолох үед соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, завших, сүйтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нь тухайн нутаг дэвсгэрт хяналт тогтоохоос өмнө командлагчдыг алсын хараатай, сайтар бодож төлөвлөхийг шаарддаг. Цэргийн хүчнүүд дээрэм, эвдэн сүйтгэх эрсдэлд өртөж болзошгүй барилга байгууламж, газрыг цаг тухайд нь тодорхойлж, аюулгүй болгохын тулд шуурхай ажиллах шаардлагатай. Энэ нь аливаа түр зуурын үймээн самууны явцад ямар шашин шүтлэг эсвэл цөөнхийн бүлэг дайралтад өртөх магадлалтай талаар тооцоолох шаардлагатай байж болох юм.

1943 оны 12-р сард АНУ-ын Хөшөө дурсгал, Дүрслэх Урлаг, Архивын ажилтнууд Ромыг холбоотны хүчинд эзлэгдсэний дараа түүхэн барилгуудыг хамгаалах төлөвлөгөөг яаравчлан боловсруулжээ. 1944 оны 6-р сард Ромыг эзлэн авахад эдгээр ажилтнууд АНУ-ын цэргийн анги нэгтгэлүүдээс өмнө Ром хотод орж ирсэн байв.

194. Эзлэгч зэвсэгт хүчин нь хулгайлагдсан урлагийн бүтээл, эртний үнэт эдлэлийн талаар хулгайлагдсан соёлын үнэт зүйлийн тухай сэрэмжлүүлэг мэдээг олон улсын түвшинд түгээдэг ЮНЕСКО, хулгайлагдсан урлагийн бүтээлийн мэдээллийн санг хөтөлдөг ИНТЕРПОЛ, хууль бусаар худалдах, худалдан авах эрсдэлтэй соёлын объектуудын “Улаан жагсаалт”-ыг түгээдэг Олон улсын музейн зөвлөлд тус тус мэдэгдэх замаар соёлын

үнэт зүйлийг завших явдлыг таслан зогсоох, цаашлаад урьдчилан сэргийлэхэд ажилд тусалж болно.

Г. ЦЭРГИЙН ХҮЧЭЭР ЭЗЛЭН ТҮРЭМГИЙЛЭЧДИЙН ХҮЛЭЭХ ОНЦГОЙ ҮҮРЭГ

(i) Эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэх

- 195.** Цэргийн хүчээр эзлэн түрэмгийллийн хуулийн дагуу (§171-р зүйлийг харах) хүлээх нийтлэг үүргийн нэг нь эзлэгч гүрэн тухайн нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийг хариуцдаг аливаа захиргааны байгууллагуудыг бүрэн бүтэн, чөлөөтэй ажиллуулах ёстой. Энэ нь олон улсын эрх зүйгээр эзлэгч гүрний хүлээсэн соёлын үнэт зүйлтэй холбоотой тодорхой үүрэг хариуцлагын дагуу тухайн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг хамгаалах үүрэг нь эзлэлтийн үед эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий байгууллагуудад оногдсоор байна гэсэн үг юм. Гэсэн хэдий ч эзлэгч гүрэн нь эдгээр байгууллагуудыг ажлаа явуулах боломжоор хангахаас илүүг хийх ёстой. Энэ талаар хоёр поситив үүрэг хүлээдэг.

Эзлэгч гүрэн соёлын үнэт зүйлийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахад орон нутгийн эрх бүхий байгууллагыг аль болох дэмжих ёстой.

- 196.** Эзлэгч гүрэн нь тэдний ажилд саад учруулахгүй байх үүргээсээ илүүтэйгээр тухайн нутаг дэвсгэрт байгаа соёлын үнэт зүйлийг аюулгүй байдлыг хангах, хамгаалахад эрх бүхий байгууллагуудад аль болох идэвхтэй дэмжлэг үзүүлэх ёстой.

Дэлхийн 2-р дайны дараа Германы Цэргийн засгийн газрын албанаас гаргасан Цэргийн засгийн газрын дүрмийн 18-р зүйл ('Хөшөө дурсгал, дүрслэх урлаг, архив')-д АНУ-ын эзлэлтийн бүс дэх хэд хэдэн мужуудын Цэргийн засгийн газрын албад Германы эрх бүхий байгууллагуудаас хүсэлт гаргавал "соёлын байгууламжийг хамгаалахад зохих тусламж" үзүүлэх үүрэгтэй гэж заасан.

2003 оноос Аюулгүйн зөвлөлийн тогтворжуулах ажиллагааны тухай 1483 (2003) тогтоолын дагуу Иракт байршуулсан олон үндэстний цэргийн бие бүрэлдэхүүнүүд тус улсын археологийн дурсгалт газруудыг хамгаалах, эртний олдворыг сэргээн засварлахад орон нутгийн эрх баригчдыг идэвхтэй дэмжиж байв. Жишээлбэл, Польшийн армийн бүрэлдэхүүнд багтсан археологичид агаараас болон хиймэл дагуулын зургаар үнэлгээ хийж, хэд хэдэн дурсгалт газруудын нөхцөл байдлын талаар Иракийн Соёлын яам, Эртний дурсгал, өвийг хамгаалах улсын зөвлөл (SBAH) болон бусад байгууллагуудад мэдээлж байв. Мөн Иракийн археологийн цагдааг ('Байгууламжийн хамгаалалтын алба') сэргээн босгох, сургах, тоног төхөөрөмжөөр дэмжих, үүнд шинэ станц, ажиглалтын цамхаг байгуулахад тусалж, Эртний дурсгал, өвийг хамгаалах улсын зөвлөлийн бүс нутгийн оффисуудыг засварлах, тоноглоход нягт хамтран ажиллажээ. Италийн Соёлын өвийг хамгаалах Карабиенири алба мөн Эртний дурсгал, өвийг хамгаалах улсын зөвлөлийн бүс нутгийн удирдлагатай нягт хамтран ажиллаж, байршлуудыг хамгаалах үүрэг хүлээсэн албаныханд сургалт хийжээ. Голландын арми Варка (Урук) хотын Бедуин овгийнхны түүх, соёлын зүйлсийг сахин хамгаалагч нарын цалинг сэргээн олгож, байрлах хугацаандаа төлж байсан нь албан ёсны бус боловч чухал ач холбогдолтой орон нутгийн өвийн "удирдлага"-д дэмжлэг үзүүлсэн жишээ юм.

- 197.** "Аюулгүй байдлыг хангах" гэдэг нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг урьдчилан таамаглаж болох үр дагавраас хамгаалах арга хэмжээ бөгөөд, тухайлбал, өрнөж буй болон цэргийн ажиллагаа хийгдэж болзошгүй газраас шилжүүлэх, эсвэл тухайн байгаа газарт нь хамгаалах арга хэмжээ авахыг хэлнэ (§§145–149-р зүйлийг харах). Эзлэгч гүрэн эзлэгдсэн газар нутгийн эрх баригчдад соёлын үнэт зүйлийг аюулын бүсээс холдуулах эсвэл газар дээр нь бэхжүүлэх, тусгаарлах зэрэг ажлыг зохион байгуулахад аль болох туслах ёстой.

- 198.** “Хамгаалах” гэдэг нь эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийн төлөв байдлыг хадгалахын тулд цэргийн дайсагнасан ажиллагаа зогссоны дараа авах арга хэмжээ бөгөөд ихэвчлэн энх тайван байдал тогтнох үед авдаг арга хэмжээ байна. Эзлэгч гүрэн соёлын үнэт зүйлийг хадгалах, хамгаалах ажилд тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, захиргааны дэглэмийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагад аль болох туслах ёстой. Үүнд, тухайлбал, эмзэг газруудад болон ойролцоох барилга байгууламжийг зохицуулах орон нутгийн төлөвлөлтийн хууль, түүхэн барилгуудыг арчлах, өөрчлөх тухай хууль, археологийн малтлага хийх зөвшөөрөл олгох тухай хууль, урлаг, эртний эдлэлийн худалдааг зохицуулах, экспортын хяналтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад туслах зэрэг орно.
- 199.** Эзлэгдсэн газар нутгийн соёлын үнэт зүйлийг хадгалахад эрх бүхий байгууллагуудад үзүүлэх дэмжлэгийн чухал хэсэг нь эзлэгч гүрний хяналтдаа аваад байсан археологийн болон бусад соёлын дурсгалт газруудыг эзлэлт дуусах үед зохицуулалттай, эмх цэгцтэй хүлээлгэн өгөх явдал юм. Гаднын цэргийн албанаас орон нутгийн иргэдийн хамгаалалтад завсар гаргалгүй шилжүүлэн өгөх нь соёлын үнэт зүйлийг завших, сүйтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх цэргийн ажиллагааны улмаас гэмтсэн соёлын үнэт зүйлийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай нь батлагдсан боловч эзлэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага ийм арга хэмжээ авах боломжгүй нөхцөлд эзлэгч гүрэн эрх бүхий байгууллагатай аль болох нягт хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

- 200.** Эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий байгууллагад цэргийн дайсагнасан ажиллагааны улмаас эвдэрч сүйдсэн соёлын үнэт зүйлийг улам бүр гэмтэж доройтохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад логистикийн болон техникийн бэрхшээл тулгарч болзошгүй. Дайны үеэр хохирсон түүхэн барилга нурах эсвэл доторх эд зүйл ил задгай орхигдох, галд өртсөн гар бичмэлүүд үрэгдэх аюулд өртөх эрсдэл үүсэхэд эрх бүхий байгууллагууд соёлын үнэт зүйлийг хадгалахад шаардлагатай арга хэмжээг авах чадавхгүй байх тохиолдол гардаг. Ийм үед эзлэгч гүрэн эрх бүхий байгууллагатай аль болох хамтран ажиллаж, зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Эрх бүхий байгууллагуудтай зөвлөлдөн хэрхэн арга хэмжээ авахыг тодорхойлох, тэднээр дамжуулан ЮНЕСКО болон холбогдох төрийн бус байгууллагуудаас техникийн туслалцаа хүсэж болно. Зөвхөн нэн яаралтай нөхцөл байдал үүссэн

үед эзлэгч гүрний бүтцийн хөндлөнгийн оролцоо авах талаар асуудал хөндөгдөх ёстой.

(ii) Зарим үйлдлийг хориглох, урьдчилан сэргийлэх

201. Эзлэгч гүрэн тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэв журмыг сэргээж, ард иргэдийн хэвийн амьдралыг аль болох хангахын тулд олгогдсон эрх мэдлийн хүрээнд бүх арга хэмжээг авах нийтлэг үүрэг нь соёлын үнэт зүйлийг экспортлох болон хураах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, тухайн нутаг дэвсгэр (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоосон бол харьяа далай тэнгис хамаарна)-т археологийн малтлага хийхтэй холбоотой хууль тогтоомж, тухайн нутаг дэвсгэр (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоосон бол харьяа далай тэнгис хамаарна)-т соёлын үнэт зүйлийг өөрчлөх, зориулалтыг өөрчлөхтэй холбоотой хууль тогтоомж (§§174-р зүйлийг харах)-ийн хэрэгжилтийг аль болох хангахыг шаардана. Энэхүү ерөнхий үүрэгтэй холбоотой шаардлагатай тохиолдолд эдгээр хуулийг батлах эрхтэй (§§175-р зүйлийг харах). Цэргийн дайсагнасан ажиллагааны үеэр соёлын үнэт зүйлийг хамгаалахтай холбоотой тодорхой үүрэг нь дээрхээс илүү зүйлийг шаарддаг. Тухайлбал соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох, шилжүүлэх, өмчлөлийг шилжүүлэх, соёлын үнэт зүйлийг хамгаалалтад авах, хадгалахаас бусад шалтгаанаар тухайн нутаг дэвсгэр (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоосон бол харьяа далай тэнгис хамаарна)-т археологийн малтлага хийх, тухайн нутаг дэвсгэр (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоосон бол харьяа далай тэнгис хамаарна)-т шинжлэх ухааны нотлох баримтыг нуун дарагдуулах, устгах зорилгоор соёлын үнэт зүйлийг өөрчлөх, зориулалтыг өөрчлөхийг хориглох арга хэмжээ авахыг зөвшөөрөөд зогсохгүй түүнийг хийхийг шаарддаг. Энэ үүргийг биелүүлэх нь соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших үйлдлийг хориглох үүрэг (§§187-194-р зүйлийг харах)- тэй нэгэн адилаар эзлэгдсэн газар нутагт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль эрх зүйн дэглэмийг хөндөлгүйгээр үлдээх ерөнхий үүрэгтэй зөрчилдөхгүй бөгөөд түүнээс үл хамаарах зүйл юм. Дахин хэлэхэд үүнээс үүдэн гарсан нэмэлт хориг нь тухайн нутаг дэвсгэрт аль хэдийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль заасан ижил төстэй хоригт нэмэлт хэлбэрээр орж ирж болно. Ялгаатай зүйл нь эзлэгч гүрний баталсан хоригийн дагуу орон нутгийн шүүхээр бус эзлэгч гүрний цэргийн шүүхээр гэмт этгээдүүдийг яллах боломжтой болох юм.

202. Эзлэгч гүрэн эдгээр янз бүрийн үйлдлийг хориглохоос гадна тухайн нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийг хууль бусаар гаргах, бусад хэлбэрээр нүүлгэн шилжүүлэх, өмчлөх эрхийг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй; мөн тухайн нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийг хамгаалах, бүртгэх, хадгалахаас бусад зорилгоор аливаа археологийн малтлага хийхээс урьдчилан сэргийлэх; тухайн нутаг дэвсгэрт соёл, түүх, шинжлэх ухааны нотлох баримтыг нуун дарагдуулах, устгах зорилгоор соёлын үнэт зүйлийн ашиглалтыг хувиргах, зориулалтыг өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээнэ. Тухайн нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, завших, эвдэн сүйтгэхийг хориглох үүргийн нэгэн адил (§§187–194-р зүйлийг харах) цаашид холбогдох үйлдлээс урьдчилан сэргийлэх үүрэг нь эзлэн авч буй хүчин шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой гэсэн үг юм. Энэ зорилгоор өөрсдийн эрх мэдлийн хүрээнд боломжит бүх арга хэмжээ авах ёстой. Өөрөөр хэлбэл, чадах бүхнээ хийх ёстой. Командлагч нарт дахин зөвлөхөд (§160-р зүйлийг харах) доод албан тушаалтнуудад ийм үйлдлээс урьдчилан сэргийлэх нь цэргийн даалгаврыг амжилттай хэрэгжүүлэх чухал элемент гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

(a) Соёлын үнэт зүйлийг хууль бус экспортлох, нүүлгэн шилжүүлэх, өмчлөх эрхийг шилжүүлэх

Эзлэгч гүрэн эзлэгдсэн газар нутгийн хэмжээнд соёлын үнэт зүйлийг хууль бусаар өмчлөх, экспортлох, өөр газар шилжүүлэх, дамжуулахыг хориглож, ийм үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ёстой.

203. Эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хил хязгаарын дотор соёлын хөдлөх үнэт зүйлийн гэмт хэрэг хулгайлах, дээрэмдэх эсвэл зориулалтын бусаар ашиглах үйлдлээс эхэлдэг нь ихэвчлэн тухайн объектын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор өмчлөлийн нэг буюу хэд хэдэн шударга бус шилжүүлгээр дамжин түүнийг хууль бусаар экспортлох, газар нутгаас нь нүүлгэн шилжүүлэх замаар төгсдөг. Иймд соёлын үнэт зүйлийг бүх хэлбэрээр завшихыг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох үүргээс гадна хэн ч байсан аливаа соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох, бусдад шилжүүлэх, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх үүргийг эзлэгч гүрэн хүлээнэ. Мэдээж өөрөө ийм үйлдэл хийх ёсгүй. “Хууль бус” гэдэг нь тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дотоодын хууль

тогтоомж, Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд харшлах буюу албадлагад өртөж буй/ эсвэл албадлагын дагуу бусад үйлдлийг хэлнэ.

- 204.** Эзлэгдсэн нутаг дэвсгэрээс соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох, өөр аргаар нүүлгэн шилжүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хилийн пост, боомт, нисэх онгоцны буудалд хяналт шалгалтын дэглэм тогтоож, зохих гэрчилгээгүй эсвэл хууль бусаар экспортлогдох магадлалтай хэмээн сэжиглэгдэж байгаа аливаа соёлын үнэт зүйлийг хураан авахыг эзэлсэн цэргийн хүчнээс шаарддаг. Ийм өмчийг боломжтой бол хууль ёсны эзэмшигчид нь буцааж өгөх ёстой. Түүнчлэн, соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, нутаг дэвсгэрээс нь өөр аргаар гаргахаас урьдчилан сэргийлнэ гэдэг нь эзлэгч гүрэн өөрөө ийм үйлдэл хийхгүй байх үүргийг хүлээж байгаа гэсэн үг. Иймд цэргийн албан хаагчид урлагийн бүтээл, соёлын үнэт зүйлийг хууль бусаар хил давуулан авч гарахаас командлагч нар урьдчилан сэргүүлэх ёстой. Шаардлагатай бол чөлөө авсан эсвэл албан үүргээ хааж дуусгаад буцах гэж байгаа цэргүүдийн ачаа тээш, биеийг шалгаж үзэх хэрэгтэй.

Аюулгүйн Зөвлөлийн 1483 (2003) тогтоолын дагуу Иракт эзлэгч хүчний хувиар бус тогтворжуулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Олон үндэстний Төв Өмнөд дивизийн командлагч 2003 оны сүүлээр гаргасан 19 тоот тушаалдаа Иракийн соёлын үнэт зүйлийг хууль бусаар тээвэрлэхтэй холбоотой олон улсын хориг арга хэмжээний талаар цэргийн албан хаагчдад тайлбарлаж, онцлон тэмдэглэсэн нэмэлтийг оруулжээ.

- 205.** Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг хууль бусаар завшсантай адил (§§187–194-р зүйлийг харах) эзлэгдсэн нутаг дэвсгэрээс соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох эсвэл нүүлгэн шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор урлагийн бүтээл, эртний үнэт зүйлийг хулгайлсан тохиолдолд ЮНЕСКО, Интерпол ба Олон улсын музейн зөвлөлд мэдэгдэх хэрэгтэй.

(б) Археологийн малтлага

1999 оны II Протоколд нэгдэн орсон улс орнууд уг протоколд нэгдэн орсон өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн үед соёлын үнэт зүйлийг хадгалах, бүртгэх, хамгаалах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт ямар нэгэн археологийн малтлага хийхийг хориглох, урьдчилан сэргийлэх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй улсууд өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн тохиолдолд мөн энэ шаардлагыг биелүүлэх нь зүйтэй.

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт ямар нэгэн археологийн малтлага хийхдээ нөхцөл байдал зөвшөөрөхгүй байхаас бусад тохиолдолд тухайн газар нутгийн эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах ёстой.

- 206.** 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протоколын 9 дүгээр зүйлийн 1/б/-д Протоколд нэгдэн орсон эзлэгч гүрэн эзлэгдсэн нутаг дэвсгэрт (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг тогтоосон харьяаны далай тэнгис хамаарна)-т соёлын үнэт зүйлийг хамгаалах, бүртгэх, хадгалахаас бусад зорилгоор археологийн малтлага хийхийг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэхийг шаарддаг. Мэдээж эзлэгч гүрэн өөрөө ийм үйлдэл хийх ёсгүй. Энэ үүрэг нь зөвхөн археологийн далд хэлбэрийн малтлагад хамаараад зогсохгүй. Далд хэлбэрийн малтлага нь эзлэгдсэн нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр завших, сүйтгэхийг хориглох заалтад хамаарна. II Протоколын 9(1)(b) зүйл нь ил явуулсан археологийн малтлагад хамаарна. Энэ нь үндэсний эрх бүхий байгууллагуудын зөвшөөрөлтэй хийгдэж буй малтлага тэр дундаа аль хэдийн хийгдэж буй малтлагад ч мөн хамаардаг. Хэдийгээр энэ нь хачирхалтай мэт санагдаж болох ч энэ нь урьдчилан сэргийлэх тухай заалт юм. Учир нь энэ заалт нь эзлэгдсэн нутаг дэвсгэрт хууль бусаар археологийн малтлага хийхээс урьдчилан сэргийлэх цорын ганц баталгаа бол эзлэх хугацаанд бүх төрлийн археологийн малтлага хийхийг хориглох явдал гэсэн тооцоолол дээр үндэслэсэн юм.
- 207.** Эзлэгч гүрэн II Протоколд ороогүй тохиолдолд 9(1)(b) зүйлд заасан зүйлийг дагаж мөрдөх нь шилдэг туршлага болно.
- 208.** Тухайн нутаг дэвсгэрт археологийн малтлага хийхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуурай газрын археологийн дурсгалт газруудад

зэвсэгт харуул байрлуулах, сүйрсэн болон усан доорх археологийн дурсгалт газруудын эргэн тойронд зурвас тогтоох зэрэг багтаж болно.

- 209.** Соёлын үнэт зүйлийг хамгаалах, бүртгэх, хадгалах зорилгоор хийж буй археологийн малтлагын хувьд олдсон олдворуудыг бүртгэх мөн ажлыг түр зогсооход зориулж талбайг бэлтгэхэд шаардлагатай гэж үзвэл хийгдэж буй малтлагыг үргэлжлүүлэхийг эзлэгч гүрэнд зөвшөөрнө. Энэ нь мөн эзлэгдсэн гүрэнд цэргийн дайсагнасан ажиллагааны улмаас олдсон эсвэл эзлэгдсэн үед илэрсэн аливаа олдворыг хамгаалах, бүртгэхэд зайлшгүй шаардлагатай шинэ малтлага хийх зөвшөөрөл олгох боломжийг олгодог. Энэхүү сүүлчийн санаа нь 1956 онд ЮНЕСКО-ын Ерөнхий чуулганаас баталсан Археологийн малтлагад хэрэглэх олон улсын зарчмуудын тухай зөвлөмжид тусгагдсан байдаг. Ялангуяа цэргийн ажлын үеэр санамсаргүй олдвор олдсон тохиолдолд эзлэгч гүрэн эдгээр олдворыг хамгаалахын тулд боломжтой бүх арга хэмжээг авах ёстой. Ийм олдворыг байлдааны ажиллагаа дууссаны дараа эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий байгууллагад тэдгээртэй холбоотой бүх бичиг баримтын хамт хүлээлгэн өгөх ёстой гэж зөвлөмжид нэмж оруулсан байна. II Протоколын 9 дүгээр зүйлийн 2-т нөхцөл байдал зөвшөөрөхгүйгээс бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт ямар нэгэн археологийн малтлага хийхдээ эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий үндэсний байгууллагуудтай нягт хамтран ажиллах ёстой гэж нэмж оруулсан болно.

(в) Соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөх

1999 оны II Протоколд нэгдсэн улс орнууд уг протоколд нэгдэн орсон өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлж авах үед соёл, түүх, шинжлэх ухааны холбогдолтой эд зүйлийг нуун дарагдуулах, устгах зорилгоор соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөхийг хориглож, урьдчилан сэргийлэх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй улсууд өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн тохиолдолд мөн дагаж мөрдвөл зохино.

Соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөхөд нөхцөл байдал зөвшөөрөхгүйгээс бусад тохиолдолд эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах ёстой.

- 210.** 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протоколын 9(1)(с) зүйлд тус протоколд нэгдсэн орсон улс эзлэгч гүрэн байх үед тухайн газар нутаг (үүнд тухайн улсын дотоод усны нөөц болон, шаардлагатай хяналтыг

тогтоосон бол харьяа далай тэнгис хамаарна) дахь соёл, түүх, шинжлэх ухааны холбогдолтой эд зүйлийг нуун дарагдуулах, устгах зорилгоор соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөхийг хориглож, урьдчилан сэргийлэх ёстой гэж заасан. Мэдээж эзлэгч гүрэн өөрөө ийм үйлдэл хийх ёсгүй. Соёлын үнэт зүйлийг өөрчлөх гэдэг нь тухайн эд зүйлийн бүтээсэн байдал, бүтэц, талбайн бүтэц дэх өөрчлөлтийг хэлнэ.

- 211.** Эзлэгч гүрэн II Протоколд ороогүй тохиолдолд 9(1)(с) зүйлд заасныг мөн дагаж мөрдөх нь сайн туршлага болно.
- 212.** Соёл, түүх, шинжлэх ухааны нотлох баримтыг устгах, нуун дарагдуулах зорилгоор эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөх нь эзлэгч гүрний хориглох, урьдчилан сэргийлэх үүрэгт хамаарна. II Протоколын 9-р зүйлийн 2-т зааснаар аливаа зөвшөөрөгдөх өөрчлөлт хийх тохиолдолд эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий үндэсний байгууллагуудтай нягт хамтран ажиллах ёстой гэж заасан.

VI. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

A. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЯЛГАН ТАНИХ АЖЛЫГ ХӨНГӨВЧЛӨХ ЗОРИЛГООР ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ

(i) Соёлын үнэт зүйл

Соёлын үнэт зүйлийг ялган таних ажлыг хөнгөвчлөх зорилгоор өмнө нь хэрэглэж байсан соёлын үнэт зүйлийн тэмдэглэгээ хэрэглэж болно.

- 213.** 1954 оны Гаагийн Конвенцод соёлын үнэт зүйлийн “ялгах тэмдэг”-ийг бий болгосон. Конвенцын 16-р зүйлийн 1-д зааснаар ялгах тэмдэг нь цэнхэр, цагаан өнгөөр дөрөв хуваасан доошоо шовх бамбай хэлбэртэй (бамбай нь дараах зүйлээс бүрдэнэ: нэг өнцөг нь бамбайн шовх хэсэг рүү харсан цэнхэр өнгийн квадрат, уг квадратын дээр цэнхэр өнгийн гурвалжин байх бөгөөд уг квадрат, гурвалжин нь хоёр хажуугаараа цагаан өнгийн гурвалжингаар хүрээлэгдсэн байна) байна. Ялгах тэмдгийн зургийг энэхүү гарын авлагын III хавсралтаас харж болно. Ялгах тэмдгийг Дэлхийн өвийн Конвенцын ялгах тэмдэгтэй андуурч болохгүй бөгөөд үүнийг мөн хавсралт III-д дүрсэлсэн болно. Командлагчид доод албан тушаалтнуудаа соёлын үнэт зүйлийн өвөрмөц ялгах тэмдгийг ялган таньдаг байхыг шаардах ёстой.
- 214.** Ялгах тэмдэг нь соёлын үнэт зүйлд хамаарах бүхий л объект, байгууламж, дурсгалт газруудад олон улсын эрх зүйн дагуу олгосон хамгаалалтын ерөнхий түвшинг заана. Зарчмын хувьд нэг ялгах тэмдгийг соёлын үл хөдлөх болон хөдлөх үнэт зүйлийн аль алинд нь байрлуулж болох боловч практик байдал, гоо зүйн хувьд үүнийг хөдлөх эд хөрөнгөд ашиглах нь тохиромжгүй бөгөөд маш ховор тохиолддог. Командлагч нар ялгах ялгах

тэмдгийг соёлын үнэт зүйлд байрлуулсны ач холбогдлыг доод албан тушаалтнуудад ойлгуулах ёстой.

- 215.** 1954 оны Гаагийн Конвенцын 6 дугаар зүйлд заасанчлан, Конвенцод нэгдэн орсон улс орнууд тухайн үнэт зүйлийг соёлын үнэт зүйл гэж хүлээн зөвшөөрөхөд дөхөм болох үүднээс соёлын үнэт зүйлд ялгах тэмдгийг байрлуулах буюу дүрслэн зурахыг зөвшөөрдөг. Гэвч соёлын үнэт зүйлийг ялгах тэмдэглэгээ нь заавал байх албагүй. Конвенцод нэгдэн орсон улс орнуудад соёлын үнэт зүйлийг ялгах тэмдгээр заахыг зөвшөөрдөг боловч шаарддаггүй. Бодит практикт соёлын үнэт зүйлд ялгах тэмдэг ашиглах нь ховор байдаг. Ялгах тэмдгийг ашиглах нь сонголтын хэрэг гэдэг нь цэргийн хүчинд маш чухал үр дагавартай. Энэ нь соёлын үнэт зүйлийг тэмдэглээгүй гэдэг нь Конвенцоор хамгаалагдаагүй гэсэн үг биш юм. Тэр ч байтугай олон улсын заншлын хуулиар хамгаалаагүй гэсэн үг биш юм. Товчоор хэлбэл, тухайн объект, байгууламж, талбайд ялгах тэмдэг байвал цэргийн хүчин тухайн объект, байгууламж эсвэл тухайн газар нь соёлын үнэт зүйл болгон хамгаалагдсан гэж үзэх ёстой бөгөөд ялгах тэмдэг байрлуулаагүй байгаа нь ямар нэгэн утга илэрхийлэхгүй.
- 216.** Конвенцод нэгдэн ороогүй улс нь соёлын үнэт зүйлийг ялгах тэмдгээр тэмдэглэх нь хууль бус зүйл биш. Гэвч энэ нь заавал байх ёстой гэсэн үг мөн л биш. Иймээс цэргийн хүчин тэмдэглэгээ байх эсэхийг дахин үзэж нягтлах ёстой.
- 217.** 1954 оны Гаагийн Конвенцын 17-р зүйлийн 4-д Конвенцод нэгдэн орсон улсын эрх бүхий байгууллагын зохих огноотой, гарын үсэг зурсан зөвшөөрөл байхгүй тохиолдолд соёлын үл хөдлөх үнэт зүйлд ялгах тэмдэг байрлуулж болохгүй гэж заасан. Ийм зөвшөөрөл олгох нь ялгах тэмдгийг ашиглахаас ч ховор тохиолддог.
- 218.** Соёлын үнэт зүйлд ялгах тэмдэг бүхий тэмдэглэгээг ихэнхдээ холбогдох эрх бүхий иргэний байгууллага хийх хандлагатай байдаг. Гэвч цэргийн дайсагнасан ажиллагаа эсвэл зэвсэгт довтолгооны үед цэргийн хүчнүүд өөрсдийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйл дээр, эсвэл түүний эргэн тойрон дахь хашаан дээр тэмдэглэгээ хийж тухайн эд хөрөнгө нь өөрийн талын цэрэг, нутгийн ард иргэд болон бусад хүмүүс эсвэл аль алинд нь хориотой болохыг мэдэгдэж болно. Мөн соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааны улмаас үүсэх аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор илүү өргөн хүрээнд тэмдэглэгээ хийж болно. Соёлын үнэт зүйлийг ялгах тэмдгээр тэмдэглэхийг хүсвэл цэргийн албан хаагчид соёлын үнэт зүйлийг хамгаалах үүрэг бүхий мэргэжлийн алба, ажилтан, соёлын үнэт зүйлийн холбогдох иргэний байгууллагын мэргэжилтнүүд

эсвэл ЮНЕСКО-оос зөвлөгөө, тусламж авах ёстой. ЮНЕСКО-оос цэргийн хүчинд энэ зорилгоор ялгах тэмдгийг хувилан өгч байсан тохиолдлууд бий.

(ii) Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйл

1954 оны Гаагийн Конвенцод нэгдсэн улс орнууд зэвсэгт мөргөлдөөний үеэр тусгай хамгаалалттай соёлын үнэт зүйлийг гурван удаа давтагдсан (гурвалжлуулан байрлуулахдаа нэг бамбайг нь доод эгнээнд байрлуулна) ялгах тэмдэг ашиглан ялган тэмдэглэнэ.

- 219.** 1954 оны Гаагийн Конвенцын 10 дугаар зүйлд Зэвсэгт мөргөлдөөний үед Тусгай хамгаалалтад байх соёлын үл хөдлөх хөрөнгө нь 17 дугаар зүйлийн (1)(а)-д заасны дагуу гурван удаа давтагдсан (гурвалжлуулан байрлуулахдаа нэг бамбайг нь доод эгнээнд байрлуулна) ялгах тэмдэг ашиглан ялган тэмдэглэх ёстой гэж заасан байдаг. Гурван удаа давтагдсан ялгах тэмдгийн зургийг энэхүү гарын авлагын III хавсралтаас харж болно. Энэхүү ялгах тэмдгийг эрх бүхий байгууллагын зохих огноотой, гарын үсэг зурсан зөвшөөрөлтэй хамт байршуулсан байх ёстой. Соёлын үл хөдлөх үнэт зүйл дээр гурван удаа давтагдсан тэмдэгтийг харуулахын ач холбогдлыг захирагч нар цэргийн бие бүрэлдэхүүнд ойлгуулах ёстой. Зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн хүчин эсвэл иргэний эрх бүхий байгууллага Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг тэмдэглэх эсэх тухайн улсын шийдэх асуудал юм.

(iii) Соёлын үнэт зүйлийг тээвэрлэх

1954 оны Гаагийн Конвенцод нэгдсэн улсууд Зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг шилжүүлэх үйл ажиллагаа эрхлэн зохион байгуулахад оролцох тээврийн хэрэгслийг гурван удаа давтагдсан (гурвалжлуулан байрлуулахдаа нэг бамбайг нь доод эгнээнд байрлуулна) ялгах тэмдэг ашиглан ялган тэмдэглэх ёстой.

- 220.** 1954 оны Гаагийн Конвенцын 12-р зүйлийн 2-т Конвенцод нэгдэн орсон улсууд соёлын үнэт зүйлийг шилжүүлэх үйл ажиллагааг дагнан гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд гурван удаа давтагдсан (гурвалжлуулан байрлуулахдаа нэг бамбайг нь доод эгнээнд байрлуулна) ялгах тэмдэг ашиглан ялган тэмдэглэнэ гэж заасан. Гурван удаа давтагдсан ялгах тэмдгийн зургийг энэхүү гарын авлагын III хавсралтаас харж болно.

Командлагч нар өөрсдийн харьяа албан тушаалтнуудад соёлын үнэт зүйлийн өвөрмөц тэмдгийг тээврийн хэрэгсэлд гурван удаа давтан ашиглахын ач холбогдлыг ойлгуулах ёстой. Зэвсэгт мөргөлдөөний үед зөвхөн соёлын үнэт зүйлийг шилжүүлэх тээврийн хэрэгслийн тэмдэглэгээг цэргийн хүчин эсвэл эрх бүхий иргэний байгууллага хийх нь тухайн оролцогч улсаас хамаарна.

(iv) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл

1999 оны II Протоколд Конвенцод нэгдэн орсон улсууд зэвсэгт мөргөлдөөний үед өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг тусгайлан тэмдэглэхийг заасан.

- 221.** 1999 оны II Протоколд өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлийг ялгах тэмдэглэгээ хийх тусгай заалт байхгүй. Харин 2015 онд II Протоколд нэгдэн орсон улсууд өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлийн ялгах тусгай тэмдгийг зохиосон. Өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлийн тусгай ялгах тэмдгийн зургийг энэхүү гарын авлагын III хавсралтаас үзнэ үү. Командлагч нар өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлд ашиглах тусгай тэмдэгтийн ач холбогдлыг доод албан тушаалтнуудад ойлгуулах ёстой. Зэвсэгт мөргөлдөөний үед өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлд тусгай ялгах тэмдэг байршуулах ажлыг цэргийн хүчин хийх үү эсвэл иргэний эрх бүхий байгууллага хийх үү гэдэг нь тухайн оролцогч улсаас хамаарна.
- 222.** Зэвсэгт мөргөлдөөний үед өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлийг ялгах тэмдгээр тэмдэглэх нь заавал хэрэгжүүлэх ёстой үүрэг биш. Конвенцод нэгдэн орсон улсууд өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлд ялгах тэмдэг ашиглаж болох боловч заавал хийх шаарддаггүй. Тиймээс бодит байдал дээр өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйл нь ялгах тэмдэггүй байгаа нь II Протоколын дагуу өндөржүүлсэн хамгаалалтад хамрагдахгүй гэсэн үг биш юм.

Б. ЯЛГАХ ТЭМДЭГ БОЛОН БУСАД ТЭМДЭГЛЭГЭЭГ БУРУУ АШИГЛАХ

Зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийн ялгах тэмдгийг буруугаар ашиглахыг хориглоно.

Зэвсэгт мөргөлдөөний үед ямар ч зорилгоор ямар ч тохиолдолд соёлын үнэт зүйлийн өвөрмөц ялгах тэмдэгтэй төстэй тэмдэг ашиглахыг хориглоно.

- 223.** Зэвсэгт мөргөлдөөн болон цэргийн эзлэх үйл ажиллагааны үед цэргийн хүчин соёлын үнэт зүйлийн ялгах тэмдгийг буруугаар ашиглахыг хориглоно. Зарим тохиолдолд энэ нь дайны гэмт хэрэг ч байж болно. Ялгах тэмдгийг буруугаар ашиглах түгээмэл тохиолдол нь дайсны довтолгооноос хамгаалах зорилгоор соёлын үнэт зүйл биш объект, байгууламж, талбайд тэмдэглэгээ хийх явдал юм. Мөн соёлын үнэт зүйлийн ялгах тэмдэгтэй төстэй тэмдэг хэрэглэхийг хориглоно.
- 224.** Командлагч нар эдгээр дүрмийн үнэ цэнийг доод албан тушаалтнуудад ойлгуулах ёстой. Ялгах тэмдгийг буруу ашиглах, ижил төстэй ялгах тэмдгийг ашиглах нь зэвсэгт мөргөлдөөнд соёлын үнэт зүйлийг хамгаалахад сөргөөр нөлөөлдөг. Ингэж ашиглах нь ялгах тэмдгийг жинхэнэ соёлын үнэт зүйлд ашигласан ч нэр хүндийг нь бууруулах эрсдэлтэй байдаг бол ижил төстэй ялгах тэмдэг ашиглах нь цэргийн хүчнийг төөрөгдүүлэхэд хүргэдэг.

VII. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ АЖИЛТАН

A. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ ХАМГААЛАХ АЖИЛТНЫГ ХҮНДЛЭХ

Соёлын үнэт зүйлийг хамгаалах ажилтныг аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн хүндэтгэх ёстой. Соёлын үнэт зүйлийг хамгаалах ажилтан болон тэдний хариуцаж буй соёлын үнэт зүйл нь мөргөлдөөнд оролцогч эсрэг талын гарт орсон тохиолдолд үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх эрхээр хангагдах ёстой.

- 225.** Эсрэг талын аюулгүй байдалтай нийцэж байгаа бол мөргөлдөөнд оролцогч талын нэрийн өмнөөс соёлын үнэт зүйлийг хамгаалахад оролцсон бүх ажилтнуудад хүндэтгэлтэй хандах ёстой. Холбогдох боловсон хүчинд соёлын үнэт зүйлийг хамгаалахад оролцож буй мөргөлдөөнд оролцогч талын иргэдийн эрх баригчид болон тухайн талын зэвсэгт хүчний тусгайлсан чиг үүрэг бүхий мэргэжлийн боловсон хүчин багтана. Ийм боловсон хүчнийг хүндэтгэх үүрэг гурван зүйлийг агуулна. Нэгдүгээрт, дайсагнах аливаа үйлдэлд шууд оролцох эсвэл цэргийн тусгай албан хаагчдын хувьд эсрэг талд хор уршигтай үйлдэл хийхээс бусад тохиолдолд ийм бие бүрэлдэхүүнийг онилж дайралтад өртүүлж болохгүй. Хоёрдугаарт, хэрэв тэд эсрэг талынхны гарт орвол аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд тэднийг саатуулж болохгүй бөгөөд ямар ч тохиолдолд зүй бусаар харьцаж болохгүй. Эцэст нь, хүндэтгэх нийтлэг үүргийн талаар тодорхой тайлбарласнаар тэд болон тэдний хариуцаж буй соёлын үнэт зүйл нь эсрэг талын гарт орсон тохиолдолд үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэхийг зөвшөөрөх ёстой.

Б. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ АЖИЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Соёлын үнэт зүйлийг хамгаалах ажилтан тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон, тамга тэмдэгтэй, соёлын үнэт зүйлийн ялгах тэмдэг бүхий ханцуйвч зүүж болно.

Тэд ялгах тэмдэг бүхий иргэний тусгай үнэмлэхийг биедээ авч явах ёстой. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тэдний иргэний үнэмлэх, ханцуйвч зүүх эрхийг хасаж болохгүй.

- 226.** 1954 оны Гаагийн Конвенцыг хэрэгжүүлэх журмын 21 дүгээр зүйлд заасны дагуу соёлын үнэт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг ажилтнууд соёлын үнэт зүйлийн ялгах тэмдэг бүхий ханцуйвч тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгож, тамга тэмдгээр баталгаажуулсан, эрх бүхий байгууллагын сүлд, товойлгон дүрсэлсэн хантааз өмсөж болно. Тэд мөн биедээ тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгож, тамга тэмдгээр баталгаажуулсан тусгай үнэмлэх авч явах ёстой. Хууль ёсны шалтгаангүйгээр тэдний үнэмлэх эсвэл ханцуйвч зүүх эрхийг хасаж болохгүй. Үнэмлэхийн харагдах байдал нь улс бүрт хамаарах асуудал боловч түүнд агуулагдах мэдээллийг журмын 21-р зүйлд заасан байдаг.

VIII. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХАД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ

A. ТУСЛАМЖ, ЦЭРГИЙН ХҮЧ

- 227.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллага болон улс орнууд тайван цагт болон цэргийн дайсагнасан ажиллагаа эхэлсний дараа цэргийн хүчинд тусламж үзүүлэх боломжтой.
- 228.** Зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн хүчин соёлын үнэт зүйлийг хамгаалахтай холбоотой техникийн бэрхшээл тулгарсан үед эсвэл үүнтэй холбоотой сургалт авах хэрэгцээ шаардлага байгаа бол засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллага, улс орнуудаас тусламж авч болно. Цэргийн хүчний удирдлага, эсвэл холбогдох иргэний байгууллагын удирдах албан тушаалтнуудаар дамжуулж хүсэлт гаргах нь тухайн улсын шийдэх хэрэг юм.

B. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ

(i) ЮНЕСКО

- 229.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад туслалцаа үзүүлэх тухайд Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, практикт НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО) онцгой байр суурь эзэлдэг.
- 230.** 1954 оны Гаагийн Конвенцын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 1999 оны II Протоколын 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эдгээр холбогдох баримт бичигт нэгдэн орсон улсууд ЮНЕСКО-гоос, тэр дундаа тайван цагт өөрийн соёлын хамгаалалтыг зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд хэрхэн зохион байгуулахад чиглэлд техникийн туслалцаа үзүүлэхийг хүсэж болно гэж заасан байдаг. Мөн тус Конвенц, түүний журам, II Протоколыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа бусад асуудалтай холбогдуулан ЮНЕСКО-гоос туслалцаа хүсэх боломжтой. Конвенцын 23 дугаар зүйлийн

2 дахь хэсэг, II Протоколын 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь ЮНЕСКО-д өөрийн санаачилгаар ийм асуудлаар Конвенцод нэгдэн орсон улсуудад санал гаргах эрх олгодог. Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний тухайд Конвенцын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, II Протоколын 22 дугаар зүйлийн 7-д зааснаар ЮНЕСКО нь дээрх баримт бичгүүдийн үйлчлэх олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгох эрхтэй. Гэвч зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах талаарх ЮНЕСКО-ын эрх мэдэл нь Конвенц болон II Протоколд хамаарах нөхцөл байдлаар хязгаарлагдахгүй. Засгийн газар хоорондын байгууллага болох ЮНЕСКО-ын гишүүн орнууд түүний Дүрмийн I зүйлийн 2 дахь хэсгийн в-д заасны дагуу “Дэлхийн дахины ном, урлагийн бүтээл, хөшөө дурсгал, шинжлэх ухааны өвийг хадгалах, хамгаалахыг баталгаажуулах” чиг үүргийг ЮНЕСКО-д олгодог. ЮНЕСКО ба түүний Гишүүн орнуудын туршлагаас харахад энэхүү бүрэн эрх нь ЮНЕСКО-д Гаагийн конвенцын албан ёсны хүрээнээс гадуур олон улсын болон олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, дэмжих боломжийг олгодог. Үнэхээр ч 2015 оны сүүлээр тус байгууллагын Ерөнхий бага хурлаар зэвсэгт мөргөлдөөн гарсан үед соёлыг хамгаалах, соёлын олон ургалч байдлыг хөхиүлэн дэмжих ЮНЕСКО-ын үйл ажиллагааг бэхжүүлэх стратегийг баталсан (ЮНЕСКО doc. 38C/49).

- 231.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад ЮНЕСКО-гоос үзүүлж болох техникийн тусламжийн жишээг II Протоколын 33 дугаар зүйлийн 1-д дурдсан бөгөөд үүнд тайван цагт соёлын үнэт зүйлийг хамгаалах бэлтгэл ажил, онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх болон зохион байгуулалтын авах арга хэмжээ, соёлын үнэт зүйлийн улсын тооллогын эмхэтгэл хийх зэрэг жишээ багтсан. Өөр бусад жишээг Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протоколыг хэрэгжүүлэх удирдамжийн III хавсралтын 3-р хүснэгт (ЮНЕСКО doc. CLT-09/CONF/219/3 REV. 4, 2012.3.22) болон 2015 онд ЮНЕСКО-ын Ерөнхий бага хурлаар баталсан зэвсэгт мөргөлдөөн гарсан үед соёлыг хамгаалах, соёлын олон ургалч байдлыг хөхиүлэн дэмжих ЮНЕСКО-ын үйл ажиллагааг бэхжүүлэх стратегиас (§230-р зүйлийг харах) харж болно. Зэвсэгт мөргөлдөөн дэгдсэний дараа соёлын үнэт зүйлийг хамгаалахад онцгой ач холбогдолтой зүйл бол ЮНЕСКО-ийн Соёлын салбарт байгуулагдсан Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах алба (CLT/EPR) юм. Гэсэн хэдий ч тайван цагт ЮНЕСКО-ийн үйлчилгээ цэргийн хүчний боловсрол, бэлтгэл ч чухал болохыг онцлох нь зүйтэй.

(ii) Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хороо

232. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хороо буюу 1999 оны II Протоколын дагуу байгуулагдсан Засгийн газар хоорондын хороо нь уг протоколтой холбоотой олон чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тэдгээрийн ихэнх нь цэргийн хүчинд шууд хамаарахгүй. Хороо нь мөн Протоколын дагуу байгуулагдсан зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах Сангаас дэмжлэг авдаг.

233. Тус хороо нь өргөтгөсөн хамгаалалтад оруулах зэрэг төрөл бүрийн ажлуудын дотроос цэргийн дайсагнасан ажиллагааны үеэр соёлын үнэт зүйлийг хамгаалах, эсвэл цэргийн дайсагнасан ажиллагаа дууссаны дараа түүнийг нэн даруй сэргээх зорилгоор яаралтай тусламж үзүүлэх болон бусад арга хэмжээг дэмжихэд олон улсын тусламж үзүүлэх хүсэлтийг хүлээн авч хэлэлцдэг. Төлөвлөсөн техникийн болон зөвлөлдөх арга хэмжээний жишээг Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенцын 1999 оны II Протоколыг хэрэгжүүлэх удирдамжийн III Хавсралтын (ЮНЕСКО doc. CLT-09/CONF/219/3 REV. 4, 2012 оны 3-р сарын 22) 2-р хүснэгтээс харж болно. Түүнчлэн тус сангаас тухайн бүс нутаг дахь олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотойгоор Малид олгосон санхүүгийн тусламжийн ашиглалтын тухай хороонд ирүүлсэн тайлангаас харж болно (UNESCO doc. CLT-3/8.COM/CONF.203/5, 2013 оны 9-р сарын 24-р зүйлийг харарх). II Протоколд нэгдэн орсон аль ч улс, мөн хэдийгээр тус протоколд ороогүй боловч 3-р зүйлийн 2-т заасны дагуу мөргөлдөөний үед түүний заалтуудыг хүлээн зөвшөөрч, даган мөрдөж буй зэвсэгт мөргөлдөөнд оролцогч аль ч улс хорооноос олон улсын тусламж хүсэж болно. Ийм хүсэлтийг цэргийн хүчнийхэн биш харин холбогдох иргэний байгууллагын удирдах албан тушаалтнууд гаргах ёстой.

(iii) Олон улсын Улаан загалмайн хороо (ОУУЗХ)

234. Олон улсын Улаан загалмайн хороо (ОУУЗХ) нь Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг.

235. ОУУЗХ нь соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай гэрээнд үндэслэсэн болон заншлын эрх зүйн заалтуудын хэрэгжилтийг дэмжих, тухайлбал цэргийн боловсрол олгох ба сургалт явуулах зэрэг ажлыг хийхээс гадна Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах зөвлөлд зөвлөхийн статустай ажилладаг. Үүнээс гадна зэвсэгт мөргөлдөөний үед газар дээр нь холбогдох үүргийн дагуу ажилладаг. Мөргөлдөөнд оролцогч талууд зөвшөөрсөн тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд

нэрвэгдэгсэд, тэр дундаа соёлын дурсгалт зүйл, байгууламж, дурсгалт газар нь аюулд өртсөн, гэмтсэн, сүйдсэн, хууль бусаар эзлэгдсэн хүмүүст зориулсан хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулна. Жишээлбэл, 1956 онд Израйль Синайг эзлэн авах үед ОУУЗХ нь эртний Гэгээн Кэтрин сүм болон тэндхийн оршин суугчдын нөхцөл байдлыг шалгахар төлөөлөгчөө илгээж байжээ.

- 236.** 2016 онд ЮНЕСКО болон ОУУЗХ хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 1(vi)-д соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааны улмаас үүсэх аюулаас хамгаалахад туслалцаа үзүүлэхэд ОУУЗХ тодорхой үүрэг гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрсөн. 1(vi) зүйлд ОУУЗХ нь “цуглуулгыг нүүлгэн шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх ба/эсвэл яаралтай хамгаалах арга хэмжээ авахад шаардлагатай хангамж, тоног төхөөрөмжөөр нийлүүлэх замаар эрсдэлд өртсөн соёлын үнэт зүйлийг аврахад тусалж чадна” гэж заасан. ЮНЕСКО эсвэл мөргөлдөөнд оролцогч талуудын хүсэлтээр тусламж үзүүлэх бөгөөд ОУУЗХ-д хүсэлт ирүүлэхдээ мөргөлдөөнд оролцогч бүх талууд харилцан тохиролцож санал нийлсэн байх ёстой. Мөн холбогдох орон нутгийн оролцогчид, тэр дундаа эрх бүхий үндэсний байгууллагуудтай нарийн тохиролцсоны үндсэн дээр тусламжийг олгох ёстой.

(iv) Төрийн бус байгууллага

- 237.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад олон төрийн бус байгууллага (ТББ) ямар нэг байдлаар оролцдог. Эдгээрт Цэнхэр бамбайн олон улсын хороо (ICBS) болон түүний бүрэлдэхүүний байгууллагууд, тухайлбал, Аудио-визуал архивын холбоодын зохицуулах зөвлөл (ССААА), Архивын олон улсын зөвлөл (ICA), Олон улсын музейн зөвлөл ICOM, Хөшөө дурсгал, дурсгалт газруудын олон улсын зөвлөл ICOMOS болон Олон улсын номын сангийн холбоо (IFLA) зэрэг орно. Эдгээр байгууллага бүгд Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хороонд зөвлөх статустай байдаг. Цэнхэр бамбайн үндэсний хороод ч бас хамааралтай. Энх тайвны төлөөх өв зэрэг институци багатай бусад нийгэмлэгүүдэд мөн багтдаг.
- 238.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахтай холбогдуулан эдгээр төрийн бус байгууллагууд цэргийн хүчинд үзүүлж чадах тусламж харилцан адилгүй. Мэргэжилтэн илгээх, сургалт явуулахаас эхлээд мөргөлдөөнтэй бүс дэх соёлын үнэт зүйлийн хиймэл дагуулын зураг авах, “цохилт өгөхгүй байх” объектын жагсаалт гаргах гэх мэт.

В. УЛС ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУСЛАМЖ

- 239.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор өөр улсад техникийн болон бусад тусламж үзүүлэхэд ямар ч зөвшөөрөл шаардлагагүй. Мөн аливаа улс ийм тусламж хүсэхэд зөвшөөрөл авах шаардлагагүй. 1999 оны II Протокол нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах хороогоор дамжуулан (§§232–234-р зүйлийг харах) Конвенцод нэгдэн орсон болон тусламж хүссэн улсуудад бүх төрлийн техникийн болон бусад туслалцаа үзүүлэх, Конвенцын оролцогч талуудад хоёр талын эсвэл олон талт тусламж үзүүлэхийг уриалдаг.
- 240.** Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалахад улс орнууд ямар техникийн туслалцаа үзүүлж чадах нь тухайн улсаас хамаарна.
- 241.** 2015 онд ЮНЕСКО-ын хямралтай бүс нутгийн соёлын үнэт зүйлийг хамгаалах 'Unite4Heritage' компани ажлын үед Арма деи Карабиниеригийн Италийн Соёлын өвийг хамгаалах Карабиенири алба 'Unite4 Heritage' ажлын хэсгийг байгуулсан бөгөөд түүний харьяаны Tutela Patrimonio Culturale (TPC) төв штаб соёлын үнэт зүйлийг дээрэмдэх, сүйтгэхээс хамгаалах, хулгайлагдсан эд зүйлсийг олж авах зорилгоор мөргөлдөөний бүсүүдэд (§§69, 190-р зүйлийг харах) ажиллаж байсан туршлагатай. Тус ажлын хэсэг нь археологи, архитектур, урлаг, түүхийн хамгаалалт, сэргээн засварлалт, музей судлал, номын сан, архив судлал, геологи, газар хөдлөлт судлалын чиглэлийн мэргэжилтнүүдээс бүрддэг. 2016 оны эхээр Итали Улс болон ЮНЕСКО “Соёлын цэнхэр дуулгатан” гэдэг нэрээр танил болсон “Unite4Heritage” ажлын хэсгийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон харилцан ойлголцлын санамж бичиг байгуулжээ. Тэдний үүрэг нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хямрал эсвэл байгалийн гамшигт нэрвэгдсэн бүс нутагт соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор очиж ажиллах бөгөөд соёлын эд зүйлийг хууль бусаар дамжуулан худалдаалахаас сэргийлэх, ирээдүйн эрсдэлээс хамгаалах орон нутгийн чадавхыг бэхжүүлэх зорилготой юм.

ХАВСРАЛТ I – ХУРААНГУЙ

“СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ”-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1954 оны Гаагийн Конвенцод тодорхойлсноор “соёлын үнэт зүйл” гэдэг нь гарал үүсэл, өмчлөлийн хэлбэрээс үл хамааран тухайн улсын соёлын өвд чухал ач холбогдол бүхий, иргэний болон шашны, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хэлнэ. Жишээлбэл, түүх, урлаг, архитектурын ач холбогдолт бүхий барилга байгууламж, бусад дурсгалт газрууд, археологийн дурсгалт газрууд, урлагийн бүтээл, эртний эдлэл, гар бичмэл, ном, цуглуулга болон архивын байр зэрэг болно. Энэ нэр томъёонд соёлын хөдлөх үнэт зүйлсийг хамгаалах, дэлгэн үзүүлэх зориулалттай барилга байгууламж, хадгалах байгууламж мөн хамаарна.

“Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйл” гэдэг нэр томъёо нь 1954 оны Гаагийн Конвенцод заасны дагуу “Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын бүртгэлд” орсон соёлын үнэт эд зүйлийг хэлнэ.

“Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйл” гэдэг нэр томъёо нь 1999 оны II Протоколын дагуу “Өргөтгөсөн хамгаалалтад байх олон улсын соёлын үнэт зүйлийн жагсаалт”-д оруулсан соёлын үнэт зүйлийг хэлнэ.

БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ

А. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЗААВАРЧИЛГАА

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улс орнууд Конвенцыг дагаж мөрдөхөд чиглэсэн заалтуудыг тайван цагт Зэвсэгт хүчний хууль, дүрэм, зааварчилгаандаа оруулж, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүндээ бүх ард түмний соёл, соёлын үнэт зүйлийг хүндэтгэх сэтгэлгээг төлөвшүүлэх ёстой. Конвенцод нэгдэн ороогүй улсууд ч мөн энэ заалтыг дагаж мөрдөх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн орсон улс орнууд Конвенцыг дагаж мөрдөхөд чиглэсэн зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг зохих ёсоор хамгаалах заавар, зааварчилгааг Зэвсэгт хүчний хууль, дүрэмдээ тусгах ёстой.

Протоколд нэгдэн ороогүй улсууд ч мөн энэ заалтыг дагаж мөрдөх ёстой.

Б. ЦЭРГИЙН СУРГАЛТ

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улс орнууд цэргийн сургалтын хөтөлбөртөө конвенцыг судлах талаар тусгах ёстой. Конвенцод ороогүй улсууд ч мөн дагаж мөрдөх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн орсон улсууд зохих тохиолдолд ЮНЕСКО болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах чиглэлээр тайван цагийн цэргийн сургалт, хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Протоколд ороогүй улсууд ч мөн дагаж мөрдөх ёстой.

В. МЭРГЭЖИЛТЭН ЦЭРГИЙН АЛБАН БУЮУ АЖИЛТНУУД

1954 оны Гаагийн Конвенцод нэгдэн орсон улсууд зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг хүндэтгэх, тэдгээрийг хамгаалах үүрэгтэй иргэний байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажиллахад чиглэсэн ажлыг төлөвлөх болон зэвсэгт хүчиндээ тайван цагийн алба байгуулах эсвэл мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ёстой. Конвенцод нэгдэн ороогүй улс орнууд ч мөн адил хүчин чармайлт гаргах ёстой.

ЦЭРГИЙН ДАЙСАГНАСАН АЖИЛЛАГААНЫ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ

Б. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ОНИЛГОО

(i) *Соёлын үнэт зүйлийг халдлагын объект болгох*

(a) *Ерөнхий дүрмүүд*

Цэргийн ажиллагааны зорилгоор ашиглаагүй бөгөөд ижил төстэй цэргийн ажиллагааны давуу тал олж авах өөр арга зам байхгүй байхаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйлд довтлохыг хориглоно.

Мөргөлдөөнд оролцогч талууд довтолгоонд өртөх объектууд нь соёлын үнэт зүйл биш гэдгийг баталгаажуулахын тулд боломжит бүх арга хэмжээг авах ёстой.

Довтолгооны объект нь соёлын үнэт зүйл болох нь тогтоогдвол мөргөлдөөнд оролцогч талууд довтолгоог цуцлах эсвэл түр зогсоох ёстой.

Соёлын үнэт зүйл цэргийн ажиллагааны объект байх үед, түүнд довтолхоос өөр хувилбар байхгүй тохиолдолд 1999 оны II Протоколын дагуу мөргөлдөөнд оролцогч талын соёлын үнэт зүйлд довтолх шийдвэрийг нөхцөл байдалд нийцэхгүй байгаагаас бусад тохиолдолд нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг командалж буй офицер гаргах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй тал соёлын үнэт зүйлд довтолх шийдвэр гаргах тохиолдолд энэ заалт мөн хамаарна.

Соёлын үнэт зүйл цэргийн ажиллагааны объект байх үед, түүнд довтолхоос өөр хувилбар байхгүй тохиолдолд 1999 оны II Протоколын дагуу мөргөлдөөнд оролцогч талын соёлын үнэт зүйлд довтолхоор шийдсэн бол боломж олдмогц урьдчилан анхааруулах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй тал соёлын үнэт зүйлд довтолх шийдвэр гаргах тохиолдолд энэ заалт мөн хамаарна.

(б) Өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлийн хувьд баримтлах тусгай заалт

1999 оны II Протоколыг заавал биелүүлэх үүрэг хүлээсэн мөргөлдөөнд оролцогч талууд дараахаас бусад тохиолдолд өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг довтолгооны объект болгохыг хориглоно. Үүнд:

- ашиглалтаараа цэргийн объект болгох;
- довтолгоо нь тийнхүү ашиглахыг зогсоох цорын ганц боломжит арга зам болох;
- соёлын үнэт зүйлд хохирол учрахаас зайлсхийх, учрах хохирлыг багасгах довтолгооны арга хэрэгслийг сонгохдоо бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;
- өөрийгөө даруй хамгаалах шаардлага зөвшөөрөхгүй байхаас бусад тохиолдолд довтолох тушаалыг командлалын дээд түвшинд гаргах, ашиглахаа зогсоохыг эсрэг талд урьдчилан анхааруулах, эсрэг талд нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах хугацаа өгөх зэрэг болно.

(в) Соёлын үнэт зүйлийг тээвэрлэх тусгай заалт

Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлийг тээвэрлэхэд тусгайлан ашиглах тээврийн хэрэгслийг довтолгооны объект болгохыг хориглоно.

(ii) Цэргийн цохилт өгөх үеэр соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учруулах

Соёлын үнэт зүйлд цэргийн урьдчилан тооцоолсон бодит болон шууд давуу байдлаас илүү хэмжээний санамсаргүй хохирол учруулж болзошгүй довтолгоо хийхийг хориглоно.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлд санамсаргүй хохирол учрахаас сэргийлэх эсвэл учрах хохирлыг багасгахын тулд довтолох арга, хэрэгслээ сонгохдоо боломжит бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын үнэт зүйлд санамсаргүй учруулж болзошгүй хохирол нь урьдчилан тооцоолсон цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад хэт их байх үед довтолгоог цуцлах буюу түр зогсоох ёстой.

В. ӨӨРИЙН ТАЛЫН ХЯНАЛТАД БАЙГАА СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ УСТГАХ, ХОХИРОЛ УЧРУУЛАХ

(i) Ерөнхий заалт

Цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд өөрийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг хориглоно.

1999 оны II Протоколд нэгдэн орсон мөргөлдөөнд оролцогч тал өөрийн мэдэлд байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах цэргийн зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ тухай шийдвэрийг нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг удирдаж байгаа цэргийн албан тушаалтан гаргах ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй мөргөлдөөнд оролцогч тал өөрийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулах цэргийн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөн адил хамаарна.

(ii) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн тусгай заалт

1999 оны II Протоколд нэгдэн орсон улсын мөргөлдөөнд оролцогч талуудын цэргийн хүчин өөрийн хяналтад байгаа өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулахыг хатуу хориглоно.

Г. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ БУЮУ ТҮҮНИЙ ОРЧНЫ ОРЧНЫГ АШИГЛАХ

(i) Ерөнхий заалт

Зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаас бусад тохиолдолд соёлын үнэт зүйл болон түүний эргэн тойронд байх эд зүйлийг устгах буюу хохиролд өртөж болзошгүй аливаа зориулалтаар ашиглахыг хориглоно.

1999 оны II Протоколд зааснаар зэвсэгт мөргөлдөөний үед мөргөлдөөнд оролцогч тал соёлын үнэт зүйлийг устгах, хохирол учруулж болзошгүй зориулалтаар ашиглах цэргийн зайлшгүй шаардлагатай гэж үзвэл тухайн шийдвэрийг нэг батальонтой дүйцэхүйц хэмжээний цэргийн хүчийг удирдаж байгаа цэргийн албан тушаалтан гаргах ёстой.

1999 оны II Протоколд үл хамаарах мөргөлдөөнд оролцогч тал зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг түүнийг устгах, хохирол учруулах зорилгоор ашиглах шаардлагатай тохиолдолд дээрх нөхцөл мөн адил хамаарна.

(ii) Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн тусгай заалт

1999 оны II Протоколд заасан мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн ажиллагааг дэмжих зорилгоор өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйл болон түүний ойр орчмын аливаа зүйлийг ашиглахыг хориглоно.

Д. ЦЭРГИЙН АЖИЛЛАГААНААС ҮҮДЭН СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛД АЮУЛ УЧРАХ

Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн хяналтад байгаа соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааны улмаас үүсэх аюулаас хамгаалахын тулд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой.

Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын дурсгалт зүйлсийг цэргийн объект, түүний ойр орчмоос холдуулах эсвэл тухайн байршил дээр нь зохих ёсоор хамгаалах боломжит арга хэмжээ авах ёстой.

Мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн объектуудыг соёлын дурсгалт газрын ойролцоо байрлуулахаас аль болох зайлсхийх ёстой.

Е. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХУУЛЬ БУСААР ЭЗЭМШИХ, САНААТАЙГААР ХОХИРОЛ УЧРУУЛАХ

(i) Цэргийн хүчээр

Соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр шамшигдуулах, эвдэн сүйтгэх үйл ажиллагаа явуулахыг бүрэн хориглоно.

(ii) Бусад талууд

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд бусад хүмүүс, тэр дундаа зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд соёлын үнэт зүйлийг хулгайлах, дээрэмдэх болон бусад хэлбэрээр үрэгдүүлэх, сүйтгэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол таслан зогсоох үүрэгтэй.

Ё. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАРИУ БАРИХ БАЙДЛААР АШИГЛАХ

Соёлын үнэт зүйлийг өш авах байдлаар хэлмэгдүүлэлтийн объект болгохыг хориглоно.

ЗЭВСЭГЛЭН ДОВТЛОХ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ

А. ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЭХЛЭХ, ДУУСГАХ

Дайсагнагч армийн мэдэлд орсон тохиолдолд тухайн газар нутгийг эзлэгдсэн гэж үзнэ. Эзлэн түрэмгийлэл нь зөвхөн эрх мэдлээ тогтоож, засаглах боломжтой болсон газар нутгаар хязгаарлагдана.

Б. ЭЗЛЭГЧ ГҮРНИЙ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

Эзлэгч гүрэн эрх мэдлийнхээ хүрээнд нийтийн хэв журам, иргэдийн амьдралыг аль болох хурдан хугацаанд хэвийн байдалд оруулах бүх арга хэмжээг авахын зэрэгцээ бүрмөсөн хязгаарлснаас бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дээдэлнэ.

В. ЦЭРГИЙН ХҮЧЭЭР ЭЗЛЭН ТҮРЭМГИЙЛЭЧДИЙН ХҮЛЭЭХ ОНЦГОЙ ҮҮРЭГ

(i) Эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэх

Эзлэгч гүрэн соёлын үнэт зүйлийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахад орон нутгийн эрх бүхий байгууллагыг аль болох дэмжих ёстой.

Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх цэргийн ажиллагааны улмаас гэмтсэн соёлын үнэт зүйлийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай нь батлагдсан боловч эзлэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага ийм арга хэмжээ авах боломжгүй нөхцөлд эзлэгч гүрэн эрх бүхий байгууллагатай аль болох нягт хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

(ii) *Зарим үйлдлийг хориглох, урьдчилан сэргийлэх*

(a) *Соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох, нүүлгэн шилжүүлэх, өмчлөх эрхийг шилжүүлэх*

Эзлэгч гүрэн эзлэгдсэн газар нутгийн хэмжээнд соёлын үнэт зүйлийг хууль бусаар экспортлох, өөр газар шилжүүлэх, өмчлөх эрхийг дамжуулахыг хориглож, ийм үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ёстой.

(б) *Археологийн малтлага*

1999 оны II Протоколд нэгдэн орсон улс орнууд уг протоколд нэгдэн орсон өөр нэгэн улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн үед соёлын үнэт зүйлийг хадгалах, бүртгэх, хамгаалах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт ямар нэгэн археологийн малтлага хийхийг хориглож, урьдчилан сэргийлэх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй улсууд өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн тохиолдолд мөн энэ шаардлагыг биелүүлэх нь зүйтэй.

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт ямар нэгэн археологийн малтлага хийхдээ нөхцөл байдал зөвшөөрөхгүй байхаас бусад тохиолдолд тухайн газар нутгийн эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах ёстой.

(в) *Соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөх*

1999 оны II Протоколд нэгдсэн улс орнууд уг протоколд нэгэн орсон өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзлэх үед соёл, түүх, шинжлэх ухааны холбогдолтой эд зүйлийг нуун дарагдуулах, устгах зорилгоор соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөхийг хориглож, урьдчилан сэргийлэх ёстой.

1999 оны II Протоколд нэгдэн ороогүй улсууд өөр улсын газар нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн тохиолдолд мөн дагаж мөрдвөл зохино.

Соёлын үнэт зүйлийг хувиргах, зориулалтыг өөрчлөхөд нөхцөл байдал зөвшөөрөхгүйгээс бусад тохиолдолд эзлэгдсэн газар нутгийн эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах ёстой.

СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

A. А. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ЯЛГАН ТАНИХ АЖЛЫГ ХӨНГӨВЧЛӨХ ЗОРИЛГООР ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ

(i) Соёлын үнэт зүйл

Соёлын үнэт зүйлийг ялган таних ажлыг хөнгөвчлөх зорилгоор өмнө нь хэрэглэж байсан соёлын үнэт зүйлийн тэмдэглэгээ хэрэглэж болно.

(ii) Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйл

1954 оны Гаагийн Конвенцод нэгдсэн улс орнууд зэвсэгт мөргөлдөөний үеэр тусгай хамгаалалттай соёлын үнэт зүйлийг гурван удаа давтагдсан (гурвалжлуулан байрлуулахдаа нэг бамбайг нь доод эгнээнд байрлуулна) ялгах тэмдэг ашиглан ялган тэмдэглэнэ.

(iii) Соёлын үнэт зүйлийг тээвэрлэх

1954 оны Гаагийн Конвенцод нэгдсэн улсууд Зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийг шилжүүлэх үйл ажиллагаа эрхлэн зохион байгуулахад оролцох тээврийн хэрэгслийг гурван удаа давтагдсан (гурвалжлуулан байрлуулахдаа нэг бамбайг нь доод эгнээнд байрлуулна) ялгах тэмдэг ашиглан ялган тэмдэглэх ёстой.

(iv) Өргөтгөсөн хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлс

1999 оны II Протоколд Конвенцод нэгдэн орсон улсууд зэвсэгт мөргөлдөөний үед өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийг тусгайлан тэмдэглэхийг заасан.

Б. ЯЛГАХ ТЭМДЭГ БОЛОН БУСАД ТЭМДЭГЛЭГЭЭГ БУРУУ АШИГЛАХ

Зэвсэгт мөргөлдөөний үеэр соёлын үнэт зүйлийн ялгах тэмдгийг буруугаар ашиглахыг хориглоно.

Зэвсэгт мөргөлдөөний үед ямар ч зорилгоор ямар ч тохиолдолд соёлын үнэт зүйлийн өвөрмөц ялгах тэмдэгтэй төстэй тэмдэг ашиглахыг хориглосон.

СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ АЖИЛТАН

А. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ ХАМГААЛАХ АЖИЛТНЫГ ХҮНДЛЭХ

Соёлын үнэт зүйлийг хамгаалах ажилтныг аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн хүндэтгэх ёстой. Соёлын үнэт зүйлийг хамгаалах ажилтан болон тэдний хариуцаж буй эд зүйл нь мөргөлдөөнд оролцогч эсрэг талын гарт орсон тохиолдолд үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх эрхээр хангагдах ёстой.

Б. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ АЖИЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Соёлын үнэт зүйлийг хамгаалах ажилтан тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон, тамга тэмдэгтэй, соёлын үнэт зүйлийн ялгах тэмдэг бүхий ханцуйвч зүүж болно.

Тэд ялгах тэмдэг бүхий иргэний тусгай үнэмлэхийг биедээ авч явах ёстой. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тэдний иргэний үнэмлэх, ханцуйвч зүүх эрхийг хасаж болохгүй.

ХАВСРАЛТ II БҮРТГЭЛ, ЖАГСААЛТ

Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын бүртгэл

<https://en.unesco.org/node/341352>

Өргөтгөсөн хамгаалалтад байх соёлын үнэт зүйлийн олон улсын жагсаалт

<https://en.unesco.org/node/341353>

Дэлхийн өвийн жагсаалт

<http://whc.unesco.org/en/list/>


ХАВСРАЛТ III – ЯЛГАХ ТЭМДЭГ

СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ




сүүдэр = тод гүн цэнхэр

ГУРВАЛЖИН ХЭЛБЭРЭЭР ГУРВАН УДАА ДАВТСАН
СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ОНЦГОЙ ЯЛГАХ ТЭМДЭГ
(НЭГ БАМБАЙ ДООР НЬ)



сүүдэр = тод гүн цэнхэр

ӨРГӨТГӨСӨН ХАМГААЛАЛТ ДАХЬ СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН
ЯЛГАХ ТЭМДЭГ



доторх сүүдэр = тод гүн цэнхэр
гаднах сүүдэр = улаан

ДЭЛХИЙН ӨВИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ



ХАВСРАЛТ IV – ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭГДСЭН ЭРҮҮГИЙН ХЭРГҮҮД

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД

Нюрнбергийн Олон улсын цэргийн шүүх

Германы дайны гол гэмт хэрэгтнүүдийг шүүх олон улсын цэргийн шүүхийн шийдвэр, Нюрнберг, 1946 оны 9-р сарын 30, 10-р сарын 1, Misc № 12 (1946), Ctd 6964 (ээлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг устгах, завшсан дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдсан 4 этгээдэд ял оногдуулсан)

Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх

Прокурор Блашкич, IT-95-14-T, Шүүхийн танхим, 2000 оны 3-р сарын 3-ны өдрийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгах, завшсан дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял, IT-95-14-A, Давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2004 оны 7-р сарын 29, нэг хэргийнх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон)

Прокурор Кордич болон Черкез, IT-95-14/2-T, Шүүхийн танхим, 2001 оны 2-р сарын 26-ны өдрийн шүүхийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял, IT-95-14/2-A, Давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2004 оны 12-р сарын 17, нэг хэргийнх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг үл зөвшөөрсөн)

Прокурор Плавшич, IT-00-39&40/1-S, Шүүхийн танхим, 2003 оны 2-р сарын 27-ны өдрийн шийтгэх тогтоол (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор Налетилич болон Мартинович, IT-98-34-T, Шүүхийн танхим, 2003 оны 3-р сарын 31-ний өдрийн шүүхийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Стакич, IT-97-24-T, Шүүхийн танхим, 2003 оны 7-р сарын 31-ний өдрийн шүүхийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор Жокич, IT-01-42/1-S, Шүүхийн танхим, 2004 оны 3-р сарын 18-ны өдрийн шийтгэх тогтоол (Дубровникийн Хуучин хотын Дэлхийн өвд халдсан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор Деронжич, IT-02-61-S, Шүүхийн танхим, 2004 оны 3-р сарын 30-ны өдрийн шийтгэх тогтоол (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Бабич, IT-03-72-S, Шүүхийн танхим, 2004 оны 6-р сарын 29-ний өдрийн шийтгэх шийдвэр (Хорват дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор Брянин, IT-99-36-T, Шүүхийн танхим, 2004 оны 9-р сарын 1-ний өдрийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Стругар, IT-01-42-T, Шүүхийн танхим, 2005 оны 1-р сарын 31-ний өдрийн шийдвэр (Дубровникийн Хуучин хотын Дэлхийн өвд халдсан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор Хаджихасанович ба Кубура, IT-01-47-T, Шүүхийн танхим, 2006 оны 3-р сарын 15-ны өдрийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Krajišnik, IT-00-39-T, Шүүхийн танхим, 2006 оны 9-р сарын 27-ны өдрийн шүүхийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Мартич, IT-95-11-T, Шүүхийн танхим, 2007 оны 6-р сарын 12-ны өдрийн шүүхийн шийдвэр, (Хорват дахь соёлын үнэт зүйлийг устгах, гэмтээсэн дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Milutinović нар, IT-05-87-T, Шүүхийн танхим, 2009 оны 2-р сарын 26-ны өдрийн шүүхийн шийдвэр (хожим нь Прокурор v Šainović гэх болсон) (Косово дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Đorđević, IT-05-87/1-T, Шүүхийн танхим, 2011 оны 2-р сарын 23-ны шийдвэр (Косово дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор Станишич болон Жуплянин, IT-08-91-T, Шүүхийн танхим, 2013 оны 3-р сарын 27-ны өдрийн шүүхийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v Prlić, IT-04-74-T, Шүүхийн танхим, 2013 оны 5-р сарын 29-ний өдрийн шийдвэр (Мостар дахь Хуучин гүүр зэрэг Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял, үүнийг бичих үед хэрэг давж заалдах шатны шүүх дээр байсан)

Прокурор v Šešelj, IT-03-67-T, Шүүхийн танхим, 2016 оны 3-р сарын 31-ний өдрийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял, үүнийг бичих үед хэрэг давж заалдах шатны шүүх дээр байсан)

Прокурор Караджич, IT-95-5/18-T, Шүүхийн танхим, 2016 оны 3-р сарын 24-ний өдрийн шийдвэр (Босни-Герцеговина дахь соёлын үнэт зүйлийг устгасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх ял, үүнийг бичих үед хэрэг давж заалдах шатны шүүх дээр байсан)

Олон улсын эрүүгийн шүүх (ИСС)

Прокурор Аль-Махдиги, ICC-01/12-01/15-171, Шүүхийн танхим, 2016 оны 9-р сарын 27-ны өдрийн шүүхийн шийдвэр ба оногдуулсан ял (Мали дахь Дэлхийн өвд бүртгэгдсэн бунхан зэрэг соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД

Карл Лингенфельдерийн шүүх хурал, 1947 оны 3-р сарын 11, Мец, Цэргийн шүүх, 9 Дайны гэмт хэрэгтнүүдийн шүүх хурлын тухай хуулийн тайлан 67 (эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг устгасан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)

Прокурор v УИХ-ын гишүүн, Задар дүүргийн шүүх, К 74/96, 1997 оны 7-р сарын 24 (Задарын түүхийн төв, Гэгээн Донатиусын Романескийн өмнөх сүм, Гэгээн Анастасиягийн Романескийн сүмд халдсан дайны гэмт хэрэг үйлдсэн гэх ял)



Ирак, Сири, Ливи, Йемен, Мали зэрэг улсуудад өрнөсөн сүүлийн үеийн мөргөлдөөн, олон тооны цэргийн эзлэн түрэмгийллүүд нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах олон улсын эрх зүйн хэм хэмжээг практикт хэрэгжүүлэх шаардлагатай байгааг дахин харуулж байна.

Эдгээр дүрмийг хэрэгжүүлэхэд цэргийн хүчинд тус болох нь энэхүү гарын авлагын зорилго юм. Уг гарын авлагад цэргийн ажиллагаатай холбоотой төр, иргэний хүлээх үүргийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт болон командлалын хийгээд хуурай зам, тэнгисийн болон агаарын цэргийн ажиллагааны өөр өөр үе шатуудад авч хэрэгжүүлэх шилдэг туршлагын талаарх саналуудыг нэгтгэн оруулав.

